



УДИРЛАГЫН
АКАДЕМИ

**ӨРХИЙН ЭДИЙН ЗАСАГТ
ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН
ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН
051

Улаанбаатар хот
2025 он

ӨРХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад хэлбэрээр олшруулахыг хориглоно.

Судалгааны удирдагч:

Баатаржавын Нарантулга Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор

Судлаачид:

Чогдонгийн Эрдэнэчимэг Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн профессор, доктор, дэд профессор

Бавуудоржийн Ганзориг Удирдлагын академийн Эдийн засаг, санхүүгийн удирдлагын тэнхимийн ахлах багш, докторант

Сандагдоржийн Ганцэцэг Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант

Баатарцогтын Энхболор Нийгмийн даатгалын ерөнхий газрын судалгаа, тооцооллын хэлтсийн мэргэжилтэн

Лхаасүрэнгийн Ариунболд Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн багш, докторант

Батсүхийн Батчимэг Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн ажилтан, докторант

Арилдал ХХК-д хэвлэв.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	V
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	VI
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	IX
ӨМНӨХ ҮГ	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ	3
1.1. Судалгааны асуудал	3
1.2. Судалгааны зорилго	6
1.3. Судалгааны асуулт	6
1.4. Судалгааны шинэлэг тал, ач холбогдол	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ	7
2.1. Өндөр насны тэтгэврийн талаарх онол, хандлага	7
2.2. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн нөлөөллийг тодорхойлох онол, арга зүй	12
2.3. Судалгааны үзэл баримтлал	25
2.4. Судалгааны таамаглал	26
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	27
3.1. Судалгааны төрөл	27
3.2. Өгөгдлийн эх сурвалж	27
3.3. Эх олонлог, түүвэр	27
3.4. Хувьсагч, хэмжүүр	29
3.5. Өгөгдөл цуглуулах арга	30
3.6. Өгөгдөл шинжлэх арга	31
3.7. Онч, найдвартай байдал	32
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	33
4.1. Өндөр насны тэтгэвэр, нөлөөлж буй хүчин зүйл	33
4.2. Өндөр насны тэтгэврийн талаарх үнэлгээ, сэтгэл ханамж	51
4.3. Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөө	65
4.4. Өрхийн зардалд өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөө	82
4.5. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг дээшлүүлэхэд анхаарах асуудал	109

ТАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ	117
5.1. Дүгнэлт	117
5.2. Санал	121
5.3. Судалгааны хязгаарлалт	123
НОМ ЗҮЙ	124
ХАВСРАЛТ	131
Хавсралт 1. Санал асуулгын хуудас	131
Хавсралт 2. Иргэнтэй хийх ярилцлагын удирдамж	138
Хавсралт 3. Мэргэжилтэнтэй хийх ярилцлагын удирдамж	140
Хавсралт 4. Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо, хувь, аймаг, дүүргээр (2023 он)	142

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуй нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗГ	Засгийн газар
МАА	Мал аж ахуй
НДГ	Нийгмийн даатгалын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДҮХ	Нийгмийн даатгалын үндэсний хороо
НСХ	Нийгмийн судалгааны хүрээлэн
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгуулга
ОХУ	Оросын Холбооны Улс
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЭМНДЕГ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны үзэл баримтлалын зураглал	25
Зураг 2. Ярилцлагын өгөгдөлд хамрах хүрээний шинжилгээ хийсэн алхам	31
Зураг 3. Өндөр насны тэтгэвэр авагчдын нас, хүйсийн суварга	34
Зураг 4. Өндөр насны тэтгэвэр авагчдын бүтэц, тэтгэврийн төрлөөр	34
Зураг 5. Доод хэмжээний тэтгэвэр авч байгаа даатгуулагчдын хувь, тэтгэвэр тогтоолгосон нөхцөлөөр	38
Зураг 6. Өндөр насны тэтгэврийн хэмжээнд нөлөөлж буй хүчин зүйл	39
Зураг 7. Дундаж тэтгэврийн хэмжээ, насны бүлэг ба хүйсээр	40
Зураг 8. Дундаж тэтгэврийн хэмжээ, тэтгэврийн төрөл ба тэтгэвэрт гарсан нөхцөлөөр	42
Зураг 9. Дундаж тэтгэврийн хэмжээ, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон тэтгэвэрт гарсан оноор	44
Зураг 10. Дундаж тэтгэврийн хэмжээ, нийгмийн даатгалын төрөл болон тэтгэвэрт гарах үеийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар	46
Зураг 11. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Засгийн газрын тогтоолын тойм, сүүлийн 5 жилээр	48
Зураг 12. Бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ (мян. төгрөгөөр) 2010–2025 он	49
Зураг 13. Тэтгэврийн нэмэгдэл, өсөлтийн хувиар 1997–2024 он, өмнөх онтой харьцуулсан дүнгээр	49
Зураг 14. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн шинэчлэл	50
Зураг 15. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын үнэлгээ, хувиар	52
Зураг 16. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын үнэлгээ, даатгалын хэлбэрээр, хувиар	54
Зураг 17. Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал, хувиар	56
Зураг 18. Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал, байршил, хувиар	56
Зураг 19. Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал, нийгмийн даатгалд хамрагдалтаар, хувиар	57

Зураг 20. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын ойлголт, үзэл бодол	59
Зураг 21. Өндөр насны тэтгэврийн хэмжээний талаарх мэргэжилтнүүдийн үзэл бодол	60
Зураг 22. Өндөр насны тэтгэвэрт гарснаар өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлтийн үнэлгээ, хувиар	62
Зураг 23. Өндөр насны тэтгэврийн өрхийн амьжиргаанд үзүүлж буй нөлөө, хувиар	63
Зураг 24. Өрхийн сарын дундаж орлогын түвшин, байршлаар	66
Зураг 25. Судалгаанд хамрагдсан өрхийн орлогын гол эх үүсвэр, хувиар	67
Зураг 26. Өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь, орлогын бүлгээр	68
Зураг 27. Өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь, байршлаар	70
Зураг 28. Өрхийн орлогоос хуримтлуулдаг эсэх, хувиар	71
Зураг 29. Тэтгэврийн орлогоос сар бүр хуримтлал хийдэг өрхийн хувь, байршил болон хариулагчийн боловсролын түвшнээр	72
Зураг 30. Сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх, хувиар	74
Зураг 31. Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл өрхийн хэрэглээнд нөлөөлсөн байдал, хувиар	77
Зураг 32. Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл сэтгэл санаанд нөлөөлсөн байдал, хувиар	78
Зураг 33. Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлийг үр дүнтэй зарцуулсан эсэх	78
Зураг 34. Өндөр насны тэтгэврийн өрхийн хэрэгцээнд зарцуулагдах байдал, хувиар	82
Зураг 35. Нийтийн ба хувийн зардалд зарцуулах тэтгэврийн зарцуулалтын хувь, хүйсээр	83
Зураг 36. Нийтийн ба хувийн зардалд зарцуулах тэтгэврийн зарцуулалтын хувь, байршлаар	84
Зураг 37. Тэтгэврийн орлогын зарцуулалт, нийтийн ба хувийн зардлын төрөл, он, хувиар	85
Зураг 38. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд зарцуулах үзүүлэлт, төгрөгөөр	86

Зураг 39. Өндөр настны хувийн зардал, хүйс, төгрөгөөр	87
Зураг 40. Өндөр настны хувийн зардал, байршил, төгрөгөөр	88
Зураг 41. Өндөр настны хувийн зардал, насны ангилал, төгрөгөөр	89
Зураг 42. Өндөр настны хувийн зардал, өрхийн ам бүлийн тооны ангилал, төгрөгөөр	90
Зураг 43. Тэтгэврийн орлогоос бусдад дэмжлэг үзүүлдэг эсэх, хувиар	92
Зураг 44. Өндөр насны тэтгэврээс дэмжлэг үзүүлдэг субъект, хувиар	92
Зураг 45. Өндөр насны тэтгэврийн орлогоос бусдад үзүүлж буй дэмжлэгийн давтамж, хувиар	93
Зураг 46. Тэтгэврийн орлогоос бусдад дэмжлэг үзүүлдэг өрхийн хувь, ам бүлийн тоо болон байршлаар	93
Зураг 47. Өндөр насны тэтгэврээс ач, зээдээ зарцуулдаг байдал, хувиар	94
Зураг 48. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, хувиар	96
Зураг 49. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, сарын дундаж тэтгэврийн хэмжээ, төгрөгөөр	97
Зураг 50. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, тэтгэвэр тогтоолгосон оноор, хувиар	98
Зураг 51. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, хүйсээр, хувиар	99
Зураг 52. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, насны ангиллаар, хувиар	100
Зураг 53. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, орон сууцны төрлөөр, хувиар	101
Зураг 54. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, байршлаар, хувиар	102
Зураг 55. Тэтгэврийн орлогын зарцуулалт, нийтийн ба хувийн зардлын төрөл, он, хувиар	103
Зураг 56. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг дээшлүүлэхэд анхаарах асуудлын талаарх саналын нэгтгэл, хувиар	109

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Өрхийн зардлын хуваарилалт	21
Хүснэгт 2. Өрхийн орлогын хуваарилалт	22
Хүснэгт 3. Өрхийн зардлын хуваарилалт, гишүүдийн сонирхол, хэрэгцээ шаардлагын төрлөөр	23
Хүснэгт 4. Судалгааны түүврийн мужлалт	27
Хүснэгт 5. Судалгааны түүвэр, сонгогдсон аймаг, дүүргээр	28
Хүснэгт 6. Судалгааны хувьсагч, хэмжүүр	29
Хүснэгт 7. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авдаг иргэдийн тоо, 2020–2024 оноор	33
Хүснэгт 8. Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо, хүйс ба тэтгэвэр тогтоолгосон нөхцөлөөр	35
Хүснэгт 9. Сарын дундаж тэтгэврийн хэмжээ, төгрөгөөр	37
Хүснэгт 10. Санал асуулгын судалгаанд хамрагдагчдын шинж байдал, тоо ба хувиар	51
Хүснэгт 11. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын үнэлгээ (хувь), байршил ба тэтгэврийн төрлөөр	53
Хүснэгт 12. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын үнэлгээ (хувь), хүйсээр	55
Хүснэгт 13. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын үнэлгээ, боловсролын түвшин, хувиар	55
Хүснэгт 14. Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал, насаар	58
Хүснэгт 15. Өндөр насны тэтгэвэрт гарснаар өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт, насны бүлгээр	63
Хүснэгт 16. Өндөр насны тэтгэврийн өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөөний талаарх үнэлгээ (хувь) шинж байдлын зарим үзүүлэлтээр	64
Хүснэгт 17. Судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж орлогын хэмжээ, бүлэглэсэн байдлаар	65
Хүснэгт 18. Өрхийн сарын дундаж орлогын хэмжээ, өрхийн шинж байдлаар	66
Хүснэгт 19. Өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь, өрхийн ам бүлийн бүтцээр	69
Хүснэгт 20. Судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж хуримтлалын бүлэглэсэн хэмжээ, тоо болон хувиар	73

Хүснэгт 21. Сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх, хариулагчийн нас, хүйсээр, хувиар	74
Хүснэгт 22. Сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх, байршлаар	75
Хүснэгт 23. Сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх, тэтгэвэрт гарах үеийн нийгмийн даатгалын төрлөөр, хувиар	75
Хүснэгт 24. Амьжиргааны доод түвшин болон тэтгэвэр, цалингийн хэмжээ	110

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг зорьж буй Монгол Улсын хувьд төрийн бодлого, шийдвэрийн үр дүн нь өрх, иргэдийн амьжиргаа, амьдралын чанараар хэмжигдэх учиртай. Ахмад настнуудын нийгмийн хамгааллын гол арга хэрэгсэл болох өндөр насны тэтгэвэр нь тухайн ахмад настанд төдийгүй өрхөд ямар нөлөө үзүүлж байгааг судалснаар нийгмийн даатгалын бодлого, тогтолцоог бодитоор дүгнэх боломж бүрдэнэ.

Монгол Улсад нийгмийн даатгалын тогтолцоонд үл итгэх хандлага давамгайл, өндөр насны тэтгэврийн хэмжээ бага, хүрэлцээт байдал хангалтгүй гэсэн ойлголт түгээмэл байгаа энэ үед Нийгмийн Даатгалын Ерөнхий Газраас “Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөө” сэдэвт судалгааг гүйцэтгүүлэх захиалга өгсөн нь цагаа болсон ажил юм. Удирдлагын академийн судалгааны багаас 2019 онд хэрэгжүүлсэн “Өндөр насны тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал” сэдэвт судалгааны тайланд тэтгэврийн тогтолцооны хүрэлцээт байдлыг тухайлан судлах шаардлагатай талаарх дүгнэсэн нь дээрхтэй уялдаж байна.

Орчин цагт өрхийг эдийн засгийн суурь институц хэмээн үзэж, өрхийн эдийн засгийг орлого, зардал гэсэн үндсэн орчил хөдөлгөөний хүрээнд авч үзэж байгааг “Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөө” сэдэвт судалгаанд эш үндэс болгов. Түүнчлэн өндөр насны тэтгэврийн хувь хүн, өрхөд үзүүлж буй нөлөөг тоон үзүүлэлтээс гадна өөрийн үнэлгээнд суурилан тодорхойлж байгааг харгалзсан болно.

Та бүхэнд судалгаатай холбоотой санал, зөвлөмж байвал Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимд d_pubman@naog.gov.mn имэйлээр ирүүлнэ үү.

Судалгааны баг

1.1. Судалгааны асуудал

Өндөр насны тэтгэвэр нь ахмад настнуудын ядуурлыг бууруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэрэгсэл төдийгүй эдийн засаг болон нийгмийн баталгаа болохын хувьд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг тул Монгол Улсын Засгийн газраас энэ чиглэлд онцгойлон анхаардаг. Тухайлбал, амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх (“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020), өндөр настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бий болгох (Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, 2015), нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, улмаар олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх (Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024) чиглэлээр Засгийн газраас урт, дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн ч хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээнүүд нь зорилтдоо бүрэн чиглээгүй, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээтэй бүрэн уялдахгүй байна (Үндэсний аудитын газар, 2024).

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын 102 дугаар конвенцод өндөр насны тэтгэврийн хэмжээг цалин, орлогын хамгийн багадаа 40 хувийг нөхөхүйц байхаар тооцохыг зөвлөмж болгосон. Бодит байдалд манай улсад өндөр насны тэтгэвэр нь дундаж цалингийн 40 хүрэхгүй хувийг нөхдөг нь (ОУХБ, 2023) тэтгэвэр авагчдын талаас илүү хувь нь тэтгэврийн хүрэлцээт байдалдаа сэтгэл ханамжгүй байх нөхцөл болдог (Удирдлагын академи, 2019).

“Дэлхийн нийгмийн хамгааллын тайлан 2024–2026”-д Монгол Улс нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулах, хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн олон хөтөлбөр, үйлчилгээг хэрэгжүүлж ирсэн ч эдгээрийн хамрах хүрээг зохистой болгох, үр ашиг, үр нөлөөг сайжруулах шаардлагатай хэмээн дурджээ. Улмаар нийгмийн даатгалын үйлчилгээний ‘гадна’ байгаа иргэдийн тоог эрчимтэй бууруулж, тогтолцооны хамрах хүрээг

өргөжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх нь ядуурлыг бууруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх гол хөшүүрэг болохыг онцолжээ (ILO, <https://www.ilo.org/>, 2024). Иймээс өндөр насны тэтгэврийн хүрэлцээт байдал, өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхойлох хэрэгцээ урган гарч байна.

Өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа, тэтгэвэрт гарах нас, тэтгэвэр бодох хувь хэмжээг салбарын шинжтэй зарим хуулиудад нийгмийн даатгалын талаарх хууль тогтоомжоос ялгаатай байдлаар тусгайлан зохицуулж байгаа (Үндэсний аудитын газар, 2024) нь өндөр насны тэтгэврийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудал болж байна. Түүнчлэн шаардлагатай санхүүжилтийг шийдээгүй атал тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх, хувь хэмжээг бууруулах, тэтгэвэрт гарах нөхцөлийг хөнгөлөх зэрэг гэнэтийн шийдвэрүүд гаргасан нь иргэдэд таатай хэдий ч нийгмийн даатгалын санд ачаалал үүсгэж, 7.3 наяд төгрөгийн алдагдалд оруулсан байна (Үндэсний аудитын газар, 2024). Иймд өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлж буй нөлөөг хууль, эрх зүйн хүрээнд судалснаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах, тэтгэврийн шинэчлэлийн стратегийг оновчтой боловсруулахад ач холбогдолтой.

Өндөр насны тэтгэврийн шинэчлэлийн талаар баримталж буй бодлогын үр дүнг “тэтгэврийн хүрэлцэхүйц/зохистой хэмжээ” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд, өндөр насны амьжиргаанд хүрэлцэхүйц, ядуурлаас сэргийлж чадахуйц хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлсэн байдлаар тодруулах шаардлагатайг олон улсын байгууллага, судлаачид онцлох болов. Монгол Улс тэтгэврийн өмнөх орлогыг нөхөх түвшнээр Ази, Номхон далайн бүсийн ихэнх улстай (60–75%) харьцуулахад доогуур түвшинд байна. Улмаар өндөр насны тэтгэвэр болон нийгмийн хамгааллын үйлчилгээг бүхэлд нь багтаасан насжилтын хяналтын индекс (Global age watch index)-ээр манай улс дэлхийн 113 улсаас 74-р байранд эрэмбэлэгдсэн нь анхаарал татаж байна (Help Age International, 2021).

Монгол Улсад 60-аас дээш насны хүн амын тоо нийт хүн амын тооны өсөлттэй харьцуулахад илүү хурдацтай нэмэгдсэн. Хэтийн тооцоогоор 2050 он хүртэлх хугацаанд насжилт илүү хурдтай явагдах төлөв ажиглагдаж байна. 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 401,421 хүн өндөр насны тэтгэвэр авч байгааг 2023 оны мөн үетэй харьцуулахад даруй (382.8) 18.6 мянган хүнээр нэмэгджээ. Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлын 80.7 хувь буюу 1,158.1 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 393.0 мянган хүний тэтгэвэрт зарцуулсан (НДЕГ, 2024 он) байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зардлын өсөлт, алдагдал, сангийн менежментийн хангалтгүй байдал нь иргэдийн өндөр насны тэтгэврийн даатгалд итгэх итгэл алдрахад нөлөөлж, нийгмийн даатгалын хамрах хүрээ хумигдах хандлага ажиглагдах болов. 2024 оны 11 дүгээр сард Үндэсний аудитын газраас “Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө” нийцлийн аудитын тайлангийн хүрээнд явуулсан санал асуулгын судалгаанаас үзэхэд, судалгаанд хамрагдагчдын 37 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл нь цалингаас шууд суутгадаг, үр ашиггүй зардал гэсэн байр суурьтай байна. Үүнтэй уялдуулан өндөр насны тэтгэврийн үр дүнг өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөөгөөр жишээлэн судалж, нотолгоонд суурилсан мэдээ мэдээллийг тохиромжтой сувгаар түгээж, иргэдийн тэтгэврийн даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлэх тулгамдсан хэрэгцээ байна.

Олон улсын түвшинд өндөр насны тэтгэвэр нь өрхийн түвшинд төдийгүй хэрэглээгээр дамжин бизнес эрхлэгчдийг дэмжих, ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой мөнгөний урсгал бий болоход нөлөөлж, орон нутгийн болон улс орны эдийн засагт шууд болон дам байдлаар нөлөөлдгийг нотолсон судалгаанууд олон бий (National Institute on National Security, 2010). Монгол улсад энэ чиглэлийн судалгаа өндөр насны тэтгэврийг тогтолцоо талаас нь судалсан цөөн тооны судалгаагаар хязгаарлагдаж байна. Ийнхүү өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөөг тухайлан судалсан судалгааны ажил өнөөг хүртэл хийгдээгүй тул энэхүү орон зайг нөхөх, энэ чиглэлийн судалгааны цар хүрээг нэмэгдүүлэх нь нийгмийн бодлого судлаачдын анхаарах шаардлагатай талбар юм.

2025 оны 1 дүгээр сарын байдлаар өндөр настнуудын 60 гаруй хувь нь тэтгэврийн зээлтэй гэсэн тооцоо гарчээ (Өндөр насны үндэсний чуулган, 2025 оны 1 дүгээр сарын 8). Монгол Улсын хувьд гэр бүл, үр хүүхдүүд, хамаатан садны хэлхээ холбоо нийгмийн чухал капитал болдгийн хувьд тэтгэвэр барьцаалсан зээл нь бусдын (гол төлөв хүүхдүүд) орон сууцны нөхцөлөө сайжруулах, сургалтын төлбөр төлөх, машин худалдан авах, бизнес эрхлэх, зарим тохиолдолд хэрэглээний шинжтэй зүйлийн санхүүгийн эх үүсвэр болдог (Удирдлагын академи, 2019). Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл нь өрхийн дутагдсан орлогыг нөхөх эх үүсвэрийн хувьд зээл авч буй зорилго, зээлийн зарцуулалт, түүний үр дүн, үр дагаврыг тодруулж, өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөөг тодруулах хэрэгцээ байна.

Дээр дурдсан асуудал нь өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх үр нөлөөг судалж, дүгнэлт, санал боловсруулах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

1.2. Судалгааны зорилго

Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг хүн ам зүй болон бодлого, эрх зүйн хүчин зүйлтэй уялдуулан судалж, холбогдох санал боловсруулах зорилготой.

1.3. Судалгааны асуулт

1. Өрхийн орлогод өндөр насны тэтгэвэр ямар нөлөө үзүүлж байна вэ?
2. Өндөр насны тэтгэвэр нь тухайн ахмад настны хувийн хэрэгцээнд хүрэлцэж байна уу?
3. Байршлаас хамаарч өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөө ялгаатай байна уу?

1.4. Судалгааны шинэлэг тал, ач холбогдол

Өндөр насны тэтгэврийн эдийн засагт үзүүлэх нөлөөг өрхийн түвшинд тодорхойлсон судалгааны эх сурвалж бүрдэнэ. Судалгаанаас гарсан дүгнэлт, санал нь холбогдох хуулийн зүйл, заалтыг өөрчлөх, улмаар өндөр настанд ээлтэй бодлогын хэрэгжилтийг сайжруулах суурь болж ашиглагдана.

Удирдлагын академийн сургалт, судалгааны уялдаа холбоог сайжруулах хүрээнд төрийн албаны мэргэшүүлэх багц сургалт болон доктор, магистрын зэрэг олгох сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан Нийгмийн бодлого R326, Нийгмийн хөгжил 719-1, Нийгмийн салбарын бодлого 727-1, Улсын салбарын менежмент 705, Улсын салбарын удирдлага, шинэчлэл FPM 805 зэрэг хичээлд бодит жишээ, кейс байдлаар судалгааны үр дүнг ашиглах боломжтой.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

2.1. Өндөр насны тэтгэврийн талаарх онол, хандлага

Өндөр насны тэтгэвэр нь нас ахиснаас шалтгаалж бие эрхтний болон биологи, физиологийн чадавх нь буурч, улмаар хөдөлмөр эрхлэх, орлого олох боломж хязгаарлагдаж эдийн засгийн эрсдэлд өртсөн үед орлогын бууралтыг нөхөх нийгмийн хамгааллын үндсэн хэрэглэгдэхүүн болдог. Өөрөөр хэлбэл, тухайн улсын хууль тогтоомжид заасан өндөр насны тэтгэврийн болзлыг хангасан, нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хугацаанд төлсөн иргэдэд тэтгэвэрт гарснаас эхлэн насан туршид нь олгодог мөнгөн хөрөнгийг өндөр насны тэтгэвэр гэнэ (Л.Мөнхзул, Б.Батжаргал ба бусад, 2017; Дагвадорж, 2004).

Нийгмийн гэрээний онол (Social Contract Theory)-ын үзэл санаа нь ард иргэдийн нийтийн эрх ашгийг тэнцвэртэй хангахуйц чадвар бүхий төлөөллийн байгууллагаар дамжуулан улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх нь оновчтой болохыг илэрхийлсэн гүн утгыг агуулдаг. Өөрөөр хэлбэл, ард иргэдийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагын хүрээнд авч үзвэл төрийн үндсэн чиг үүрэг бол иргэдийг амьдрах наад захын нөхцөл, боломжоор хангах явдал юм. Энэхүү онолын суурийг Английн философич Томас Хоббс, Жон Локк, Францын философич Жан-Жак Руссо нар бүтээлүүддээ дэвшүүлсэн гэж үздэг (Kohler, 2014). Европын Соён гэгээрлийн үеийн гол сэтгэгч, философич, улс төрийн онолч Жан-Жак Руссо (1712–1778) өндөр насыг байгалийн жам ёсны дагуу залуу наснаас эрс ялгаатайг онцлоод, нас ахих тусам хүний хүсэл, эрч хүч буурч, амар амгалан, дотоод сэтгэлийн тогтвортой байдал бий болдог. Нөгөөтээгүүр, наслах тусмаа хүн нийгмээс гадуурхагдан тусгаарлагддаг бөгөөд (Rousseau, 1979) орлогын хүрэлцээгүй байдлаас үүссэн эдийн засгийн асуудлууд байгааг бодитоор авч хэлэлцэх ёстой (Beauvoir, 1972). Өндөр настнуудын нийгмээс тусгаарлагдах хандлага нь нийгэм дэх тэдний үнэлэмж, ач холбогдлыг бууруулж байгааг Францын философич Симон де Бэйвуар (1908–1986) шүүмжлээд, нийгмийн байр суурь нь өндөр настны эдийн засгийн идэвх, бүтээмжээс хамаардаг гэжээ. Түүнийхээр, өндөр нас бол эмгэнэл биш, амьдралын нэг онцгой үе шат бөгөөд түүний утга учир, үнэ цэнийг ойлгож, нийгэм, сэтгэл зүйн дарамтаас ангид байлгах нь хүн төрөлхтний ёс суртахууны үүрэг (Beauvoir, 1972) хэмээн тодорхойлсон. Грекийн философич Платон (МЭӨ 427–347) өндөр насанд хүний хэрэгцээ буурч, амьдралын сэтгэл ханамжийг арай өөрөөр хардаг.

Тэдний мэргэн ухаан, хуримтлуулсан туршлага, ёс суртахууны талаарх ойлголт нь нийгэмд ихээхэн үнэ цэнтэй болохыг онцолжээ (Plato, 1992).

Германы философич, эдийн засагч, улс төрийн онолч Карл Маркс (Karl Marx, 1818–1883) нийгмийн хөгжил, үйлдвэрлэлийн харилцаа болон ангич тэмцлийн үзэл санаандаа өндөр настнууд нийгмийн үйлдвэрлэлийн процессыг хамтран бүтээлцэж байсан гэх утгаараа тэтгэвэрт гарсны дараа өөрсдийн залуу насны хөдөлмөрийн үнэ цэнийг бүрэн хүртэх боломжгүй нь тэдний амьдралын чанар, нийгмийн үнэлэмжийг бууруулж байгаад шүүмжлэлтэй хандсан байдаг (Marx, 1867). Түүнчлэн, эдийн засгийн харилцаа, хөдөлмөрийн хуваарилалтаас үүдэн өндөр настнуудыг ажиллах хүчинд тооцохгүй тул тэд ажилгүй болж улмаар нийгмийн идэвхгүй болдог (Marx, 1867) талаарх санааг дэвшүүлсэн.

Германы эзэнт гүрний Канцлер Отто Фон Бисмарк 1889 онд өндөр насны тэтгэврийн анхны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн нь дэлхий нийтэд нийгмийн даатгалын тогтолцооны эхлэлийг тавьсан гэж үздэг. Түүний санаачилга анх 1881 онд Германы хаан Вилгельм I-ийн парламентад хандаж бичсэн "...өндөр насанд хүрч хөдөлмөрлөх чадваргүй болсон иргэд улсаас тэтгэмж хүсэх бүрэн эрхтэй гэж би үзэж байна..." гэсэн агуулга бүхий захидлаас үүдэлтэй (Б.Үүрцайх, 2018). Тухайн үеийн Германы эдийн засгийг дээд зэргийн үр ашигтай хөгжүүлэх, бүтээмжтэй, мэргэшсэн ажиллах хүчнийг дэмжих зэрэг бодлогод суурилсан нийгмийн даатгалын тогтолцоог Бисмарк танилцуулж байсан. Уг тогтолцоо нь нийгмийн даатгалын санг бүрдүүлэхэд ажилтан, ажил олгогч, Засгийн газрын оролцоо, тэдгээрийн чиг үүргийг хамаарч байв.

Германы эзэнт гүрэнд Отто Фон Бисмаркийн үүсгэл санаачилгаар 1883–1889 онд Эрүүл мэндийн даатгалын хууль, Үйлдвэрлэлийн ослын даатгалын хууль, Тэтгэврийн даатгалын хууль батлагдан хэрэгжиж, тухайн үедээ ажилчид, ажил олгогч, төр гурвын орлогоос санхүүждэг даатгалын тогтолцоогоор дамжуулан ажилчдын эрүүл мэндийн болон үйлдвэрлэлийн ослын асуудлыг хэрхэн шийдвэрлэх, ажилчин өндөр настан болсон үед амьдралын баталгааг нь хэрхэн хангах зэрэг чухал асуудлыг шийдвэрлэхийг зорьсноороо тун шинэлэг үзэгдэл болсон ба Бисмаркийн тогтолцоо хэмээн нийтэд түгсэн байна (Bortz, 2022). Тухайн үеийн Герман улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь тэтгэврийн болон хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжээс бүрдэж байсан бол хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал, ослын даатгалын хөтөлбөрүүдийг 1883–1884 онд нэгтгэж, нийгмийн даатгалын үндсэн зарчмуудын нэг орлогод суурилсан иж бүрэн нийгмийн даатгалын сангийн тогтолцоог нэвтрүүлжээ. Энэхүү тогтолцоонд ажилгүйдлийн даатгалыг 1927 онд нэмсэн нь бусад улс орнуудад жишиг

тогтоож, нийгмийн даатгалын орчин үеийн тогтолцоо үүсэх үндсэн хүчин зүйл болсон (Б.Үүрцайх, 2018). Герман улсын сайн туршлагыг XIX зууны сүүл XX зууны эхээр тухайн үеийн Австри, Англи, Швед, Франц зэрэг улсууд нэвтрүүлсэн нь өнөөгийн нийгмийн хамгааллын тогтолцооны дүр зургаа олсон юм. АНУ-ын хувьд 1935 онд Нийгмийн хамгааллын тухай хууль баталж, өндөр насны тэтгэвэр, ажилгүйдлийн тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тогтолцоог нэвтрүүлжээ.

Дэлхийн II дайны дараачаас нийгмийн даатгалын тогтолцоог дэлхийн улс орнууд бүх нийтийг хамарсан байдлаар хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж эхэлсэн. Улмаар, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хамгааллыг хэрэгжүүлэх зарчим, стандартыг тогтоон албажуулж өгснөөр нийгмийн даатгал нь хүн төрөлхтний хийгээд улс орнуудын хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болж өдийг хүрчээ.

Эдийн засаг, нийгмийн хурдацтай хөгжил, хүн амын насжилт, хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэл зэрэг цаг үеийн нөхцөл байдалтай уялдан өндөр насны тэтгэврийн тогтолцоонд томоохон сорилт, бэрхшээл тулгарсаар байна. Хувьсан өөрчлөгдөх эдийн засаг, нийгмийн аливаа үзэгдэлтэй уялдуулан өндөр настны нийгмийн баталгааг хангах, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн тогтолцооны шалгуурыг тодорхойлох оролдлогууд хийгдэх болсон. Дэлхийн банкнаас өндөр настанд тулгарах эрсдэлийг бууруулсан ээлтэй тогтолцоо нь дараах шалгуурыг хангасан байх шаардлагатай хэмээн тодорхойлжээ (World Bank, 2008). Үүнд:

1. Зохистой хэмжээ
2. Санхүүжүүлж чадахуйц байдал
3. Тэгш байдал
4. Урьдчилан таамаглахуйц байдал
5. Тогтвортой байдал
6. Тэсвэртэй байдал зэрэг багтана (World Bank, 2008).

ОУХБ (ILO), Дэлхийн банк, ЭЗХАХБ, Европын комисс зэрэг олон улсын байгууллагууд өндөр насны тэтгэврийн шинэчлэлийн талаар баримталж буй бодлогын үр дүнг “тэтгэврийн хүрэлцэхүйц байдал буюу зохистой хэмжээ” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд судлан үзэх нь зүйтэй хэмээн зөвлөдөг. Учир нь тэтгэврийн тогтолцооны эцсийн зорилго зөвхөн сангийн тогтвортой байдал, санхүүжилтийг анхаарах бус гол нь ахмад настуудын амьжиргааны зохистой түвшинг хамгаалахад чиглэдэг. НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (United Nations, 1948), Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 102 дугаар конвенц болох “Нийгмийн хамгааллын доод хэмжээний стандарт”

(ILO, 1952) зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан “хүн бүр өндөр насандаа зохистой амьдрах эрхтэй” болохыг тунхагласан.

Эндээс, судлаач Роберт Холзман, Иан Мак Артур нар тогтвортой байдал, тэгш шударга байдал, зохистой байдлыг өндөр насны тэтгэврийн тогтолцооны суурь шалгуур болгон авч үзсэн. *Тогтвортой байдал* нь хүн ам зүйн бүтэц, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан өндөр настнуудад өндөр насны тэтгэвэр олгох санхүүгийн чадавхаар тодорхойлогдоно. *Тэгш, шударга байдалд* хүний хөгжил, амьдралын чанарын үндсэн тулгуур нь тэгш эрх, адил боломж хэмээн үзнэ. Нийгмийн хамгаалалд эв санааны зарчмыг суурь болгож байгаа энэ цаг үед өндөр насны тэтгэвэртэй холбогдох ялгаатай болон зөрүүтэй байдлыг хамруулан үнэлнэ. *Зохистой байдалд* өндөр насны тэтгэвэр нь тэдний амьжиргааны баталгааг хангаж байгаа эсэхээр тодорхойлогдоно (Holzman. Mac Arthur, 2009). Австралийн Монаш их сургуулийн, Санхүү судлалын төвийн судлаачид хүрэлцээт байдал, тогтвортой байдал, тэгш байдал гэсэн гурван гол шалгуур бүхий тэтгэврийн тогтолцооны индексийг боловсруулсан. Энэхүү индексийг дэлхийн улс орнууд тэтгэврийн тогтолцоонд үнэлгээ өгч, харьцуулалт хийхэд ашиглаж байна.

Судлаачид Монгол Улсын өндөр насны тэтгэврийн тогтолцоог хүрэлцээт байдал, тогтвортой байдал, тэгш шударга байдал гэсэн шалгуурын хүрээнд судлан, амьжиргаанд хүрэлцэхүйц байж чадахгүй байгааг онцолжээ (Удирдлагын академи, 2019). Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл нь иргэдийн амьдралын чанар, эрүүл мэндийн хамгаалалт, орлогын тэгш бус байдлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна (НДЕГ, 2020). Удирдлагын академийн судлаачдын боловсруулсан “Өндөр насны тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал” судалгаанд хүрэлцээтэй байдал гэсэн шалгуурын хүрээнд өндөр насны тэтгэврийн хэмжээ, хүрэлцээт байдлыг судалсан.

Монгол Улсын нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрхэн хийх, санхүүгийн тэгш байдал, ил тод байдлыг хангах, иргэдийн бодит хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлэх талаар судлаачид санал болгожээ (ЗГ, НДЕГ, 2018). Судлаачид, эрх зүйн орчинд хийсэн шинэчлэлүүд нь нийгмийн даатгалын үйлчилгээг хүртээмжтэй болгоход хэрхэн нөлөөлж байгааг судлан нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх шаардлагатай (МНДТША–НДЕГ, 2015) хэмээн дүгнэлт гаргасан байна.

Фельдштейн (1974) “нийгмийн хамгааллын баялаг” буюу тэтгэврээс бий болох баялгийн тухай ойлголтыг танилцуулж, өргөтгөсөн амьдралын циклийн загварыг боловсруулсан. Түүнчлэн тэтгэврийн тогтолцоог үнэлэх

хэд хэдэн шалгуур үзүүлэлт санал болгожээ. Мерси тэтгэврийн тогтолцооны үнэлгээг хүрэлцээтэй байдал, тогтвортой байдал, цогц байдал гэсэн гурван шалгуур үзүүлэлтээр хэмжих нь тохиромжтой гэж үздэг.

Хүрэлцээт байдал гэдэгт тэтгэврийн хэмжээ, татварын дэмжлэг, хөрөнгийн өсөлт гэсэн ойлголт багтах бөгөөд энэ нь нийт жингийн 40 хувийг бүрдүүлнэ. Тогтвортой байдал нь нийт жинд 35 хувийг эзэлдэг. Үүнд хамрах хүрээ, хувь хэмжээ, хүн ам зэрэг нь багтана. Тэтгэврийн сангийн макро түвшний удирдлага буюу “цогц байдал” нь үлдсэн 25 хувийг эзэлж байна. Фельдштейн, Мерсигийн боловсруулсан шалгуураас гадна Дэлхийн банкны тэтгэврийн тогтолцооны ололт, амжилтыг үнэлдэг хүрэлцээтэй байдал, хүртээмжтэй байдал, тогтвортой байдал, найдвартай байдал гэсэн дөрвөн үзүүлэлт боловсруулсан нь практикт нэлээд түгээмэл ашиглагддаг (Zhao, et al, 2025).

Петер Вайтфорд, Эдвард Вайтхаус нар ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын тэтгэврийн сорилт, тэтгэврийн шинэчлэлийг судлан үзээд сүүлийн жилүүдэд өндөр настанд олгодог тэтгэврийн хэмжээнээс хамааралтайгаар абсолют ядуурал, орлогын тэгш бус байдал залуучуудын бүлэгтэй харьцуулахад буурсан гэсэн дүгнэлт хийсэн юм (Whiteford, Whitehouse, 2006).

Дэлхий нийтэд эв санааны зарчим буюу дахин хуваарилалтын зарчмаар санхүүжигддэг цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоо, шимтгэлд суурилсан хагас хуримтлалын болон бүрэн хувьчлагдсан тогтолцоо мөн эдгээрийн холимог зэрэг нийгмийн даатгалын олон тогтолцоо байдаг байна. Өнөө үед дэлхийн ихэнх улс олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлжээ (ЭМНДЕГ, 2017). Манай улсын нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр нь цалинд суурилсан, хуваарилалтын зарчмаар санхүүждэг тогтолцоо юм. Даатгуулагчийн тэтгэвэрт гарах шийдвэрт тухайн даатгуулагчийн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн ажил эрхлэлт, орлого, эрүүл мэнд, гэр бүлийн гишүүдийн тоо, тэдгээрийн бие даасан байдлаас ихээхэн хамааралтай (С.Ариунаа, 2019).

Өндөр насны тэтгэврийн хэмжээ нь түүнийг тогтоож буй аргачлалаас ихээхэн хамааралтай. Улс орнуудад өндөр насны тэтгэврийг:

1. Цалинд суурилсан (Defined benefit/DB system)
2. Шимтгэлд суурилсан (Defined contribution/DC system)
3. Хийсвэр хуваарилалтын (Notional defined contribution/NDC system) тэтгэвэр гэсэн үндсэн гурван хэлбэрээр тогтоож байна.

Цалинд суурилсан тэтгэвэр нь даатгуулагчийн ажиллах хугацаан дахь цалингийн хувь хэмжээнд, шимтгэлд суурилсан тэтгэвэр нь даатгуулагчийн

төлсөн шимтгэлийн хэмжээнд тус тус үндэслэн тооцогддог. Шимтгэлд суурилсан тэтгэврийн үед даатгалын харилцаанд оролцогч бүрийн шимтгэлийг түүний тэтгэврийн даатгалын нэрийн дансанд байршуулж, тухайн иргэн тэтгэвэр тогтоолгох үед нэрийн дансны хөрөнгийг тэтгэврийг санхүүжүүлэх эх үүсвэр болгон ашиглана. Шимтгэлээс хийсвэр тооцох тэтгэвэр нь шимтгэлд суурилсан тэтгэвэртэй олон талаар төстэй. Гэхдээ дансанд бодит хөрөнгө хуваарилагдахгүй, тухайн данс нь тэтгэврийн эрхийг тодорхойлох бүртгэл тооцоо болдог онцлогтой байна.

Улс орнууд өндөр насны тэтгэврийн тогтолцооны загвар, тэтгэврийн давхарга, санхүүжүүлэх эх үүсвэрээс хамааруулан тэтгэвэр тогтоох дээрх аргыг гол төлөв хослуулан ашиглаж байна.

2.2. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн нөлөөллийг тодорхойлох онол, арга зүй

Нобелийн шагналт эдийн засагч Гарри Беккер 1992 онд нийтлүүлсэн бүтээлдээ “Өрх бол маргаангүй хамгийн эртний нийгмийн суурь институц” юм (Becker, 1992) гэж тодорхойлжээ. Тэрээр, өрхийн орлогын эх үүсвэрийн хуваарилалт, шийдвэр гаргалт, орлого нэмэгдүүлэх арга, хэрэгслийг хамгийн өндөр түвшинд бий болгох, түүнийгээ ашиглах, захиран зарцуулах үйл явцын тухай ойлголтод суурилан “*Шинэ өрхийн эдийн засгийн онол*”-оо боловсруулсан (Mattila–Wiro, 1999).

Өрх нь эдийн засгийн анхдагч нэгжийн хувьд гишүүдийн мэргэжлийн ур чадвар, сонирхол, орлого, зардлын төрөл, хэмжээ, хуримтлал үүсгэх чадвар, техник технологийн өөрчлөлт, шинэчлэлд хандах хандлага зэрэг нь зөвхөн өрхийн төдийгүй салбар, цаашлаад улс орны эдийн засгийн хувьд ч чухал институц юм (Browning, Chiappori, 2011). Эдийн засагчид өрхийг орлого бүрдүүлдэг, түүнийг хэрхэн хуваарилахаа шийддэг, хамтран ажилладаг эдийн засгийн бичил эс гэж үздэг. Канад улсын Үндэсний дансны систем байгууллагаас өрхийг “нэг орон сууцанд амьдардаг, орлого, баялгийнхаа зарим хэсгийг эсвэл бүхэлд нь нэгтгэдэг, хоол хүнс зэрэг тодорхой төрлийн бараа, үйлчилгээг нийтээрээ хэрэглэдэг жижиг бүлэг хүмүүс хэмээн тодорхойлсон байна (Merto. et.al, 2024).

Судлаачид өрхийн эдийн засаг гэсэн ойлголтыг тодорхойлохдоо өрхийн гишүүдийн эдийн засгийн хамтын үйл ажиллагаагаар тодорхойлогддог бөгөөд төр, хувийн хэвшилтэй нэгэн адил том хүрээг хамардаг ухагдахуун (Akter, 2018) гэж үзсэн байдаг. Энэ нь өрхийн эдийн засагт тухайн өндөр насны тэтгэвэр авагчийн бүрдүүлж буй орлогоос гадна өрхийн бусад гишүүдийн орлого, хэрэглээ зэргийг хамруулан авч үзэхийг харуулж байна.

Мөн өрхийн эдийн засаг гэдэг нь өрхүүд амьжиргааны хэвийн түвшинг хангах, амьдрал ахуйгаа дээшлүүлэхийн тулд орлого, хөрөнгө капитал, цаг хугацаа, хөдөлмөр зэрэг нөөцөө оновчтой удирдах зорилгоор гаргасан стратеги, шийдвэр, үйл ажиллагаа, түүний үр дүн юм. Энэ нь өрхийн орлого бүрдүүлэлт, хуваарилалт, өрхийн хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээ, зарцуулалт, амьжиргааны төлөв байдлыг хамардаг (Household economy, 2010). Хүүхдийг ивээх сангаас өрхийн эдийн засагтай холбоотой судалгаа хийхдээ “Өрхийн эдийн засаг гэдэг нь өрхийн орлого олох арга зам, хадгаламж, хөрөнгө эзэмшил, хүнс болон хүнсний бус бараа бүтээгдэхүүний хэрэглээний нийлбэрээр тодорхойлогдоно” (Save the children, 2000) гэсэн тодорхойлолтыг ашиглаж байна. Энэ нь өрхийн эдийн засгийн судалгаанд орлого, зардал гэсэн гол бүрэлдэхүүнийг багтаах шаардлагатай болохыг харуулна.

Өрх нь хөгжиж буй, хөгжингүй аливаа нийгэмд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийлүүлэх гол хүчин буюу эдийн засгийн нөөц болсоор ирсэн. Энэ утгаараа өрх нь эдийн засгийн чухал үйлдвэрлэгч төдийгүй зарцуулагч юм. Тухайлбал, хүүхэд төрүүлэх, асрах, хөгжүүлэн төлөвшүүлэх замаар ирээдүй хойч үеэ бэлтгэх, худалдан авсан бараа, бүтээгдэхүүнийг ашиглан хоол хүнс үйлдвэрлэх, гишүүдээ өвчин, болон бусад аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, гишүүдийн нэр хүндийг баталгаажуулах зэрэгт ихээхэн анхаарал хандуулдгаараа нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн суурь болдог бөгөөд нэр хүнд бүхий эдийн засагчид өрх бол макро, микро эдийн засгийн амьдралын үндэс гэж үздэг. Түүнчлэн, санхүүгийн хувьд харьцангуй хүчирхэг өрхүүд зах зээлээс зөвхөн бараа, үйлчилгээг худалдан авч хэрэглээд зогсохгүй хуримтлалаараа банкны системийг санхүүжүүлэх, үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийх зэргээр үе дамжсан санхүүгийн баталгааг бий болгож байдаг (Browning, Chiappori, 2011).

Ихэнх судлаачид эдийн засгийн шинжилгээнд өрхийн бодит эдийн засгийг тодорхойлоход шаардлагатай үзүүлэлтүүд болох өрхийн төлөв, хандлагын талаарх мэдээллийг ашигладаггүй (Becker, 1986). Энэ нь өрхийн эдийн засгийн бодит нөхцөл байдлыг тодорхойлох, улмаар оролцогч талуудын харилцан хамаарал, оролцооны түвшин зэргийг нарийвчлан шинжлэх боломжийг хязгаарлах эрсдэлтэй бөгөөд эдийн засагчдыг өрхийн эдийн засагт системтэй, нэгдсэн дүн шинжилгээ хийх эхлэлийг тавих нөхцөл болсон.

Өрхийг эдийн засгийн анхдагч нэгж хэмээн үзэж болох бөгөөд боловсрол, эрүүл мэнд, халамж зэрэг нийгмийн ач холбогдол бүхий салбарт гүйцэтгэх үүрэг, оролцоо нь зайлшгүй хэрэгцээтэй юм. Өрхийн гишүүд дотооддоо сурган хүмүүжүүлэх, үлгэр дуурайлал үзүүлэх, аливааг хийх арга барил, ур

чадвар эзэмшүүлэх зэрэг үйл ажиллагааг үнэ төлбөргүй явуулж, өрхийн болон нийгмийн түвшинд эдийн засгийн олон эерэг нөлөөллийн суурийг тавьдаг (Browning, Chiappori, 2011). Өрхийн гишүүн-тэтгэврийн насны иргэний хувьд тэтгэвэр нь цалинтай ажил эрхлэх боломжгүй болсноос үүссэн орлогын эх үүсвэрийг нөхөх зайлшгүй шаардлагатай бөгөөд орлого нь тэдний наад захын хэрэгцээнд хангалтгүй тохиолдолд энэ нь тэгш бус байдлыг бий болгодог. Учир нь тэтгэвэр бол ядуурлыг шууд бууруулахаас гадна сэтгэцийн эрүүл мэнд, материаллаг бус сайн сайхан байдлыг дэмжиж, улмаар өндөр настнуудын нийгмийн оролцоог урамшуулна. Түүнчлэн, тэтгэврийн хэмжээ нь нийгмийн эерэг нөлөөлөл, ялангуяа өндөр настнуудын нийгмийн капиталыг төлөвшүүлэх, өрх, нийгэм дэх тэдний байр суурийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах чухал хэрэгсэл болдог (Zhu, Walker, 2018).

Манай улсад ҮСХ-оос зохион байгуулдаг хүн амын тооллого болон бусад өрхийн эдийн засагтай уялдаа бүхий статистик мэдээллийг боловсруулахдаа “Өрх гэдэг нь нэг сууцанд хамтран амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс болон бусад амьдралынхаа наад захын хэрэгцээг хамтран хангадаг бүлэг хүмүүс юм” хэмээх тодорхойлолтод суурилдаг (ҮСХ, 2015). Энэ нь өрхийн төсөв буюу орлого, зардал нь өрхийн суурь ухагдахуун бөгөөд өрх нь эдийн засгийн шинжтэй эдийн засгийн бичил нэгж болохыг илтгэнэ.

Азийн Хөгжлийн банкны судлаачид БНХАУ-ын хөдөө орон нутгийн тэтгэврийн шинэчлэлийн хүрээнд 60-аас дээш насныханд олгодог тэтгэвэр нь өндөр настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд хэрхэн нөлөөлж байгааг судалжээ. Тэтгэвэр авдаг өндөр настнуудын хувьд шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж нэмэгдэж, тэтгэврээ эмчилгээний зардалд зарцуулах хандлага нэмэгдсэн. Тэтгэвэр нь өндөр настнуудын сайн сайхан байдалд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлдэг гэж АХБ-ны судлаачид дүгнэсэн байна (Chen, 2023).

Өндөр настны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын судалгаанд Монгол Улсын өндөр настнуудын тэтгэврийн орлого бага, амьжиргааны түвшин доогуур байгааг онцолсон (ҮСХ, 2018). Улмаар К.Бендер, В.Мак Артур нар Монгол Улсад 20 жил нийгмийн даатгалын шимтгэл төлж, 60 настай тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд тэтгэврийн хэмжээ нь тэтгэвэрт гарахаас өмнөх цалингийн 39.6 хувийг нөхөж байгааг дурджээ (Л.Энх-Амгалан, 2015). Нийгмийн даатгалын үйлчилгээ нь хөдөө, орон нутаг, эмзэг бүлгийн иргэдэд хүртээмжтэй эсэхийг судлахад хөдөө, орон нутгийн иргэдэд хүртээмж бага, мэдээлэл хомс байна (НДҮХ-НДЕГ, 2020).

Нийгмийн даатгалын ерөнхий газар, ОУХБ хамтран нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд хэрхэн авч байгаа, авахад тулгардаг бэрхшээлийг судлахад

орлого багатай хэсэгт мөн адил хүртээмжгүй байгааг онцлоод, үүнд байршил, мэдээллийн хүртээмж, иргэдийн оролцоо чухал болохыг тодорхойлжээ (НДҮХ–НДЕГ, ОУХБ, 2016). Судлаач С.Ариунаа, өндөр насны тэтгэвэр нь өрхийн гишүүдийн тоо, хүүхдийн тоо, гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, орлого, хөрөнгийн байдлаас шалтгаалан амьдралын түвшинд харилцан адилгүй нөлөөлдөг (С.Ариунаа, 2019) болохыг судалгаагаар харуулсан байна. Хүн амын тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд суурилсан ҮСХ-ны судалгаанд өндөр насны эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлохдоо тэтгэврийн хэмжээг хавсарга байдлаар авч үзсэн байна. Олон судалгаанаас үзэхэд, өндөр насны амьжиргааны гол эх үүсвэр нь өндөр насны тэтгэвэр байгаа (ХЭҮК, 2015) тул өрхийн эдийн засаг дахь нөлөөллийг нарийвчлан судлах нь чухал юм.

Степен Кидд, Анх Тран нар Өмнөд Африк болон Өмнөд Америкийн улсуудын өндөр настнуудын өрхийн эдийн засагт үзүүлэх тэтгэврийн нөлөөг судлан дараах үр дүнг танилцуулжээ. Үүнд:

- Өндөр настнууд тэтгэврийн орлогоо ач зээгээ асрах, тэднийг чадавхжуулан хөгжүүлэх, ирээдүйн бүтээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулдаг ажээ. Жишээлбэл, Намиби улсын өндөр настнуудын дунд хийсэн судалгаагаар тэтгэврийнхээ тэн хагасыг ач, зээгийнхээ сургууль, хоол хүнс болон бусад зардалд зориулдаг гэсэн үр дүн гарсан байдаг. Түүнчлэн, тус судалгаагаар дараах үр дүн танилцуулагджээ. Үүнд:
 - Бразил, Өмнөд Африкийн улсуудад тэтгэвэр авагчдын 80 гаруй хувь нь тэтгэврийн орлогынхоо ихэнх хувийг хүүхдүүдтэйгээ хувааж хэрэглэдэг.
 - Өмнөд Африк, Мексик, Филиппин зэрэг улсын өндөр настнууд тэтгэврийн мөнгө авч байгаа нь үр хүүхдүүддээ санхүүгийн дарамт учруулахгүй амьдрах боломж бүрдүүлдэг.
 - Өмнөд Африк улсад өндөр настнууд тэтгэврээ ач, зээгийнхээ сургалтын төлбөрт зориулдгаас улбаатайгаар хүн амын нэн ядуу хэсгийн сургуульд хамрагдалтын түвшин 8 хувиар өссөн.
 - Боливи улсад тэтгэврийг бизнесийн үйл ажиллагаа болон хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийхэд зарцуулж эерэг үр нөлөөг бий болгосон.
 - Өмнөд Африк, Замби улсад тэтгэврийг албан бус бичил аж ахуйн нэгж байгуулах, энэ чиглэлийн ААН-ийг өргөжүүлэхэд зарцуулдаг туршлага байна. Энэ улсад хоёр жилийн дотор хөрөнгө худалдан авагчдын тоо 45 хувиар, мал худалдан авагчдын тоо 77 хувиар,

тухайн худалдан авалтын бодит үнэ цэн 42 хувиар өссөн. (Tan, 2025).

Их Британи гурван удаагийн тэтгэврийн шинэчлэлийн үр дүнг судлахдаа тэтгэврийн хуримтлал болон хадгаламжийн хамаарал гэсэн хувьсагчийг ашиглажээ. “Ялгаатай хандлагын ялгаа”-д суурилан хоёр хувьсагчийн хамааралд шинжилгээ хийхдээ хяналтын болон туршилтын бүлгийг харьцуулсан (Attanasio, Rohwedder, 2003).

Брүүкингс институтийн судлаач Уильям Гэйль “Өрхийн эд баялагт тэтгэврийн үзүүлэх нөлөө” судалгаанд тэтгэвэр ба хуримтлалын хамаарлын шинжилгээ хийжээ. Тэрээр, тэтгэврийн хуримтлал бол тэтгэврээс өмнөх цалингийн өнөөгийн үнэ цэн, боловсролын түвшин, өрхийн тэргүүлэгчийн нас, эхнэр болон нөхрийн хуримтлал үүсгэсэн байдал зэрэг хувьсагчийг ашигласан байна. Судлаач тэтгэвэр нь өрхөд бусад төрлийн баялаг бий болгоход нөлөөлдөг гэж дүгнэжээ (Gale, 1998). Ораза, Сюзан (2003), Уильям Гэйль (1998) нарын хийсэн судалгааны үр дүнгээс үзвэл “өрхийн эдийн засаг” гэсэн хувьсагчид хадгаламжийн хэмжээнээс гадна тогтмол хуримтлал хийх хандлагыг судлах боломжтой юм.

Жин Фэн, Лисин Хэ, Хироши Сато зэрэг судлаачид өрхийн хуримтлалыг 1999 онд хийгдсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлоготой холбон судалж, Хятад улсын хот суурин дахь өрхийн хадгаламжийн хувь хэмжээ нэмэгдэж байгаа хандлагыг шинэлэг өнцгөөс тайлбарлажээ. Судлаачид тэтгэврийн хуримтлалаас бий болсон баялгийг судлахдаа “экзоген – бодлого – үйл явцын шалтгаан – хэлбэлзэл” аргыг ашиглан тэтгэврийн орлого нь өрхийн хуримтлал үүсгэхэд нөлөөлж буйг тогтоосон. Үр нөлөө нь хүлээгдэж буй параметрийн утгаас хамаарах хэдий ч тэтгэврийн шинэчлэл өрхийн хуримтлалд нөлөөлсөн болохыг нотолсон байна. Тэтгэврийн шинэчлэл нь өрхийн хуримтлалын хувь хэмжээг 25–29 насны бүлэгт 6–9 хувиар, 50–59 насны бүлэгт 2–3 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн. Тэтгэврийн хэмжээ хүрэлцээ багасахад бусад хэрэглээнээс илүүтэй боловсрол, эрүүл мэндэд зарцуулах зардлаа бууруулдгийг судлаачид харуулсан байна. Судалгаанд Үндэсний статистикийн газрын томоохон түүвэр болох хөдөөгийн 65,000 өрх, хотын 35,000 өрхөөс сонгон 19 аймгийн 7,998 хөдөөгийн өрх, 11 аймгийн 6,931 хотын өрхийн судалгаанд үндэслэсэн БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн мэдээллийг ашиглан боловсруулжээ (Feng, 2011).

Судлаач Эллиотт Фаний “Өндөр насны тэтгэврийн үр шимийг хэн хүртэх вэ? Зорилтот бүлгийн нотолгоо” судалгаандаа нийгмийн бодлого ба эдийн засгийн хөгжил хоорондоо харилцан уялдаатай гэдэг утгаараа тэтгэвэр, өрхийн хэрэглээ, хадгаламжийн уялдааг судлах нь амин чухал болохыг

цохон тэмдэглэсэн байдаг. Нийт орлого, тогтмол орлого, амьдралын мөчлөгийн таамаглалд тулгуурлан өрхийн хэрэглээний түвшинд тэтгэвэр хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилгоор судлаач өгөгдлийн цувааны загвар боловсруулсан. Хэрэглээний функцийг дараах томъёогоор тооцжээ.

$$C_t = \alpha + \beta_1 Y_t + \gamma_1 W_t \quad C_t = \alpha + \beta_1 Y_t + \gamma_1 W_t$$

Энд: C_t C_t – хэрэглээний зардал,
 Y_t Y_t – тогтмол орлого,
 W_t W_t – өрхийн хөрөнгийг илэрхийлнэ.

Онолын хүрээ болгон Кейнсийн “Үнэмлэхүй орлогын таамаглал” гэсэн хэрэглээний функцийн дагуу одоогийн хэрэглээний ахиу өсөлтийг зөвхөн одоогийн орлогын ахиу өсөлтөөр шийддэг боловч «хэрэглээний ахиуц хандлага буурч» байгааг харуулдаг (Fan, 2010).

Дээрх загварыг ашиглан Эллиотт Фан Тайвань улсын эцэг эхтэй хамт амьдардаггүй насанд хүрсэн хүүхдүүдэд үзүүлэх “фермерүүдийн тэтгэврийн хөтөлбөр”-т хамрагдагчдын гар дээр авдаг мөнгөний нөлөөг судлан үзсэн. Фермерүүдэд зориулсан тэтгэврийн хөтөлбөрийн тооцооллоос үзэхэд 1 доллар тэтгэврийн 30–39 центийг өндөр настнууд төрөл бүрийн шилжүүлэг хийхэд ашигладаг гэсэн тооцоо гарсан (Fan, 2010).

Улсаас олгож буй тэтгэвэр нь өрхийн хэрэглээ, эдийн засгийн өсөлтийн хооронд хамаарал үүсгэж нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгохын тулд Хятад улс тэтгэврийн тогтолцоонд хамгийн бага орлоготой бүх иргэдийг хамруулж, тэтгэмжийн түвшинг нэмэгдүүлэхийг бодлогын түвшинд дэмжиж байна (Zhao, et al, 2025). БНХАУ-д урт хугацаанд давтан хийгддэг эрүүл мэнд, тэтгэврийн судалгааны 2011, 2013 оны үр дүнг үзвэл, тэтгэвэр авдаг болон авдаггүй бүлгийг харьцуулахад тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан хүмүүс орлогын квантил бүлэгтээ илүү хэрэглээтэй байдаг нь илэрхий байв. Түүгээр ч зогсохгүй, тэтгэвэрт гарсан бага орлоготой бүлгийг өндөр орлоготой бүлэгтэй харьцуулахад хэрэглээний ялгаатай байдалтай болохыг судлаачид тодруулсан. Өөрөөр хэлбэл, өндөр орлоготой бүлэгтэй харьцуулахад бага орлоготой бүлгийнхэн тэтгэврийн нэмэгдлээ хувийн хэрэглээндээ илүү зарцуулах хандлагатай байв.

Дэлхийн банкны Эдийн засгийн тоймд хэвлэгдсэн Эшфэх Дафлогийн “Эмээ болон ач охид: Өмнөд Африкийн өндөр насны тэтгэврийн өрх дэх зарцуулалт” судалгааны тайланд тэтгэврийн мөнгө ач, зээгийн хоол тэжээлийн байдалд үзүүлэх нөлөө, түүний хүйсээс хамаарсан ялгааг харуулжээ. Өмнөд Африк улсын тав хүртэлх насны хар арьст дөрвөн

хүүхэд тутмын нэгээс илүү хувь нь тэтгэвэр авагчтай хамт амьдардаг. Эмэгтэйчүүдийн тэтгэврийн хэмжээ охидын антропометрийн төлөв байдал (биеийн өндөр, тухайн насны жин)-д чухал нөлөө үзүүлсэн бол хөвгүүдэд бага зэрэг нөлөө үзүүлсэн. Харин, эрэгтэй тэтгэвэр авагчдын хувьд ямар нэгэн нөлөө ажиглагдаагүй.

Тэтгэвэр авдаггүй өрхийн хүүхдүүдийн биеийн жинг өрхийн эрэгтэй, эмэгтэй тэтгэвэр авагчидтай харьцуулахад тэтгэвэр авагч эмэгтэй байх нь ач, зээ охидын биеийн өндөр, жинг нэмэгдүүлсэн боловч хөвгүүдэд статистик хамааралгүй гэсэн үр дүнд хүрчээ (Esther Duflo, 2003). Энэхүү судалгаанд Дэлхийн банк болон Кейптаун их сургуулийн Өмнөд Африкийн Хөдөлмөр, хөгжлийн судалгааны алба хамтран хийсэн үндэсний судалгааны үр дүнг өгөгдөл болгон ашиглаж, 1993 оны сүүлийн таван сарын хугацаанд санамсаргүй түүврийн аргаар бүх үндэстэн, бүх нутаг дэвсгэрийг төлөөлөх чадвартай 9,000 өрхийг сонгож санал асуулгад хамруулжээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хүүхдийн өндөр, жингийн шинжилгээг 0-5 насаар хязгаарлах зөвлөмжийг (ДЭМБ 1986) эш үндэс болгон судалгааны үзэл баримтлалыг боловсруулсан байна. Судалгаанд АНУ-ын Эрүүл мэндийн статистикийн үндэсний төвөөс тогтоосон жишиг популяцийн харгалзах нас, хүйсийн бүлгийн дундаж утгыг хасаж, стандарт алдаанд хуваах замаар хүүхдийн өндрийг сараар тооцдог z онооны аргыг ашигласан юм.

Польш улсын судлаачид 1999 оны тэтгэврийн шинэчлэлээс үүдэлтэй бий болсон хөрөнгийн өөрчлөлтийг судалж, улсаас олгож буй тэтгэврийн өрхийн хуримтлалд үзүүлэх нөлөөг тооцоолжээ. Судалгаагаар тэтгэврийн шинэчлэлийн үр дүнд өрхийн хуримтлал нэмэгдэж, зарлага буурсан нь илэрхий байсан. Өгөгдлийн шинжилгээгээр тэтгэврийн баялгийн 1.00 польш золот бууралт тутамд хувийн хадгаламж ойролцоогоор 0.30 польш золотоор нэмэгдсэн байна. Линднер, Моравски (2012) нар тэтгэврийн шинэчлэлийн ажиллах хүчний нийлүүлэлтэд үзүүлэх нөлөө бага гэж үзсэн. Польш улсын өндөр настнууд ирээдүйд авах тэтгэврийн хэмжээ бууруулах сорилттой тулгарсан үед ажиллах хүчний нийлүүлэлтээс илүүтэй хуримтлалдаа өөрчлөлт оруулахыг илүүд үздэг. Тэтгэврийн шинэчлэлийн талаар мэдээлэлтэй, санхүүгийн хувьд илүү дасан зохицох чадвартай, боловсролын түвшин дээгүүр өндөр настнуудын хувьд тэтгэврийн шинэчлэлд дасан зохицох хариу үйлдлийг богино хугацаанд үзүүлж байсан бол, бага боловсролтой өндөр настнуудын хувьд хурд удаан, ямар нэгэн боловсрол эзэмшээгүй өндөр настнууд ямар ч хариу үйлдэл үзүүлээгүй байна (Lachowska Муск, 2018). Өндөр насны тэтгэврийн үр нөлөөг судлахдаа тэтгэвэр авагчдын боловсролын түвшин, насны бүлэг зэрэг үзүүлэлтийг сонгон шинжилгээ хийх нь зохимжтой юм.

Видхья Унникришнан, Кацуши С.Имай нар Индра Гандигийн нэрэмжит Үндэсний өндөр насны тэтгэврийн хөтөлбөрт хэрэглээний зардал, орлого, хөрөнгө, ядуурал зэрэг өрхийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлохдоо урт хугацаанд давтамжтайгаар хийгддэг Энэтхэг улсын хүний хөгжлийн судалгааны 2004 оны 5 дугаар сар, 2011 оны 12 дугаар сарын өрхийн мэдээллийг ашигласан. Үндэсний өндөр насны тэтгэврийн хөтөлбөрт хамрагдах нь хэрэглээний зардал, хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний зардал, орлогын түвшинг нэмэгдүүлж, харин өрхийн ажиллах хүчний нийлүүлэлтийг бууруулсан байна. Энэ үр дүн зөвхөн эмэгтэй тэтгэвэр авагчдын дунд ажиглагдсан. Засгийн газрын хөтөлбөрт 2007 онд өөрчлөлт оруулсны дараах 2011–2012 онуудад ядуурлыг бууруулах үр нөлөө бага болохыг ялгаатай байдлын загвар ашиглан харуулжээ (Unnikrishnan, Imai, 2020). Тэтгэврийн нөлөөг тодорхойлоход салбар дундын өгөгдөлд суурилсан ба өрх дэх нөлөөллийн загвар ашигласан. Ингэхдээ тэтгэвэр авдаг болон авдаггүй өрхийг хандлагын оноотой харьцуулах аргаар тооцож тухайн оноог ашиглан регрессийн шинжилгээ хийснээрээ онцлогтой. Энэхүү судалгаа нь өрхийн хэрэглээ, орлого, хөрөнгө, хөдөлмөрийн нийлүүлэлт зэрэгт үзүүлэх үр нөлөөг тэтгэвэр авдаг болон авдаггүй өрхөөр, тэтгэвэр авагчдын хүйс, өрхийн хэлхээ холбоо, кастын бүлгээр харьцуулсан. Үр дүнгээс үзэхэд өрхийн хэрэглээ, орлого, хөрөнгө, өрхийн хөдөлмөрийн нийлүүлэлт гэсэн үзүүлэлтээр, туршилтын болон хяналтын бүлгээр, өрхийн орлогын түвшин, тэтгэвэр авагчийн хүйсээр харьцуулан тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөөг судлах боломжтой юм.

Азийн орнууд тухайлбал, Хятад улс 2009 онд хөдөө орон нутгийн тэтгэврийн шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бол Киргиз улс 1992 онд тэтгэврийн тогтолцоонд томоохон шинэчлэл хийсэн. Шинэчлэл нь өндөр настнуудын хоол хүнсний хангамжид эерэг нөлөө үзүүлжээ. Киргиз улсад 2012, 2013, 2016, 2019 онд дараалан хийгдсэн урт хугацааны судалгааны өгөгдөл ашиглан “Өндөр насны тэтгэврийн хоол тэжээлийн байдалд хийсэн судалгаа: Киргиз улсын нотолгоо” судалгааг гүйцэтгэсэн. Судалгаанд өндөр настнуудын хоол тэжээлийн байдалд тэтгэврийн үзүүлэх нөлөөг тодорхойлоход “ялгаатай байдлын загвар” ашиглажээ. Тус улсын өндөр настнуудын хувьд тэтгэвэр нь орлогын гол эх үүсвэр болж, тухайн орлогоороо хоол хүнсээ худалдан авдаг. Өндөр насны тэтгэвэр хүнсний хэрэглээ, илчлэг, шим тэжээлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй, харин уургийн хэрэглээг нийт илчлэгт харьцуулсан харьцааг бууруулдаг гэсэн үр дүнг гарсан. Боловсролын түвшин, орлогын ялгаатай байдлаас хамааран өндөр насны тэтгэврийн мөнгөөр худалдан авдаг хоолны шим тэжээл ялгаатай байсан бөгөөд энэ ялгаа ядуу эсвэл бага боловсролтой өндөр настнуудын дунд түгээмэл ажиглагддаг (Ren, et.al, 2023).

Өндөр насны тэтгэвэр нь өрхийн орлогыг 18 хувиар нэмэгдүүлэхэд (Scheme Wei Huang Chuanchuan Zhang, 2021), эдийн засгийн идэвхтэй хүүхдүүдийн дэмжлэгээс өндөр настнуудын хараат байдлыг бууруулж, бие даан амьдрах чадвар дээшилсэн (Cheng, et.al, 2013) үр дүнд хүрчээ. Ижил хэмжээний тэтгэвэр авдаг шилжин суурьшигч болон шилжигч бус, хүүхэдтэй өндөр настнуудыг харьцуулан судлахад шилжин суурьшигч болон хүүхэдтэй өндөр настан ядууралд өртөх эрсдэл өндөр байна (Giles et al., 2011).

Европын Холбооны орнуудад ахмад настай өрхийн 60–70 хувь нь гол орлогын эх үүсвэрээ тэтгэврээс бүрдүүлдэг бол (Eurostat, 2023), зарим Азийн орнуудад хөдөлмөрийн болон тэтгэврийн орлого зэрэгцэн өрхийн орлогын үндсэн эх үүсвэр болж байгааг (ILO, 2022) олон улсад хийгдсэн зарим судалгаанаас харж болох юм. Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь хэмжээ нь тухайн өрхийн байршил, ам бүлийн бүтэц, орлогын түвшин зэргээс хамааран харилцан адилгүй байна. Ийм төрлийн зөрүүг бусад орнуудад хийсэн судалгаануудад тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, тэтгэврийн орлого нь нийт өрхийн орлогод эзлэх хувь нь бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн түвшин, хөдөлмөр эрхлэлтийн бүтэц, нийгмийн хамгааллын бодлогоос шууд хамаардаг (OECD, 2023) болохыг олон улсын судлаачид онцолсон нь бий.

Өндөр орлоготой бүлгүүдийн хувьд тэтгэвэр, тэтгэмжийн орлого нь нийт орлогын бүтцэд харьцангуй бага хувь эзэлдэг бол орлого багатай өрхүүдийн хувьд эдгээр орлого нь амьжиргааны гол тулгуур, орлогын тэгш бус байдлыг бууруулах гол хэрэгсэл болж байгаа нь харагдана. Өндөр насны тэтгэврийн орлого нь орлого багатай өрхүүдийн орлогын 60–80 хувийг бүрдүүлж нийгмийн тэгш бус байдлыг бууруулахад гол үүрэг гүйцэтгэдэг (Grech, 2021) болохыг энэ чиглэлээр хийгдсэн олон улсын зарим судалгааны үр дүн тодорхой харуулдаг.

Өндөр насны тэтгэвэр нь зөвхөн хувь хүний орлогын баталгаа биш, харин өрхийн эдийн засгийн тогтвортой байдал, үе хоорондын дэмжлэгийн гол хөшүүрэг болж байгааг харуулж байна. Япон, Өмнөд Солонгос зэрэг улсуудад ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлт өндөр түвшинд хэвээр байдаг нь тэтгэврийн хүрэлцээ болон гэр бүлийн хамтын эдийн засгийн тогтолцоотой уялддаг (Higo, & Klassen, 2017) болохыг энэ чиглэлээр хийсэн судалгаанаас харагдаж байна.

Орлого бага өрхүүдийн хувьд санхүүгийн боломжийн хомсдол нь хуримтлал үүсгэх чадамжийг бууруулж, урт хугацааны санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна (Алтанцэцэг, 2021). Хуримтлалын хэмжээ бага байгаагийн нэг гол шалтгаан нь өрхийн нийт орлогын түвшин болон

тэтгэврийн хэмжээтэй шууд хамааралтай болохыг судалгааны дүн харуулж байна. Өндөр орлоготой өрхүүдийн хувьд илүүдэл орлогоо хуримтлалд чиглүүлэх хандлага ажиглагддаг бол, бага орлоготой өрхүүдийн хувьд хэрэглээ давамгайлдаг (Modigliani, 1954).

Өндөр насны тэтгэвэр хөдөлмөрийн зах зээлийн оролцоонд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүй хэмээн судлаачид үздэг ч Нинг (Ning et al., 2016), Жао (Zhao, 2016) хөдөө амьдардаг, эрүүл мэнд тааруу, тэтгэвэр авагч өндөр настнуудын хувьд оролцоо буурдаг болохыг тогтоожээ. Сүүлийн үеийн эмпирик судалгаагаар өндөр насны тэтгэвэр нь хөдөлмөрийн зах зээлийн оролцоо, ажлын цагийг бууруулдаг болохыг ерөнхийд нь баталж байна (Börsch-Supan & Schnabel, 1998; Jung & Tran, 2012; Shu, 2018).

Судлаач Браунинг, Чиаппори нар өрхийн орлого ба зарцуулалтын хуваарилалтад гишүүдийн эзлэх хувь хэмжээг тодорхойлох шинжилгээ хийжээ. Судалгаанаас үзэхэд өрхийн гишүүн бүрд нийт зардлыг хуваарилснаар гишүүдэд өрхийн зардлаас зарцуулагдаж буй хувийг тооцоолох боломж олгодог байна (Browning, Chiappori, 2011). Энэхүү зарцуулалт нь өрхийн гишүүдийн тооноос хамааран ялгаатай байна.

Хүснэгт 1. Өрхийн зардлын хуваарилалт

№	Хэрэглээний төрөл	Зардлын хуваарилалт			
		Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн ...	Нийт
1	Хоол хүнс (Гэрт хооллох)	%	%	%	100%
2	Хоол хүнс (Гадуур хооллох)	%	%	%	100%
3	Хувцас	%	%	%	100%
4	Тээврийн үйлчилгээ	%	%	%	100%
5	Соёл, ахуйн үйлчилгээ (үсчин, гоо сайхан гм.,)	%	%	%	100%
6	...				
Нийт					

Эх сурвалж: (Browning, Chiappori, 2011)

Судлаачид судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн насны бүлэг, хүйсээр өрхийн зардлын хувь хэмжээг тогтоож, өрхийн эдийн засгийн нөхцөл, байдалд хэрэглээ талаас нь дүн шинжилгээ хийх, улмаар тэдний нийгмийн идэвх оролцоо, сонирхол зэргийг тодруулах замаар тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшинг тодорхойлохыг зорьсон байна.

Орлогын бүтцийг дараах хүснэгтийг ашиглан тодорхойлох боломжтой нь харагдаж байна.

Хүснэгт 2. Өрхийн орлогын хуваарилалт

№	Орлогын эх үүсвэрийн төрөл	Орлогын хуваарилалт			
		Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн ...	Нийт
1	Тогтмол хөдөлмөр эрхлэлт	%	%	%	100%
2	Түр хөдөлмөр эрхлэлт	%	%	%	100%
3	Тэтгэвэр	%	%	%	100%
4	Тэтгэмж	%	%	%	100%
5		%	%	%	100%
...	...				
Нийт					

Эх сурвалж: (Browning, Chiappori, 2011)

Орлогын хуваарилалтын судалгааны дүнг ашиглан өрхийн гишүүдийн насны ангилал, хүйсийн төрөл тус бүрээр зарцуулалтын хувь хэмжээг тогтоож, өрхийн эдийн засгийн нөхцөл, байдалд санхүүгийн эх үүсвэр талаас нь дүн шинжилгээ хийх, улмаар тэдний хөдөлмөр эрхлэлтэд хандах хандлага, хариуцлагатай байдал шинжилгээ хийж нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлага зэргийг тодорхойлох боломжтой юм.

Өрхийн нийт худалдан авсан бараа, үйлчилгээний зарим нь хувь гишүүний буюу өрхийн тодорхой гишүүнд зарцуулагдах, зарим нь нийтийн буюу бүх гишүүдэд зарцуулагдах онцлогтой. Хувийн бараа, үйлчилгээг өрхийн гишүүн тус бүр хувьдаа, харин нийтийн бараа, үйлчилгээг өрхийн бүх гишүүд хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, хувийн бараа, үйлчилгээний хэрэглэгчийн тоо хязгаарлагдмал шинжтэй байдаг бол нийтийн бараа, үйлчилгээний хувьд ийм хязгаарлалт байхгүй (Browning, Chiappori, 2011).

Судлаач Мартин Браун, Пиерре Чиаппори нарын боловсруулсан өрхийн гишүүдийн зардлын хуваарилалтыг нийтийн болон хувийн ашиг сонирхол, хэрэгцээ, шаардлагад үндэслэн нэг гишүүнд ногдох зардлын нийт зардалд эзлэх хувь хэмжээг тодорхойлох аргачлалыг дараах хүснэгтийг ашиглан тодорхойлох боломжтой юм.

Хүснэгт 3. Өрхийн зардлын хуваарилалт, гишүүдийн сонирхол, хэрэгцээ шаардлагын төрлөөр

№	Хэрэглээний төрөл	Өрхийн зардлын хуваарилалт			
		Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн ...	Нийт
Нийтийн бараа, үйлчилгээ					
1	Орон сууцны халаалт	%	%	%	100%
2	Татвар, хураамж (жишээ нь: хог хаягдлын хураамж)	%	%	%	100%
3	Хоол, хүнс	%	%	%	100%
4	Тэтгэмж	%	%	%	100%
5	Машины зардал	%	%	%	100%
...	...				
Хувийн бараа, үйлчилгээ					
1	Эм, тариа (жишээ нь: даралтны эм)	%	%	%	100%
2	Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн	%	%	%	100%
3	Хоол, хүнс (шаардлагатай тохиолдолд)	%	%	%	100%
4	Гоо сайхны үйлчилгээ	%	%	%	100%
5	Машины бензиний зардал (ихэвчлэн тодорхой тооны гишүүн хэрэглэж байгаа тохиолдолд)	%	%	%	100%
6	Тоглоом	%	%	%	100%
...	...	%	%	%	100%
Нийт					100%

Эх сурвалж: (Browning, Chiappori, 2011)

Хувийн бараа, үйлчилгээний хувьд гоо сайхны бараа, хувцас, ор зэрэг багтах ба гишүүн тус бүр өөрийн нас, хүйс, сонирхолд нийцүүлэн худалдан авахыг зорьдог. Халаалт, цахилгааны зардал зэрэг нь нийтийн бараа үйлчилгээний төрөлд багтана. Гэвч, машин, тоглоом зэрэг зарим барааны хувьд анхны шийдвэр нь нийтийн зориулалтаар худалдан авсан хэдий ч өрхийн нэг гишүүн, эсвэл хэд хэдэн гишүүд хэрэглэдэг тохиолдол элбэг байдаг.

Гишүүдийн хооронд шууд харилцан үйлчлэл бий болох бүрд нийтийн хэрэглээний улмаас эсвэл нэг гишүүний хэрэглээ нөгөө гишүүний сайн сайхан байдалд нөлөө үзүүлдэг тул үр ашиггүй байдал үүсэх магадлал өндөр байдаг. Зарим өрхийн хувьд өрх доторх барааны хуваарилалт нь орлогын хуваарилалтаас хамаарна (Browning, Chiappori, 2011). Өрхийн гишүүн нь бусад гишүүдийн худалдан авалт хийх зан үйлийн онцлогоос хамааран тэдэнтэй хамтран болон бие даан орлогоо юунд, хэрхэн зарцуулах талаар

шийдвэр гаргадаг. Гэвч энэ нь ихэнх өрхийн хувьд бараа, үйлчилгээний үнэ болон өрхийн нийт орлогоос хамаарна. Нийтийн бус шийдэл нь өрхийн гишүүн бүр өөрийн хэрэглээний төрөл, түвшинг бусдаас үл хамааран сонгохыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, өрхийн гишүүд хамт амьдардаг, гэхдээ зарим хэрэглээний хувьд эдийн засгийн харилцан үйлчлэлгүй байх явдал юм.

Өндөр настнууд тэтгэврээ өдөр тутмын хэрэглээний зардал, өрхийн орлого бүрдүүлэх, хөрөнгөтэй болох, хуримтлал үүсгэх, ач зээгээ асран тэтгэж ирээдүйд нь хөрөнгө оруулалт хийхэд зарцуулдаг байна. Мөн түүнчлэн тэтгэвэр нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах байдал, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтад эерэг нөлөө үзүүлж, хараат бус байдлыг бууруулж, бие даан амьдрах чадварыг нэмэгдүүлэх нөлөөтэй нь судалгаагаар нотлогджээ.

Өндөр насны тэтгэврийн өрхөд үзүүлэх нөлөөг тэтгэвэр авдаг болон авдаггүй бүлэг, хүйс, боловсрол, хот хөдөө, хүүхдүүдийнх нь шилжих хөдөлгөөнд оролцсон байдал зэрэг хүн ам зүйн хувьсагчаар судлан үзсэн тохиолдол түгээмэл юм.

Судлагдсан байдлын тоймоос харахад, өрхийн эдийн засгийн судалгаанд суурилан өндөр настны амьдралын чанарыг дээшлүүлэх, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэлхийн улс орнууд ашиглах хандлага нэмэгдсэн.

Өндөр насны тэтгэврийн өрхөд үзүүлэх үр дагавар, үр нөлөөг судлахдаа рационал сонголтын онол, жижиг үйл ажиллагаа нийлж өөрчлөлт бий болгодог тухай инкреймэнтэл онол ашиглахаас гадна ялгаатай байдлын хандлага, экзоген – бодлого – үйл явцын шалтгаан – вариаци, өгөгдлийн цувааны загвар, өргөтгөсөн амьдралын циклийн загвар, өрхийн тогтвортой нөлөөллийн загвар, симуляц зэрэг аргыг ашиглаж байгаагаас “ялгаатай байдлын хандлага”-ын арга хамгийн түгээмэл ашиглагддаг.

Тодорхой хугацаанд давтамжтай хийгддэг лонгитюд судалгааны хүрээнд цуглуулсан үндэсний хэмжээний өгөгдөл ашиглан энэ төрлийн судалгааг хийж байгаагаас гадна өгөгдлийг шинжлэхдээ хамаарлын хүснэгтийн, Z оноо тооцох, хандлагын оноотой харьцуулах, регрессийн шинжилгээний аргыг ашиглаж байна. Олон улсын түвшинд хийгдсэн дээрх судалгааны үр дүнг тэтгэврийн шинэчлэлийн талаарх бодлого боловсруулах, төлөвлөхөд ашиглах нь нэн чухал юм.

Өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөөг урт хугацаанд тодорхой давтамжтай хийж тухайн судалгааны үр дүнд тулгуурлан


тэтгэврийн шинэчлэлийн талаарх бодлого боловсруулах, төлөвлөх хандлага дэлхийн улс орнуудад нийтлэг ажиглагдаж байна.

Улмаар өндөр насны тэтгэврийн зохистой байдал нь тэгш шударга байдлын шалгуур буюу хууль эрх зүйн талаас тэтгэвэр тогтоох нөхцөл, тэтгэврийн хэмжээ, төрөл, нэмэгдэл гэх мэт нөхцөл байдал хэр хангагдсанаас хамаарч байна. Түүнчлэн тэтгэврийн тогтолцоо нь санхүүгийн хувьд тогтвортой байгаа эсэх нь зохистой байдалд тодорхой түвшинд нөлөөлөх юм.

2.3. Судалгааны үзэл баримтлал

Эдийн засагч Гарри Беккерийн тодорхойлсон шинэ өрхийн эдийн засгийн онол (Becker, 1992) нь энэхүү судалгааны үзэл баримтлалын үндэс болно. Уг онол нь *“Өрх бол маргаангүй хамгийн эртний нийгмийн суурь институц”, “Өрхийн орлогын эх үүсвэрийг бий болгох, хуваарилах, захиран зарцуулах, улмаар орлого нэмэгдүүлэх арга хэрэгслийг сайжруулах, холбогдох шийдвэр гаргалтыг оновчтой болгох нь өрхийн эдийн засгийн суурь ойлголт юм”* гэсэн үзэл санаанд суурилдаг. Иймд өрхийн эдийн засаг гэсэн ойлголтын хүрээнд өрхийн орлогыг бүрдүүлж буй байдал, орлогоос ахмад настан өөрийн болон өрхийн хэрэгцээ хангах байдал, цаашлаад хуримтлал болон бусдад үзүүлэх дэмжлэг буюу хуваарилалтыг багтаан судлав.

Зураг 1. Судалгааны үзэл баримтлалын зураглал



Судлаач Мартин Браун, Пиерре Чианпори нар өрхийн нийтийн болон хувийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн нийт зардалд эзлэх нэг гишүүнд ногдох зардлын хувь хэмжээг тодорхойлсон аргачлалыг судалгаанд эш үндэс болгов. Өөрөөр хэлбэл, өрхийн зардлын бүтцийг тодорхойлохдоо нийтийн буюу өрхийн бүх гишүүдэд хамааралтай хоол хүнс, орон сууц, ахуйн

хэрэгцээний зардал болон зөвхөн тухайн өндөр настанд хамааралтай хувийн хэрэгцээний зардал гэж хоёр төрөлд авч үзлээ.

Өндөр настнуудын эрүүл мэнд, амьдралын хэв маяг, сэтгэл зүйн онцлог, сонирхол, өрхийн орлогын хүрэлцээт байдал зэрэг хүчин зүйлээс шалтгаалан тэдний хувийн хэрэглээ нь харилцан адилгүй байдлыг харгалзан үзэж, Хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, Хувцас, эд хэрэглэл, Эрүүл мэндийн зардал (Эм тариа, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн), Тээврийн зардал (шатахуун, машины засвар үйлчилгээ), Хувийн үйлчилгээ (үсчин, гоо сайхан г.м), Өөрийн чөлөөт цагт зориулсан зардал (бүжиг, тоглоом, спорт г.м), Бусад гэсэн байдлаар өндөр настны хувийн хэрэглээг ангилсан.

2.4. Судалгааны таамаглал

1. Өндөр насны тэтгэвэр нь өрхийн орлого, эх үүсвэр, хуримтлалд эерэг нөлөө үзүүлж байна.
2. Өндөр насны тэтгэвэр нь тухайн ахмад настны хувийн хэрэгцээнд хүрэлцэхгүй байна.
3. Улаанбаатар хотын өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөө бага байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1. Судалгааны төрөл

Судалгаа нь нийгмийн даатгалын сангаас олгож буй өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлж буй нөлөөг судлан тодорхойлох, нөлөөлж буй зарим хүчин зүйлийг тодруулахад чиглэж буй тул тайлбар судалгаа болно.

3.2. Өгөгдлийн эх сурвалж

Судалгаанд анхдагч болон хоёрдогч өгөгдлийн эх сурвалжийг ашиглав. Санал асуулга, иргэд, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага нь судалгааны анхдагч өгөгдлийн эх сурвалж болно. Хоёрдогч эх сурвалжид сэдэвт хамаарах эрдэм шинжилгээний бүтээл, бодлого, эрх зүйн баримт бичиг, олон улсын туршлага, ҮСХ, НДЕГ-ын статистик мэдээлэл багтаж байна.

3.3. Эх олонлог, түүвэр

Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо 2023 оны жилийн эцсийн дүнгээр өндөр насны тэтгэвэр авч байгаа 382,755 иргэн байгаа нь нийт хүн амын 11.3 хувийг¹ эзэлж байна. Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо аймаг, дүүргээр нэлээд ялгаатай тул (Хавсралт 4) өндөр насны тэтгэвэр авагчдын тоо, хувийн жинг баримжаалан аймаг, дүүргүүдийг дараах 2 муж болгосон. Улмаар санал асуулгын судалгаанд төлөөлөх чадвартай түүвэр болох мужилсан санамсаргүй түүврийн аргыг ашиглав.

Хүснэгт 4. Судалгааны түүврийн мужлалт

№	Муж/Кластер	Тэтгэвэр авагчдын хувийн жингийн интервал	Хамаарах аймгийн тоо	Хамаарах дүүргийн тоо
1	Тэтгэвэр авагчдын тоо улсын дундажтай ойролцоо түвшинд байгаа аймаг, дүүрэг	9.5–12.5 хувь	8	4
2	Тэтгэвэр авагчдын тоо улсын дунджаас ялгаатай түвшинд байгаа аймаг, дүүрэг	9.4 хувь хүртэл, 12.6 хувиас дээш	12	5

¹ Судалгааны ажлыг 2025 оны 1-р улиралд эхэлсэн. Энэ хугацаанд 2024 оны жилийн эцсийн мэдээ бүрэн нэгтгэгдэж, нийтийн хүртээл болоогүй тул түүврийг тооцоходоо 2023 оны өгөгдөл суурилав.

Муж бүрд харьцангуй ойролцоо буюу нийт 9–12 аймаг, 4–5 дүүрэг ногдож байгаа тул тэнцүү пропорционаалт тархаалтаар муж бүрээс нэг аймаг, нэг дүүргийг сонгоход өндөр насны тэтгэвэр авагчдын улсын дундажтай ойролцоо мужаас Дорноговь аймаг, Баянзүрх дүүрэг, улсын дунджаас ялгаатай мужаас Сэлэнгэ аймаг, Сүхбаатар дүүргийг тус тус сонгогдсон болно. Сонгогдсон аймгийн төвийн болон хөдөөгийн тус бүр нэг сум буюу Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Дорноговь аймгийн Өргөн сумыг сонгож, судалгаанд хамруулсан.

Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо нь 382,755 буюу том хэмжээтэй эх олонлог бөгөөд 95 хувийн итгэмжлэх интервалд, түүврийн алдаа 5 хувь байхаар тооцоход төлөөлөх чадвартай буюу зохистой түүврийн хэмжээ 214 гарсан.

$$n = PQ \left(\frac{Z \left(1 - \frac{\alpha}{2} \right)}{e} \right)^2 = 11.3 * 88.7 \left(\frac{1.96^2}{5^2} \right) = 214$$

n – Түүврийн зохистой хэмжээ

Z – 95 хувийн итгэмжлэх интервал дахь *Z* утга

P – Өндөр насны тэтгэвэрт хамрагдалтын илрэх магадлал

Q – Өндөр насны тэтгэвэрт хамрагдахгүй байх магадлал

e – Алдааны түвшин

Түүврийн бус алдааг харгалзан үзээд, нийт 240 өрхөөс санал асуулгын судалгаа явуулах бөгөөд сонгогдсон аймаг, дүүрэг бүрээс тус бүр 60 өрхийг сонгож, судалгаанд хамруулсан болно.

Хүснэгт 5. Судалгааны түүвэр, сонгогдсон аймаг, дүүргээр

Аймаг, дүүрэг/сум	Түүврийн тоо	Хувь
Баянзүрх дүүрэг	60	25.0
Сүхбаатар дүүрэг	60	25.0
Дорноговь аймаг, Сайншанд сум	30	12.5
Дорноговь аймаг, Өргөн сум	30	12.5
Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум	30	12.5
Сэлэнгэ аймаг, Зүүнхараа сум	30	12.5
Нийт	240	100.0

“Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөө” судалгааны мэргэжилтний ярилцлагад ХНХЯ, НДЕГ, Аймаг, дүүргийн НДГ, сумын даатгал хариуцсан мэргэжилтэн, олон улсын төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, нийгмийн даатгалын чиглэлийн судлаачид нийт 20 хүн хамрагдав. Иргэнтэй хийх ярилцлагад судалгаанд сонгогдсон сум,

дүүрэг бүрээс 3, нийт 18 өндөр насны тэтгэвэр авч байгаа иргэн хамрагдсан. Иргэдийг түүвэрлэхдээ нас, хүйс, гэр бүлийн бүтэц, тэтгэвэрт гарсан нөхцөл, он зэргийн хувьд ялгаатай байдлыг харгалзан үзэв.

3.4. Хувьсагч, хэмжүүр

“Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөө” сэдэвт судалгааны хүрээнд дараах гол хувьсагчийг тодорхойлсон болно.

Хүснэгт 6. Судалгааны хувьсагч, хэмжүүр

№	Хувьсагч	Хэмжүүр
Хамаарах хувьсагч		
1	Орлого	<ul style="list-style-type: none"> ▪ Өндөр насны тэтгэврийн хэмжээ ▪ Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь хэмжээ ▪ Өрхийн хуримтлал ▪ Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл
2	Зардал	<ul style="list-style-type: none"> ▪ Өндөр насны тэтгэврийн зарцуулалт ▪ Өндөр насны тэтгэврээс бусдад үзүүлэх дэмжлэг ▪ Өндөр насны тэтгэврээс хувийн хэрэгцээнд зарцуулах байдал ▪ Өндөр насны тэтгэврээс нийтийн хэрэгцээнд зарцуулах байдал ▪ Өндөр насны тэтгэврийн хувийн зардалд хүрэлцэх байдал
Үл хамаарах хувьсагч		
Хүн ам зүй		
1	Нас	<ul style="list-style-type: none"> ▪ 60 хүртэлх ▪ 61–65 ▪ 66–75 ▪ 76–85 ▪ 86, түүнээс дээш
2	Хүйс	<ul style="list-style-type: none"> ▪ Эрэгтэй ▪ Эмэгтэй
3	Байршил	<ul style="list-style-type: none"> ▪ Нийслэл ▪ Аймгийн төв ▪ Сумын төв
4	Ам бүлийн тоо	<ul style="list-style-type: none"> ▪ 1 ▪ 2 ▪ 3–5 ▪ 6, түүнээс олон
5	Хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоо	<ul style="list-style-type: none"> ▪ 0 ▪ 1 ▪ 3 ▪ 3, түүнээс олон

Бодлого, эрх зүй		
6	Тэтгэвэр тогтоолгох нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Энгийн • Хөнгөлөлттэй
7	Тэтгэврийн төрөл	<ul style="list-style-type: none"> • Бүрэн • Хувь тэнцүүлсэн
8	Шимтгэл төлсөн хугацаа	<ul style="list-style-type: none"> • 120–240 сар • 241–300 сар • 301–360 сар • 361–480 сар • 481, түүнээс дээш сар
9	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэлбэр	<ul style="list-style-type: none"> • Албан журмын • Сайн дурын
10	Тэтгэвэр тогтоолгосон хугацаа	<ul style="list-style-type: none"> • 1995 оноос өмнө • 1995–2010 • 2011–2023 • 2023–2025

3.5. Өгөгдөл цуглуулах арга

Нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, судалгааны тайлан зэрэг хоёрдогч эх сурвалжид баримт бичгийн шинжилгээ хийж, судалгааны үзэл баримтлал, арга зүйг тодорхойлов.

Нийгмийн даатгалын нэгдсэн сангийн статистик мэдээлэлд судалгааны зорилго, асуулттай уялдуулан холбогдох шинжилгээ хийж, тайланд тусгав. 2025 оны 6 дугаар сарын 5-ны байдлаар НДЕГ-ын өгөгдлийн санд нийт 369,301 даатгуулагчийн хүйс, төрсөн болон тэтгэвэр тогтоолгосон он, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа, тэтгэврийн хэмжээ, төрөл, нөхцөл зэрэг мэдээлэл байсан бөгөөд эдгээр тоон өгөгдлийг судалгааны суурь өгөгдөл болгон ашиглалаа.

НДЕГ-ын өгөгдлийн сангаас гарах боломжгүй, өгөгдлийг санал асуулгын аргаар цуглуулж, судалгаанд ашиглалаа (Хавсралт 1). Санал асуулгыг боловсруулахдаа судалгааны зорилго, асуулт, үзэл баримтлалтай уялдуулсан бөгөөд цомхон, ойлгомжтой байхад анхаарав.

Судалгааны зорилго, зорилт, асуулттай уялдуулан нийгмийн даатгалын салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд болон өндөр насны тэтгэвэр авч буй иргэдтэй ярилцлага хийж, цуглуулсан чанарын өгөгдлөө тоон өгөгдлийг баталгаажуулах, тодруулах чиглэлээр хэрэглэв (Хавсралт 2, 3).

Судалгааны асуудалтай холбоотой тодорхой тохиолдол дээр ажиглалт, шинжилгээ хийж, судалгааны чанарын эх сурвалж болгон ашигласан болно. Кейсийг боловсруулахдаа шалтгаан, нөхцөл байдал, үр дагавар гэсэн холбоонд суурилсан болно.

3.6. Өгөгдөл шинжлэх арга

Нийгмийн даатгалын сангийн статистик өгөгдөл болон санал асуулгаар цуглуулсан тоон өгөгдлийг SPSS программаар боловсруулж, дүрслэн тодорхойлох болон хамаарлын статистикийн шинжилгээг хийсэн. Дүрслэн тодорхойлох шинжилгээнд давтамж, дундаж үзүүлэлтийг түгээмэл ашиглалаа.

Судалгааны хүрээнд ярилцлагаар цуглуулсан чанарын өгөгдөлд шинжилгээ хийхдээ нийгмийн шинжлэх ухааны судалгаанд ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын өгөгдлийг боловсруулахад түгээмэл ашигладаг **хамрах хүрээний шинжилгээний арга** (Framework analysis)-ыг ашиглав. Чанарын судалгааны өгөгдөлд шинжилгээ хийдэг энэхүү аргын үндсэн зорилго нь өгөгдлийг системтэй ангилж, тодорхой сэдэв (thematic), асуудлаар эмхэтгэн дүгнэдэг. Матрицын арга нь ярилцлагын явцад цуглуулсан өгөгдлийг шинжлэх үндсэн арга хэрэгсэл болно. Хамрах хүрээний шинжилгээний аргыг ашиглан дараах 6 үе шатаар мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын өгөгдөлд боловсруулалт хийсэн. Нэгдүгээрт, ярилцлагыг бичвэрт буулган тухайн бичвэртэй танилцаж, гол асуудал, сэдвүүдийг тодорхойллоо. Хоёрдугаарт, бичвэрээс чиглүүлэх асуулт, сэдвээс хамааран хүрээг нарийвчлан гаргав. Гуравдугаарт, сэдэвтэй холбоотой хэсгүүдийг тэмдэглэж, кодчилсон. Дөрөвдүгээрт, бичвэрийг тодорхой сэдэв, асуудлаар бүлэглэн хүснэгтэд оруулж, эцэст нь өгөгдлийг дүгнэж, сэдэв хоорондын хамаарал, үр дүнд тулгуурлан дүгнэлт боловсруулав.

Зураг 2. Ярилцлагын өгөгдөлд хамрах хүрээний шинжилгээ хийсэн алхам



Өндөр насны тэтгэврийн хэмжээ, нөлөөг тодорхойлохдоо нийгмийн туршилт, ялгаатай байдлын ялгааг тодорхойлох аргыг ашигласан. Тодруулбал, өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг тодорхойлохдоо өндөр насны тэтгэврийг инфляц, амьжиргааны доод түвшин болон цалингийн түвшинтэй харьцуулах, ОУХБ-аас зөвлөмжилсөн түвшинтэй харьцуулан үзсэн. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөө, түүний ялгаатай байдлыг SP шинжилгээний аргаар илрүүлсэн. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн хэмжээ, өрхийн эдийн засаг дахь нөлөөнд S буюу нийгэм хүн ам зүй, P буюу бодлого, эрх зүйн талаас нөлөөлж буй хүчин зүйлд төвлөрөн шинжилгээ хийв. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд GAP шинжилгээний аргыг ашиглан бодлого, эрх зүйн хувьд анхаарах асуудлыг тодорхойлсон.

3.7. Онч, найдвартай байдал

Судалгаанд ашигласан тоон өгөгдлийн онч, найдвартай байдлыг Кронбахын альфа коэффициентоор шалгахад нийгмийн даатгалын нэгдсэн сангийн өгөгдлийн хувьд 0.81, санал асуулгын өгөгдлийн хувьд 0.83 байгаа нь хүчин зүйлсийн дотоод нийцэл хүлээн зөвшөөрөгдөхүйц байна гэдгийг баталлаа.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

4.1. Өндөр насны тэтгэвэр, нөлөөлж буй хүчин зүйл

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа иргэдийн тоо, бүтэц, тэтгэврийн төрөл, нөхцөлийн талаар дурдаж, өндөр насны тэтгэврийн хэмжээ, нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулна.

Тэтгэвэр авагчдын тоо, бүтэц: Нийгмийн даатгалын сангийн нэг төрөл болох тэтгэврийн даатгалын сангаас нийт 509,065 иргэн тэтгэвэр авч байгаагийн 81.4 хувийг өндөр насны тэтгэвэр авагчид эзэлж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар нийт тэтгэвэр авагчдын тоо жилд дунджаар 4.3 хувиар, өндөр насны тэтгэвэр авагчдын тоо 4.8 хувиар тус тус өссөн нь насжилтын нөлөөгөөр тэтгэвэр авагчдын тоо илүүтэй нэмэгдэж байгааг харуулж байна.

Хүснэгт 7. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авдаг иргэдийн тоо, 2020–2024 оноор

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид	418,011	435,800	453,928	465,089	509,065
Өндөр насны	332,875	353,238	372,029	382,755	414,297
Хөдөлмөрийн чадвар алдсаны	65,904	63,049	62,223	62,511	68,975
Тэжээгчээ алдсаны	19,232	19,513	19,676	19,823	21,674

Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо


Тайлбар: 2025 оны тэтгэвэр авагчдын тоо мэдээлэгдээгүй тул оруулах боломжгүй байна.

2020–2024 онд манай улсын нийт хүн амын 12.8–14.8 хувь нь буюу ойролцоогоор 7 хүн тутмын нэг нь нийгмийн даатгалын сангаас сар бүр өндөр насны тэтгэвэр авч байгаа нь уг сан Монгол Улсын өрхийн эдийн засагт нэн чухал санхүүгийн тогтмол эх үүсвэрүүдийн нэг болохыг харуулж байна.

ҮСХ-ны мэдээлэлд тэтгэвэр авагчдын нас, хүйсийн бүтцээр харьцуулан харуулсан статистик дутмаг байна. НДЕГ-ын нэгдсэн санд 2025 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэлтэй нийт 369,301 өндөр насны тэтгэвэр авагчийн мэдээлэлд суурилан тооцвол, тэтгэвэр авагчдын 120,844 нь буюу 32.7 хувь нь эрэгтэйчүүд, 248,457 нь буюу 67.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Ийнхүү 3 тэтгэвэр авагч тутмын нэг нь эрэгтэй, хоёр нь эмэгтэй байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдээс харьцангуй урт байгаатай

холбоотой. Эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хувьд 50 хүртэлх насны тэтгэвэр авагчид хамгийн цөөн байгаа ба 60–64 нас хүртэл тэтгэвэр авагчдын тоо нэмэгдэж, цаашид нас нэмэгдэхийн хэрээр тэтгэвэр авагчдын тоо буурч байгаа нь ахимаг насанд нас баралтын түвшин өндөр байдагтай холбоотой.

Зураг 3. Өндөр насны тэтгэвэр авагчдын нас, хүйсийн суварга



Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

Тэтгэврийн төрөл, нөхцөл: “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуульд заасанчлан өндөр насны тэтгэвэр нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаагаар бүрэн болон хувь тэнцүүлсэн гэсэн төрөлтэй. Тэтгэврийн насанд хүрсэн² бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл 10–20 жилийн хугацаанд төлсөн даатгуулагчид хувь тэнцүүлсэн байдлаар, 20-оос дээш жил төлсөн даатгуулагчид бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүснэ.

Зураг 4. Өндөр насны тэтгэвэр авагчдын бүтэц, тэтгэврийн төрлөөр



Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

² Эмэгтэй 55, эрэгтэй 60 насанд хүрсэн иргэн

НДЕГ-ын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өндөр насны тэтгэвэр авч байгаа 369,301 иргэний мэдээллээс үзэхэд, нийт тэтгэвэр авагчдын 90.9 хувь нь бүрэн, 9.1 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр авагчид байна. Үүнээс үзвэл, өндөр насны тэтгэвэр авч байгаа 10 хүн тутмын 9 нь 241 сараас илүү хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлж, тэтгэврээ тогтоолгосон байна. Өндөр насны тэтгэврийн төрлийг хүйсээр харьцуулбал, эрэгтэй даатгуулагчдын 7.8 хувь, эмэгтэй даатгуулагчдын 9.8 хувь нь тус тус хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байна. Үүнээс үзвэл, эмэгтэйчүүд 10–20 жил нийгмийн даатгалын шимтгэл төлж, хувь тэнцүүлсэн байдлаар буюу харьцангуй бага дүнгээр тэтгэвэр тогтоолгодог жишиг өндөр байна.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуулийн 5 дугаар зүйлд өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхийг зааж, хөнгөлөлттэй нөхцөлүүдийг тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр нь тухайн хүний ажиллаж байсан салбар, эрхэлж байгаа ажлын онцлог, нөхцөл зэргээс хамааран ялгаатай, зарим тохиолдолд хөнгөлж үзэх нөхцөлтэй байдаг. Үүнтэй уялдан манай улсад тэтгэвэр тогтоож буй 14 ялгаатай нөхцөл байгаа бөгөөд эдгээрийг багцлан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо, хүйс ба тэтгэвэр тогтоолгосон нөхцөлөөр

№	Нөхцөл	Хүйс		Нийт
		Эрэгтэй	Эмэгтэй	
1	Энгийн	67,514	98,000	165,514
2	Олон хүүхэдтэй нөхцөл	–	92,515	92,515
3	Шимтгэл төлсөн хугацаанаас хамаарсан нөхцөл*	15,449	33,121	48,570
4	Малчин	18,424	13,853	32,277
5	Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл	19,197	10,801	29,998
6	Урлагийн байгууллага	165	160	325
7	Цэрэг, цагдаа, шүүх, хуулийн байгууллага	90	3	93
8	Бусад	5	4	9
Бүгд		120,844	248,457	369301

Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

*Тайлбар: Бүрэн тэтгэврийн доод хэмжээ болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байгаа даатгуулагчдыг хамруулав.

Нийт даатгуулагчдын 44.8 хувь нь ямар нэгэн хөнгөлөлтгүй нөхцөлөөр, үлдсэн 55.2 хувь нь ямар нэгэн хөнгөлөлт авах нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байна. Тэтгэвэр авагчдын 25.1 хувь нь буюу ¼ нь

олон хүүхэд төрүүлж өсгөсөн гэсэн нөхцөлөөр 5 жилийн өмнө тэтгэврээ тогтоолгожээ. Энэ нь эмэгтэйчүүдийн хувьд хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгосон даатгуулагчдын хувь өндөр гарахад нөлөөлсөн байна.

Даатгуулагчийн ажиллаж буй нөхцөл нь хэвийн бус буюу газрын дор, халуун, хортой, хүнд нөхцөлөөр нийт 30 орчим мянган хүн өндөр насны тэтгэврээ тогтоолгосон бөгөөд тэдний 2/3 нь, цэрэг, цагдаа, шүүх, Үндсэн хуулийн цэц зэрэг байгууллагад ажилласан нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгосон даатгуулагчдын 96.8 хувийг тус тус эрэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь уул уурхай, төмөр зам, барилга, цагдаа, онцгой байдал зэрэг салбарт эрэгтэйчүүд түлхүү ажилладагтай холбоотой.

Өндөр насны тэтгэврийн хэмжээ: Монгол Улсын хувьд 2023 онд шинэчлэн найруулсан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуулийн 6 дугаар зүйлд өндөр насны тэтгэврийг цалинд үндэслэсэн болон нэрийн дансны аргаар бодохоор заасан байна. Цалинд үндэслэн тогтоохдоо өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 45 хувиар ОУХБ тогтоож байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай” 102 дугаар конвенцод өндөр насны тэтгэврийн хэмжээг тэтгэврийн өмнөх цалин, орлогын хамгийн багадаа 40 хувийг нөхөхүйц байхаар тооцохыг зөвлөмж болгосныг эш үндэс болговол Монгол Улсад мөрдөж буй аргачлал нь конвенцын доод шаардлагыг хангаж байгаа юм (ОУХБ, 2016). Өөрөөр хэлбэл, ахмад настнуудын нийгмийн хамгааллын доод босгоос бага зэрэг дээгүүр хувиар өндөр насны тэтгэврийг тооцон олгож байна.

Тэтгэврийн хэмжээ харьцангуй өндөр тогтоогддог гэсэн үндэслэлээр өнөөгийн практикт даатгуулагчид цалинд суурилсан аргачлалаар өндөр насны тэтгэврээ тогтоолгох хандлагатай байгаа нь мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын явцад тодорхой болсон. НДЕГ-ын нэгдсэн санд бүртгэлтэй өндөр насны тэтгэврээ авагчид 100 хувь цалинд суурилсан аргаар өндөр насны тэтгэврээ тогтоолгосон нь үүнийг нотолж байна.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуулийн 5, 6 дугаар зүйлд өндөр насны тэтгэврээ нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааран бүрэн болон хувь тэнцүүлсэн гэсэн хэлбэртэй байж болох талаар тусгасан. Үүнээс тэтгэврийн насанд хүрсэн³, нийгмийн

³ Хөдөлмөрийн хэвийн нөхцөлийн хувьд 55 нас хүрсэн эмэгтэй, 60 нас хүрсэн эрэгтэйг тэтгэврийн насанд хүрсэн гэж ойлгох ба хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчид, малчид, олон хүүхэдтэй эхчүүд зэрэг тодорхой бүлэгт хөнгөлөлттэй нөхцөл үйлчилнэ.

даатгалын шимтгэлийг 20-оос дээш жил төлсөн даатгуулагчид бүрэн, тэтгэврийн насанд хүрсэн, 10–20 жилийн хугацаанд төлсөн даатгуулагчид хувь тэнцүүлсэн байдлаар тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байна. 2025 оны байдлаар бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689,000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 572,400 төгрөг байна.

Нийгмийн даатгалын сангаас олгож буй өндөр насны тэтгэврийн хэмжээг бүлэглэн үзвэл, тэтгэвэр авагчдын хамгийн өндөр хувийг бүрэн тэтгэврийн доод хэмжээний тэтгэвэртэй иргэд эзэлж байна.

Хүснэгт 9. Сарын дундаж тэтгэврийн хэмжээ, төгрөгөөр

№	Тэтгэврийн хэмжээ (төгрөг)	Тэтгэвэр авагчдын тоо	Хувь
1	572,400	30,953	8.4
2	572,401–688,999	2,674	0.7
3	689,000	183,981	49.8
4	689,001–850,000	39,232	10.6
5	850,001–1,000,000	28,769	7.8
6	1,000,001–1150000	27,193	7.4
7	1,150,001–1300000	19,589	5.3
8	1,300,001+	36,910	10.0
Нийт		369,301	100.0

Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо


Өндөр насны тэтгэвэр авч байгаа 2 хүн тутмын нэг нь (49.8 хувь) сард 689,000 төгрөгийн тэтгэвэр авдаг байна. Мөн хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээний тэтгэвэр авдаг иргэд багагүй буюу нийт тэтгэвэр авагчдын 8.4 хувийг эзэлж байгаа нь хувийн жингээр дөрөвдүгээрт орох дүн байна.

Ахмад настнуудын 60 орчим хувь нь бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээний тэтгэвэр авч байгаагаас үзвэл тэтгэврийн хэмжээ төдийлөн өндөр биш байна гэж дүгнэж болно.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Ийнхүү нийт даатгуулагчдын 58.2 нь доод хэмжээний тэтгэвэр авч байгаа бөгөөд тэтгэвэр тогтоолгосон нөхцөлөөр харьцуулбал, малчин, олон хүүхэдтэй эх зэрэг нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд 70-аас дээш хувь нь доод хэмжээний тэтгэвэр авч байгаа ажээ.

Зураг 5. Доод хэмжээний тэтгэвэр авч байгаа даатгуулагчдын хувь, тэтгэвэр тогтоолгосон нөхцөлөөр



Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

Энэ нь нийгмийн даатгалын шимтгэлийг 120–240 сарын хугацаанд төлөөд өндөр насны тэтгэвэр тогтоолгох хандлага түгээмэл байгааг илэрхийлнэ. Тухайлбал, малчдын хувьд хуулийн дагуу нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 насанд хүрсэн эрэгтэй, 20-оос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй нийгмийн даатгалын шимтгэл төлөөд тэтгэвэр тогтоолгосон иргэд 96.6 хувийг эзэлжээ.

Өндөр насны тэтгэвэр авагчдад 572.4–689 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг хүмүүс 5 хүн тутмын 3-ыг эзэлж байгаа нь өрхийн эдийн засагт үзүүлэх тэтгэврийн орлогын нөлөө бага, хувийн хэрэглээнд зарцуулагдахаас төдийлөн хэтрэхгүй байх талтайг харуулж байна.

Өндөр насны тэтгэвэр авагчдыг тэтгэврийн орлогоор бүлэглэсэн дээрх хүснэгтээс үзэхэд, доод хэмжээний тэтгэвэртэй иргэд 3/5-ыг эзэлж байгаагаас гадна даатгуулагчдын 77.3 хувь нь буюу дийлэнх нь сард сая хүрэхгүй төгрөгийн тэтгэвэртэй, дундаж тэтгэврийн хэмжээг тооцвол 865,123 төгрөг байна. Харьцангуй өндөр буюу улсын дундаж цалин болох 2,621,900 төгрөгөөс дээш тэтгэвэртэй 2,040 иргэн байгаа нь нийт тэтгэвэр авагчдын ердөө 0.6 хувийг эзэлж байна.

Өндөр насны тэтгэврийн хэмжээнд нөлөөлж буй хүчин зүйл: Тэтгэврийн хэмжээ ийнхүү ердөө 6 оронтой тоогоор хэмжигдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодруулахын тулд нийгмийн даатгалын салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдтэй ярилцлага хийсэн. Ярилцлагаар цуглуулсан чанарын өгөгдлөөс харахад өндөр насны тэтгэврийн хэмжээнд нөлөөлж буй хүчин зүйлийг дараах байдлаар тоймлож болохоор байна.

Зураг 6. Өндөр насны тэтгэврийн хэмжээнд нөлөөлж буй хүчин зүйл

Цалингийн түвшин	Хөдөлмөр эрхлэлт	Ажиллаж буй салбар	Хамрагдсан нийгмийн даатгалын төрөл	Боловсролын түвшин
Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа	Нас	Хүйс	Хүүхдийн тоо	Байршил
Тэтгэвэр тогтоож буй аргачлал	Тэтгэврийн төрөл	Тэтгэвэр тогтоож буй нөхцөл	Нөхөн даатгалд хамрагдалт	Тэтгэврийн нэмэгдэл


Эх сурвалж: Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын үр дүнд суурилсан ангилал

Тайлбар: Цэнхэр өнгөөр хувь хүний хүчин зүйл, шар өнгөөр бодлого, эрх зүйн хүчин зүйлийг тэмдэглэв.

Эдгээр хүчин зүйл нь өндөр насны тэтгэврийн хэмжээнд шууд болон дам нөлөөг үзүүлж байна. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуульд заасанчлан өндөр насны тэтгэврийн цалин, түүнтэй адилтгах орлогын хэмжээг суурь болгож, нийгмийн даатгалын шимтгэлийг 241 сараас илүү төлсөн бол илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар нэмэгдүүлэн олгож байгааг баримжаалбал, цалингийн түвшин болон шимтгэл төлсөн хугацаа нь шууд нөлөөтэй хүчин зүйл болно. Харин цалингийн түвшинд тухайн хүний ажиллаж буй салбар, албан тушаал, боловсролын түвшин зэрэг нь нөлөөлж болох тул эдгээр нь өндөр насны тэтгэвэрт дам нөлөөтэй хүчин зүйл болно.

Дээр дурдсанчлан өндөр насны тэтгэвэр нь бүрэн, хувь тэнцүүлсэн байж болох бөгөөд энэ нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон наснаас хамаарна. Мөн бодлого, эрх зүйн хувьд тэтгэврийн хэмжээг хэрхэн тогтоож, итгэлцүүр, индексээр хэрхэн нэмэгдүүлж байгаа нь тэтгэврийн хэмжээнд чухал нөлөөтэй юм. Иймд өндөр насны тэтгэврийн хэмжээнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг дундаж хэмжигдэхүүнд суурилан ялгаатай байдлыг тодорхойлох хандлагаар харьцуулсан шинжилгээ хийв.

Зураг 7. Дундаж тэтгэврийн хэмжээ, насны бүлэг ба хүйсээр



Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

Дундаж тэтгэврийн хэмжээ нь даатгуулагчийн нас, хүйс зэрэг хүн ам зүйн шинжээс хамаарч байна. Учир нь тухайн даатгуулагчдын нас нэмэгдэхийн хэрээр нийгмийн даатгалын шимтгэлийг харьцангуй урт хугацаанд төлж, сар бүр 0.125 хувиар нэмэгдэл тооцож авах боломжтой.

Тэтгэврийн насанд хүрмэгцээ өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нөхцөлд тухайн даатгуулагчийн тэтгэвэр бага тогтоно. Учир нь манай суурь хуульд шимтгэлийг хэн илүү төлнө, тухайн даатгуулагч 60 сарын дундаж цалингийн 45 хувиар тогтоосон дүн дээр 20-оос илүү жил ажилласан жил, сар тутамд бага боловч нэмэгдэл тооцон авах зохицуулалтыг тусгасан.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Хүйсийн хувьд эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн тэтгэврийн хэмжээ 7.8 хувиар өндөр байгаа нь нэг талаас цалингийн түвшин дэх жендэрийн ялгаанаас хамаарна. Тодруулбал, 2025 оны байдлаар эрэгтэйчүүдийн дундаж цалин эмэгтэйчүүдээс 17.7 хувиар өндөр байгаа нь цалинд суурилсан аргаар өндөр насны тэтгэвэр тогтоож буй нөхцөлд тэтгэврийн хэмжээ бага байхад нөлөөлнө.

Уул уурхай, мэдээллийн технологи зэрэг өндөр цалинтай салбар, удирдах албан тушаалд эрэгтэйчүүд түлхүү ажилладаг тул эмэгтэйчүүдтэй харьцуулахад дундаж цалин өндөр байдаг. Улмаар тэтгэврийн хэмжээ өндөр гарахад нөлөө үзүүлж байна. Мөн Дорноговь аймгийн хувьд төмөр зам, уул уурхай гэх мэт харьцангуй өндөр цалинтай салбарт ажил эрхэлж байгаад тэтгэвэр гарсан ахмадууд багагүй дүнтэй байдаг тул бусад аймаг, тухайлбал Сүхбаатар аймагтай харьцуулахад тэтгэврийн сангийн зарлага өндөр байдаг.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээл дээр хөдөлмөрийн үнэлгээ багатай салбарт цалин багатай ажил эрхэлдэг (ихэвчлэн үйлчилгээний салбарт), ар гэрийн амьдрал, хүүхэд төрүүлэх, өсгөх үүргээс хамааран хөдөлмөрийн зах зээл дээр тогтмол ажиллаж чаддаггүй, эрт тэтгэвэрт гардаг зэрэг нь ийнхүү эмэгтэй даатгуулагчдын тэтгэврийн хэмжээ харьцангуй бага байхад нөлөөлж байна.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль”-д олон буюу дөрвөөс дээш хүүхэдтэй, 50 нас хүрсэн эмэгтэйчүүд хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгох заалт бий. Гэвч бодит амьдрал дээр эрт тэтгэвэр тогтоолгосноор нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлсөн жил тутамд тооцох нэмэгдлийг авах боломжгүй болж, тэтгэврийн хэмжээ бага тогтоогдоход нөлөөлдөг.


Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Дундаж тэтгэврийн хэмжээ нь тэтгэврийн төрөл ба тэтгэвэрт гарсан нөхцөлөөр харьцуулан авч үзвэл нийгмийн даатгалын шимтгэлээ 241 сараас дээш хугацаанд төлж, бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэд сард ойролцоогоор 1.1 сая төгрөгийн тэтгэвэр авч байгаа бол хувь тэнцүүлсэн тэтгэврийн дундаж хэмжээ үүнээс 500 гаруй мянган төгрөгөөр доогуур байна. Энэ нь бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээг тооцож буй аргачлалтай холбоотой юм.

Миний хувьд эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. 20 настайгаасаа эхлэн 38 жил ажиллаж, тэтгэврээ тогтоолгосон боловч шилжилтийн ороо бусгаа үед ажилласан жил тасалдаж, ажилласан жил хүрээгүй шалтгаанаар бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр тогтсон. Тухайн үед ажиллаж байсан гэдгийг нотлох баримт олдоогүй тул тэтгэврээ нэмэгдүүлэх боломжгүй, сард 689 мянган төгрөгөөр амьжиргаагаа залгуулж байна.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Зураг 8. Дундаж тэтгэврийн хэмжээ, тэтгэврийн төрөл ба тэтгэвэрт гарсан нөхцөлөөр



Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

НДЕГ-ын даргын 2023 оны А/139 дугаар тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам”-д тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх, 1995 оноос өмнөх үеийн цалин хөлс нь архивын эсхүл санхүүгийн баримтаар нотлогдох боломжгүй бол үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлахаар зохицуулсан. Дээрх журамд иргэн 1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан цалин хөлснөөс тэтгэвэр тогтоолгохыг хүссэн тохиолдолд түүний тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх өөрт нь ашигтай дараалсан 5 жилийн цалин хөлсний талаар зөвлөж, уг хугацаанд авч байсан цалин хөлсний тодорхойлолтоор иргэний 1995 оноос өмнөх цалин хөлс нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд жишиг цалинг баримтлахаар заасан нь иргэдэд ээлтэй шийдвэр болж байна.

Даатгуулагчдын хувьд ирээдүйд тэтгэвэрт гарах үед тэтгэвэр хэр хэмжээтэй байх, энэ нь шимтгэл, цалин, ажилласан жилээс хэрхэн хамаарах, яаж бодогдох талаар төдийлөн ойлголт багатай. Дээрээс нь цалин хөдөлмөрийн хөлсөө зөв зохистой юм уу яг бодит цалингаас тооцуулна гэдэг ойлголт, ач холбогдлыг төдийлөн ойлгодоггүй учраас цалингаа бууруулж, шимтгэл төлснөөрөө дараа нь эргээд тэтгэвэрт гарахад бага тэтгэвэр болоод байдагтай холбоотой.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Эрт тэтгэвэр тогтоолгосон, 50 хүртэлх насны иргэдийн дундаж тэтгэврийн хэмжээ улсын дунджаас 330 гаруй мянган төгрөгөөр илүү байгаа нь цэргийн албан хаагч гэх мэт хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэрт гарсан, улмаар тэтгэврийг дундаж цалингийн 80 хувиар тооцуулдаг бүлэг багагүй байгаатай холбоотой.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд дундаж тэтгэвэр 577,303–3,463,643 төгрөг, хамгийн бага, хамгийн өндөр тэтгэврийн дундаж хэмжээ даруй 6 дахин зөрүүтэй байгааг харж болно. Энэхүү нөхцөл байдлыг арилгах хэрэгтэй гэж зарим мэргэжилтнүүд үзэж байгаа нь ярилцлагын явцад ажиглагдав.


Тэтгэвэр тогтоох аргачлалын хувьд 45–80 хувь гэж ялгаатай тогтоож байгаа нь шударга байдлын зарчмыг алдагдуулдаг. Үндсэн хуулийн цэцийнхэн 60 хувь, хууль, цэрэг, цагдаагийнхан 80 хувь, бусад иргэд 45 хувиар тогтоож байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийг адил дүнгээр төлсөн ч ялгаатай тэтгэвэр авах нөхцөлийг бий болгодог. Иймд салбарын хуулиар ялгаатай зохицуулах байдлыг залруулж, тэтгэвэрт гарч байгаа бүх иргэнд адил зохицуулалт үйлчилдэг байх тал дээр анхаарах нь зүйтэй.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Тэтгэвэр авагчдын дотор хамгийн олон буюу нийт 165,514 иргэн энгийн өндөр насны тэтгэвэр авч байгаа ба тэдний дундаж тэтгэвэр 954.8 мянган төгрөг байна. Үүнээс хэвийн нөхцөлд ажиллаж байгаад 241 сараас дээш нийгмийн даатгалын шимтгэл төлж, эмэгтэй 55, эрэгтэй 60 насанд хүрснээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэдийн дундаж тэтгэвэр ихэнх хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэрт гарсан иргэдээс даруй 115.5 мянгаас 2.3 саяар доогуур байгаа нь харагдана. Үүнээс тэтгэвэрт гарах хөнгөлөлттэй нөхцөлийг нэмэгдүүлж, тэтгэвэр тооцох аргачлалын ялгааг нэмэгдүүлэхийн хэрээр тэтгэврийн хэмжээнд ялгаа гарч байгааг харж болно.

Хуулиар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил тутамд тэтгэврийн хэмжээг жилд 1.5 хувиар нэмэгдүүлэн олгож байгаатай холбоотойгоор дундаж тэтгэврийн хэмжээ шимтгэл төлсөн хугацаагаар ялгаатай, шимтгэл төлсөн хугацаа нэмэгдэхийн хэрээр тэтгэврийн хэмжээ өссөн байдалтай байна.

Зураг 9. Дундаж тэтгэврийн хэмжээ, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон тэтгэвэрт гарсан оноор



Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

Ийнхүү шимтгэл төлсөн хугацаа нэмэгдэхийн хэрээр авч буй тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн нь бүтээмжийн шударга ёсны зарчим тодорхой хэмжээнд хангагдаж байгааг харуулж байна. Даяаршиж байгаа өнөөгийн нийгэмд даатгуулагчдын эрх ашгийг хангах үүднээс гадаад улсад ажилласан хугацааг тэтгэвэр тогтооход харгалзаж, хамрах хүрээг өргөжүүлэх ажил хийгдэж байна.

Нийгмийн даатгалын хэлэлцээр бүхий улс орнуудын тоо одоо 6 байгааг (БНСУ, ОХУ, Турк, Польш, Чех, Унгар) аль болох нэмэгдүүлж, эдгээр улс оронд ажиллаж байгаад ирсэн бол эх орондоо тэтгэвэр авах нөхцөл боломжийг бүрдүүлэхийг зорьж байна. Жишээ нь: ОХУ-д ажиллаж байгаад ирсэн бол ОХУ болон Монголд ажилласан жилийг нэгтгээд тэтгэвэр авах нөхцөл бүрдсэн. Одоо Казакстан, Австри улсуудтай хэлэлцээрийг үргэлжлүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Иргэдийн дунд тэтгэвэр тогтоолгосон хугацаанаас хамааран тэтгэврийн хэмжээ ялгаатай байгаа гэсэн ойлголт, хандлага түгээмэл байдаг. Ингэхдээ тэтгэврийн даатгалын шинэ тогтолцоонд шилжихээс үе буюу 1995 он, ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн хугацаа буюу 2010 он гэсэн хугацааг баримжаалан эдгээр оноос өмнө, хойно тэтгэвэр тогтоолгосноос хамааран тэтгэврийн хэмжээ ялгаатай гэж үздэг.

Миний хувьд эхнэртэйгээ хамт амьдардаг. Ерөнхий боловсролын сургуульд 37 жил багшаар ажиллаад 2010 онд гавьяаны амралтад гарсан. Тухайн үед тэтгэвэр цалингийн 45 хувь буюу 295 мянган төгрөгөөр тэтгэвэр тогтсон. Гэвч хамт ажиллаж байсан, 2010 оноос хойш тэтгэвэрт гарсан багш нарын тэтгэвэр харьцангуй өндөр тогтоогдож байгаад сэтгэл дундуур, адил хөдөлмөрт адил цалин хөлс гэсэн зарчим хангагдахгүй байна гэж үздэг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Иймд судалгааны хүрээнд тэтгэврийн дундаж хэмжээг тэтгэвэрт гарсан оноор нь харьцуулан үзэхэд, тодорхой ялгаатай байгааг дээрх зургаас харж болно. Тодруулбал, 2010 оноос тэтгэвэр тогтоолгосон бол дундаж тэтгэврийн хэмжээ 870 орчим мянган төгрөг, уг хугацаанаас өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд 840 орчим мянган төгрөг авч байна. Харин 2023 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд харьцангуй өндөр дүнгээр тогтоолгосон нь харагдаж байна.

2023 оны 7 сард итгэлцүүрээр нэмэгдүүлэхдээ цалингийн түвшинг 2023 оны 7 сарын түвшинд аваачих байдлаар тооцоолол хийж, тэтгэвэрт эрт, орой гарснаас хамааран зөрүү багатай, зөв бодож тооцоход онцгой анхаарсан. 1995 онд 14.000 төгрөг авч байсан хүний цалин 2023 онд 2.4 сая байсан тул дүйцүүлэх байдалтайгаар зөрүү багатай байдлаар тэтгэвэр нэмэх ажлыг зохион байгуулсан гэж ойлгож болно.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/136 дугаар тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин”-г тогтоосон нь тэтгэвэр тогтоолгох иргэний ажил хөдөлмөр хэдэн онд ажиллаж байсантай холбоотой саналын зөрүүг арилгах нэг үндэслэл болсон.

Тэтгэврийн хэмжээ нь тухайн хүний авч байсан цалин хөлс, ажилласан хугацаанаас хамааралтай тогтоогддог учраас харилцан адилгүй байдаг. Нэг цаг хугацаанд тэтгэврээ тогтоолгосон адил ажил мэргэжлийн хоёр хүний аль олон жил ажилласан буюу шимтгэл төлсөн бөгөөд тэтгэврээ тогтоолгохдоо сонгосон сүүлийн 20 жилийн доторх дараалсан 60 сарын цалин нь өндөр байсан хүний тэтгэвэр харьцангуй өндөр тогтоогдоно. Энэ мэт хөдөлмөрийн үнэлэмж буюу цалин хөлсөнд гарсан өөрчлөлттэй холбоотойгоор тэтгэврийн хэмжээ ялгаатай тогтоогдохыг зүй ёсны гэж үзнэ. Харин адилхан ажил мэргэжилд ойролцоо цалинтай, ажилласан хугацаа нь ижил хүмүүс тэтгэврээ хэзээ тогтоолгосноосоо хамаараад тэтгэвэр нь зөрүүтэй тогтоогдсон байвал энэ зөрүүг багасгах, арилгах арга хэмжээ авах шаардлага бий болдог бөгөөд үүнд итгэлцүүрийн аргыг хэрэглэдэг.

Иргэд эрхэлж буй ажил, хөдөлмөрийн онцлогоос хамааран албан журмаар болон сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл төлөх боломжтой. Албан журмын даатгалыг цалингийн орлогоос суутгадаг бол орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн хувьд сайн дураар даатгуулж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувиас багагүй дүнгээр нийгмийн даатгалын шимтгэл төлдөг.

НДЕГ-ын санд бүртгэгдсэн 369,301 иргэний мэдээллээс үзэхэд, даатгуулагчид дунджаар 318 сар буюу 26.5 жил нийгмийн даатгалын шимтгэл төлж байна. НДЕГ-ын мэдээллийн санд тухайн тэтгэвэр авагч даатгалын ямар төрөлд хамрагдсан талаарх мэдээлэл дутмаг байсан тул санал асуулгын судалгаагаар дундаж тэтгэвэр нь даатгалын төрлөөс хэрхэн хамаарч байгааг тодруулсан болно.

Зураг 10. Дундаж тэтгэврийн хэмжээ, нийгмийн даатгалын төрөл болон тэтгэвэрт гарах үеийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тайлбар: Санал асуулгын судалгаанд малчид зэрэг бага тэтгэвэртэй бүлэг хамрагдаагүй тул тэтгэврийн хэмжээ НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцооноос өндөр гарсан.

Ингэхэд, сайн дураар даатгуулагчид гол төлөв хамгийн бага дүнгээр нийгмийн даатгалын шимтгэл төлж, улмаар тэтгэврийн хэмжээ бага тогтоогдох үндэс болж байна. Энэ нь ажилгүйчүүд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зэрэг бүлгийн тэтгэврийн хэмжээ харьцангуй бага байгаатай уялдаж байна. Хууль эрх зүйн талаар мэдээлэлтэй иргэдийн хувьд сүүлийн 5 жилд өндөр дүнгээр шимтгэл төлөөд илүү тэтгэвэр тогтоолгосон, эсвэл нөхөн даатгалд хамрагдаж, тэтгэврээ тогтоолгосон кейс цөөнгүй байна. Харин ямар нэгэн цалинтай хөдөлмөр эрхлэгчид, тухайлбал, төрийн албан хаагчид,

тэр дундаа төрийн тусгай болон захиргааны албан хаагчдын тэтгэврийн хэмжээ дунджаас 16.8–54.9 хувиар өндөр байна.

Төрийн үйлчилгээ, нутгийн захиргаа зэрэг жирийн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан тохиолдолд дундаж цалингийн 45 хувиар тэтгэвэр тогтоодог. Гал сөнөөгч, хил хамгаалагч зэрэг амь насаараа дэнчин тавьж ажилладаг хүмүүсийн тэтгэврийг 80 хувиар тогтоох нь зүйтэй боловч тухайн салбарт ажиллаж байгаа бүх хүнийг хамруулан өндөр тэтгэвэр тогтооно гэдэг нь шударга бус санагддаг.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Иргэд, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд ажил, хөдөлмөр хийж, улсад хувь нэмэр оруулаагүй хүмүүс сүүлийн жилүүдэд өндөр дүнгээр шимтгэл төлөөд өндөр тэтгэвэр тогтоолгодог байдалд нэлээн шүүмжлэлтэй хандаж байсан.

Нийгмийн даатгалын суурь зарчим бол өндөр дүнгээр шимтгэл төлсөн нөхцөлд өндөр өгөөж хүртэх явдал юм. Гэвч нөхөн даатгал буюу 78120 төгрөг нөхөн төлөөд, сар бүр тэтгэвэр авч байгаа асуудал тэгш, шударга байдлын зарчимд харшилна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Нэгэнт тогтсон өндөр насны тэтгэврийн худалдан авах чадварыг хадгалахын тулд холбогдох бодлого, хуульд заасны дагуу итгэлцүүрээр болон индексжүүлэн нэмэгдүүлдэг. Нийгмийн даатгалын шинэ тогтолцоо бүрдсэн үе буюу 1994 оноос хойш Засгийн газрын тогтоолоор тэтгэврийг нийт 41 удаа өөрчлөн тогтоожээ. Энэ нь өндөр настнуудын худалдан авах чадварыг бууруулахгүй байх, амьдралын чанарыг дээшлүүлэх тал дээр Засгийн газраас тодорхой арга хэмжээ авсаар ирсний баталгаа юм.

Өндөр настны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Засгийн газрын тогтоолыг сүүлийн 5 жилийн байдлаар тоймлон харвал, бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоож байна. Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаагчийн тэтгэврийн доод хэмжээг 2020 онд 350,000, хувь тэнцүүлэн тооцох тэтгэврийн доод хэмжээг 300,000 төгрөгөөр тогтоож байсан бол 2025 оны байдлаар бүрэн тэтгэврийн доод хэмжээг 2025 онд 689,000 төгрөг, хувь тэнцүүлэн тооцох тэтгэврийн доод хэмжээг 572,400 төгрөгөөр тогтоосон байна.

Тэтгэврийн доод хэмжээнд оруулсан өөрчлөлтийн нөлөөгөөр сүүлийн 15 жилийн байдлаар авч үзвэл сонгосон хугацааны эхэн болох 2010 онд бүрэн тэтгэвэр 105,300 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэвэр 70,200 төгрөг байсан нь

2025 онд бүрэн тэтгэвэр 6.5 дахин нэмэгдэж 689,000 төгрөг, харин хувь тэнцүүлсэн тэтгэвэр 8.1 дахин нэмэгдэж 572,400 болсон.

Зураг 11. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Засгийн газрын тогтоолын тойм, сүүлийн 5 жилээр

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 2020.01.22, ЗГ-24 дугаар тогтоол

- НДС-аас олгох болон цэргийн алба хаасны 500,000 хүртэлх төгрөгийн тэтгэврийг 30,000 төгрөгөөр, 500,000 болон түүнээс дээш төгрөгийн тэтгэврийг 25,000 төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх;
- НДС-аас олгож байгаа бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 350,000, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 300,000 төгрөгөөр шинэчлэх;

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 2022.02.01, ЗГ-63 дугаар тогтоол

- НДС-аас олгож байгаа болон цэргийн тэтгэврийг 15 хувиар нэмэгдүүлэх;
- НДС-аас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 500,000, НДС-аас олгох хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400,000 төгрөгөөр шинэчлэх;

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 2023.06.21, ЗГ-239 дугаар тогтоол

- НДС-аас олгож байгаа болон цэргийн тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлэх;
- НДС-аас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 550,000, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 440,000 төгрөгөөр шинэчлэх;

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 2024.03.20, ЗГ-120 дугаар тогтоол

- НДС-аас олгож байгаа болон цэргийн тэтгэврийг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлэх;
- НДС-аас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 650,000, НДС-аас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 540,000 төгрөгөөр тус тус шинэчлэх;


Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 2024.12.18, ЗГ-221 дүгээр тогтоол

- Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 689,000 төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572,400 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоох.

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, www.legalinfo.mn-ын мэдээлэлд суурилсан нэгтгэл

2020 оноос хойш буюу сүүлийн 5 жилийн байдлаар бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн зөрүү бага зэрэг нэмэгдэж, 16–25 хувь болсон нь харагдаж байна.

Зураг 12. Бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ (мян.төгрөгөөр) 2010–2025 он



Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

Энэ мөнгөөр 1 хүн амьдарч чадахгүй байх. Нэг өрхөд хоёр өндөр настан амьдардаг гэж бодоход нэг нь нас барахад тухайн өндөр настны тэтгэврийг 20% нэмж өгөхөөр 826,800 төгрөг 1 хүн амьдрахаар боломжгүй юм. Статистикаас энэ бүгдийг харах нь зөв болов уу? Нэг хүн сард хэдэн төгрөгийн зардал гаргаж байгааг харж болно.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Тэтгэвэр нэмэгдүүлэх тогтоолуудтай уялдан өндөр насны тэтгэврийн хэмжээ өмнөх онуудаас 6.2–42.9 хувиар нэмэгдсэн харагдаж байна.

Зураг 13. Тэтгэврийн нэмэгдэл, өсөлтийн хувиар 1997–2024 он, өмнөх онтой харьцуулсан дүнгээр



Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сангийн өгөгдөлд суурилсан тооцоо

Өндөр насны тэтгэвэрт сүүлийн 8–9 жилд хийгдээгүй ажил буюу тэтгэврийг итгэлцүүрээр нэмэгдүүлэх ажлыг 2023 оны 7 сард хийж, 2024 оноос эхлэн жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлж байхаар тусгасан. Итгэлцүүрээр ингэж нэмэгдүүлэхдээ цалингийн түвшинг 2023 оны 7 сарын түвшинд аваачих байдлаар тооцоолол хийж, тэтгэвэрт эрт, орой гарснаас хамааран зөрүү багатай, зөв бодож тооцоход онцгой анхаарсан байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг 1994–2024 оны хугацаанд нийт 7 удаа шинэчлэн тогтоосон байна. Бусад валюттай харьцах төгрөгийн ханш унаж, худалдан авах чадвар буурсантай уялдуулан цалингийн доод түвшинг шинэчлэн тогтоосон нь тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрт өөрчлөлт оруулах суурь шалтгаан юм. Тэтгэвэр бодох цалингийн орлогын итгэлцүүрийг 2014 оноос 2023 он хүртэлх хугацаанд өөрчлөлт хийгээгүй бөгөөд 2023, 2024 онуудад дараах байдлаар шинэчлэн тогтоосон байна.

Зураг 14. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн шинэчлэл

Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2023.06.21, ЗГ-238 дугаар тогтоол

- Даатгуулагчид НДС-аас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд 1,404,000 (нэг сая дөрвөн зуун дөрвөн мянга) төгрөгөөр, мөн өдрөөс хойших хугацаанд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тус тус тооцох;

Итгэлцүүр тогтоох тухай 2024.01.10, ЗГ-10 дугаар тогтоол

- Даатгуулагчид НДС-аас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2011 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 1 дүгээр тогтоолд заасан сарын дүнг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, мөн өдрөөс хойш 2023 оныг дуустал хугацаанд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойших хугацаанд албан журмын даатгуулагчийн хувьд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тус тус тооцох;

Эх сурвалж: НДЕГ-ын мэдээнд суурилан судлаачид боловсруулав.

Өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэхдээ өндөр тэтгэвэртэй иргэдийн хувьд бага дүнгээр нэмэгдүүлдэг жишиг байгаа талаар иргэд дурдаж байсан.

ҮСХ-ны мэдээлснээр ажиллагчдын сарын дундаж цалин 2,621,900 төгрөг байгаа гэсэн статистиктай харьцуулахад өндөр насны тэтгэвэр нь нийт

цалингийн 33.0 хувьтай тэнцэж байна. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуулийн дагуу өндөр насны тэтгэврийг дундаж цалингийн 45 хувиар тогтоохоор заасан боловч бодит байдал дээр даруй 12 пунктээр доогуур байгаа нь тодорхой байна. Энэ нь тэтгэврийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлж, тэтгэврийн худалдан авах чадварыг хадгалах практик хоцрогдож байгааг харуулна.

2025 оны байдлаар амьжиргааны доод түвшин бүсээс хамааран 482,900–495,400 төгрөг байгаа ба дундаж тэтгэвэр амьжиргааны доод түвшнээс ойролцоогоор 1.7 дахин өндөр байна. Энэ нь өндөр насны тэтгэврээр зөвхөн өөрийн суурь хэрэгцээг хангахуйц нөхцөл байдалтай байгааг илтгэнэ.

4.2. Өндөр насны тэтгэврийн талаарх үнэлгээ, сэтгэл ханамж

Өндөр насны тэтгэврийн хэмжээ, ажилласан жил, төлсөн нийгмийн даатгалын хэмжээтэй нийцтэй эсэх, өндөр насны тэтгэвэрт гарснаар өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт, нөлөөллийн талаарх ахмад настнуудын үнэлгээ, сэтгэл ханамжийн байдлыг танилцуулна.

Судалгаанд хамрагдагчдын шинж байдал: Судалгааны 4.2–4.5 дугаар зүйлийн боловсруулалт, шинжилгээнд санал асуулгын судалгааны өгөгдлийг суурь болгон ашигласан тул санал асуулгын судалгаанд хамрагдагчдын шинж байдлыг дараах үндсэн үзүүлэлтээр тоймлон авч үзлээ.


Хүснэгт 10. Санал асуулгын судалгаанд хамрагдагчдын шинж байдал, тоо ба хувиар

Шинж байдал	Тоо	Хувь
Нас		
65 хүртэл	123	51.2
66–75	81	33.8
76–85	30	12.5
86+	6	2.5
Хүйс		
Эрэгтэй	71	29.6
Эмэгтэй	169	70.4
Өрхийн ам бүлийн тоо		
1	24	10.0
2	48	20.0
3–5	148	61.7
6+	20	8.3
Нийт	240	100.0

Санал асуулгын судалгаанд Баянзүрх, Сүхбаатар дүүрэг, Сэлэнгэ, Дорноговь аймгаас нийт 240 иргэн хамрагдсан бөгөөд насны хувьд бүх насны төлөөлөл хамрагдсан бол хүйсийн хувьд эмэгтэйчүүд түлхүү хамрагдсан байна. Нийт судалгаанд хамрагдагчдын 30.0 хувь нь ганцаараа болон хоёулаа амьдардаг бол 70.0 хувьд нь 3-аас дээш ам бүлтэй өрхөд амьдарч байна.

Өндөр насны тэтгэврийн хэмжээний талаарх сэтгэл ханамж: Өндөр насны тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын сэтгэл ханамж харилцан адилгүй байна. Судалгаанд оролцогчдын 26.7 хувь нь сэтгэл ханамжийн түвшнээ “дунд” буюу тэтгэвэр зарим үндсэн хэрэгцээг хангадаг ч эдийн засгийн аюулгүй байдлыг бүрэн хангадаггүй гэж үзсэн бол 41.3 хувь нь “бага” болон “огт сэтгэл ханамжгүй” гэжээ.

Зураг 15. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын үнэлгээ, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Дээрхээс үзвэл ахмад настнуудын дунд тэтгэврийн хэмжээндээ дунд болон бага түвшинд сэтгэл ханамжтай байдал давамгайлж, эдийн засгийн аюулгүй байдал, амьдралын чанарт санаа зовних байдал ажиглагдаж байна.

Би ам бүл зургуулаа, хүү, ач зээтэйгээ амьдардаг. Сард 1,200,000 төгрөгийн тэтгэвэртэй. Тэтгэврээсээ орон сууцны ашиглалтын зардлаа төлөөд, хоол хүнсээ базаадаг. Эрүүл мэндийн байдал харьцангуй сайн тул тул эм тариа бараг авдаггүй. Хувцас хунар ч худалдаж авдаггүй. Хүүхдүүд нь аваад өгчихдөг. О эзэмшсэн инженер мэргэжлээ ашиглан зарим газруудад зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Үүний үр дүнд тогтмол цалин аваад байдаггүй ч нэмэлт орлого хаяадаа олчихдог. Одоогийн авч байгаа тэтгэврийн хэмжээг бодитой эсэхэд эргэлзэж явдаг. Учир нь ажилласан хугацаа, төлсөн татвартайгаа харьцуулаад үзвэл тэтгэврийн хэмжээ өнөөдрийнхөөс хавьгүй илүү байх боломжтой гэсэн бодлыг тээж явдаг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

**Хүснэгт 11. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын үнэлгээ (хувь),
байршил ба тэтгэврийн төрлөөр**

Үзүүлэлт	Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Сэтгэл ханамжгүй	Нийт
Байршил						
Нийслэл	6.7	15.8	34.2	21.7	21.7	100.0
Аймгийн төв	11.7	25.0	23.3	25.0	15.0	100.0
Сумын төв	16.7	30.0	15.0	18.3	20.0	100.0
Тэтгэврийн төрөл						
Бүрэн	10.9	21.8	27.5	21.8	18.0	100.0
Хувь тэнцүүлсэн	6.9	20.7	20.7	20.7	31.0	100.0


Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тэтгэврийн хэмжээний талаарх үнэлгээ нь байршлаас хамаарч мэдэгдэхүйц ялгаатай байгаа бөгөөд нийслэлээс судалгаанд хамрагдсан ахмад настнуудын дунд тэтгэврийн хэмжээний талаарх сэтгэл ханамжгүй буюу сөрөг үнэлгээ давамгайлж байгаа нь хотод амьжиргааны өртөг, хэрэглээ өндөр байдагтай холбоотой. Тодруулбал, тэтгэврийн хэмжээндээ маш их болон их сэтгэл ханамжтай ахмадуудын хувь нийслэлд 22.5 хувь байхад аймгийн төвд 36.7 хувь, сумын төвд 46.7 хувь байна.

Тэтгэврийн төрлөөр харьцуулан үзэхэд хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ 572.4–689.0 мянга байгаагаас хамаарч хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгосон иргэдийн сэтгэл ханамж бүрэн тэтгэвэртэй иргэдээс доогуур байна. Харин бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689 мянган төгрөг, дундаж хэмжээ ойролцоогоор 1.1 сая төгрөг байгаа нь эдгээр иргэдийн 1/3 нь маш их болон их сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ өгөхөд хүргэсэн.

Нийгмийн даатгалын төрлөөр харьцуулахад, сэтгэл ханамж өндөр байгаа хариулагчдын хувь ойролцоо байна. Сайн дураар даатгуулж буй 2 хүн тутмын нэг нь тэтгэврийн хэмжээндээ сэтгэл ханамж багатай болон огт сэтгэл ханамжгүй байгаа нь анхаарал татаж байна.

Зураг 16. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын үнэлгээ, даатгалын хэлбэрээр, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Өндөр насны тэтгэврийн хэмжээний талаар 12 иргэнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагад агуулгын шинжилгээ хийж үзвэл, сард авч буй тэтгэврийн хэмжээ нь 689,000 (n=4), 900,000, (n=2), 1,2–1.6 сая төгрөгийн хооронд (n=6) хэлбэлзэж байна. Тэтгэврийн хэмжээ хангалттай байх нь ядуурлаас зайлсхийх, үр хүүхдүүдээсээ хараат бус хүний дайтай амьдрах суурь нөхцөл болдог.

Ярилцлагад оролцогчдын цөөн хэсэг нь тэтгэврийн мөнгөөрөө суурь хэрэгцээгээ хангадаг (n=3) гэж хариулжээ. Тэгвэл ихэнх нь эрүүл мэндийн зардал гарах, баяр ёслол тохиох зэрэг онцгой зардал гарч ирэх тохиолдолд тэтгэврийн мөнгө нь хүрэлцдэггүй (n=7) гэсэн байр суурьтай байна. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн мөнгө нь өрхийн хоол хүнс, байр, цахилгаан зэрэг суурь хэрэгцээг хангахад нөлөө үзүүлж байгаа боловч амьдралын чанарыг илэрхийлэх нийгмийн оролцоо, чөлөөт цаг, хувийн хэрэгцээгээ хангахад огт хүрэлцэхгүй байна. Тэмдэглэлт баяр ёслолыг тэмдэглэх, эрүүл мэндийн зардал шаардагдах үед тэтгэвэр хэрэгцээг нь хангахаа больж ахмад настнуудад санхүүгийн дарамт үүсдэг.

2013 онд 700 мянган төгрөгөөр тэтгэврээ тогтоолгосон. Одоо нэмэгдээд 1.6 сая төгрөг болсон. Нөхөр 2011 онд суусан, одоогоор 1.5 сая төгрөгийн тэтгэвэртэй. Амьдралд хүрэлцээ багатай. Мэдээж суурь шинжтэй буюу хоол хүнс гэх мэт хэрэгцээнд хүрдэг ч, цагаан сар зэрэг томоохон баяр, эсвэл гэр бүлийн гишүүдэд өндөр зардал гарахаар бол авдаг хэд маань хүрдэггүй.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Хүснэгт 12. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настуудын үнэлгээ (хувь), хүйсээр

Хүйс	Сэтгэл ханамжийн түвшин					Нийт
	Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Огт сэтгэл ханамжгүй	
Эрэгтэй	9.9	25.4	32.4	16.9	15.5	100.0
Эмэгтэй	10.7	20.1	24.3	23.7	21.3	100.0

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тэтгэврийн хэмжээний тухайд эрэгтэйчүүдийн 32.4 хувь нь дунд, 32.4 хувь нь бага болон огт сэтгэл ханамжгүйгээ илэрхийлсэн бол эмэгтэйчүүдийн 24.3 хувь нь дунд, 45 хувь нь бага болон огт сэтгэл ханамжгүй гэж хариулжээ. Эрэгтэйчүүдийн 64.8 хувь, эмэгтэйчүүдийн 69.3 хувь нь тэтгэврийн хэмжээндээ дунд болон түүнээс дээш сэтгэл ханамжтай байгаа нь (ялгаа 4.5 хувь) эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, цалингийн түвшин, ажилласан жил зэрэг хүчин зүйлтэй холбоотой.

Хүснэгт 13. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настуудын үнэлгээ, боловсролын түвшин, хувиар

Боловсролын түвшин	Үнэлгээ				Нийт
	Маш их, их	Дунд	Бага	Огт үгүй	
Боловсролгүй	–	50.0	50.0	–	100.0
Бага	33.3	11.1	44.4	11.1	100.0
Дунд	28.6	27.3	20.8	23.4	100.0
Тусгай мэргэжил	33.3	18.3	25.0	23.3	100.0
Дээд	34.9	34.9	14.5	15.7	100.0

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо


Тэтгэврийн хэмжээний хувьд “маш их” болон “их” гэсэн сэтгэл ханамжийн үнэлгээ боловсролын түвшин нэмэгдэх тусам бага зэрэг өсөх хандлага ажиглагдав.

Өрхийн ам бүлийн тоог өндөр насны тэтгэврийн хэмжээний талаарх сэтгэл ханамжийн түвшинтэй харьцуулан үзэхэд ам бүлийн тоо нэмэгдэхийн хэрээр сэтгэл ханамж “дунд” болон “их” түвшинд гэсэн хариулт давамгайлж, огт ханамжгүй гэсэн хариултын хувь хэмжээ буурч байна. Ганцаараа амьдардаг ахмад настуудын хувьд “бага” болон “огт сэтгэл ханамжгүй” гэсэн хариултын эзлэх хувь хэмжээ нэмэгдэж байгааг нэмэлт орлого болон бусдаас авдаг дэмжлэг багатай холбон тайлбарлаж болох юм.

Өндөр насны тэтгэврийн хэмжээ бодитой эсэх талаарх үнэлгээ: Санал асуулгад “Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн

шимтгэлийн хэмжээтэй хэр нийцэж байна вэ?” гэсэн асуултыг оруулж, ахмад настнуудын үзэл бодлыг тандсан юм.


Зураг 17. Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Ахмад настнуудын 35.4 хувь тэтгэврийн хэмжээ нь ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцгүй, 34.2 хувь нь бүрэн болон зарим талаар нийцтэй гэсэн бол 30.4 хувь нь энэ асуултад мэдэхгүй гэж хариулжээ. Үүнээс, арван ахмад настан тутмын гурав нь өндөр насны тэтгэврийн хэмжээ нь ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал хангалтгүй, шударга ёсны зарчмын хэрэгжилт хангалтгүй гэж үзсэн.


Зураг 18. Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал, байршил, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тэтгэвэр нь ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэхгүй байна гэж үзсэн хувь хөдөө орон нутагт 50 хувь, хотод 45.8 хувь байна. Энэ нь нийт иргэдийн тал орчим хувь нь тэтгэврийн хэмжээ нь “ажилласан жилтэй харьцуулахад бага байна” гэж үздэгийг нотлон харуулж байна.

Зураг 19. Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал, нийгмийн даатгалд хамрагдалтаар, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Албан журмын даатгалд хамрагдаж байсан ахмад настнуудын хувьд тэтгэврийн хэмжээ нь төлж байсан шимтгэлтэй нийцэж байгаа гэсэн үнэлгээ харьцангуй өндөр (бүрэн нийцтэй 12.6 хувь, зарим талаар нийцтэй 24.6 хувь) байгаагаас гадна нийцтэй бус гэж үзсэн хувь ч өндөр байна (35.1 хувь).

Албан журмын даатгалд хамрагдаж байсан ахмадуудтай харьцуулахад (27 хувь) сайн дурын даатгалд хамрагдагсдын хувьд төлсөн шимтгэл, ажилласан жил нь тэтгэврийн хэмжээтэй нийцэж байгаа эсэх талаарх “мэдэхгүй” гэсэн хариулт (40.8 хувь) өндөр байгаа буюу мэдээлэл дутмаг байгааг харуулав. Эрэгтэйчүүдтэй (33.8 хувь) харьцуулахад эмэгтэйчүүдийн (36.1 хувь) тэтгэврийн хэмжээ нь ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцээгүй гэж хариулсан хувь 2.3 пунктээр өндөр байна.

Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдлыг илэрхийлэх тоон судалгааны үр дүнг нягтлах зорилгоор иргэдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагад шинжилгээ хийж үзвэл дийлэнх нь тэтгэвэр бодитой, шударга тогтоогдоогүй гэж үзэж, шалтгааныг нь дараах хүчин зүйлтэй холбон тайлбарласан. Үүнд нэгдүгээрт, ажилласан жил, архивтай холбоотой асуудал (Жишээ нь: “Манай төрсөн ахын... байгууллагын архивын материал шатаад 70–80 хүн хохирч, бүгд бага тэтгэвэр тогтоогдсон”). Хоёрдугаарт, эдийн засгийн нөхцөл боломж, бодлогын тодорхой бус байдал (Жишээ нь: “Улс орон эдийн засгийн боломжгүй, бодлого тодорхойгүй”). Гуравдугаарт, цалин ба амьжиргаатай холбоотой бодит үнэ цэн (Жишээ нь: “Миний цалин бага байсан тул тэтгэвэр бага тогтоогдсон”). Дөрөвдүгээрт, тэтгэвэр нэмэгдүүлэх механизм эргэлзээтэй байдал (Жишээ нь: “Тэтгэврийг итгэлцүүрээр нэмэгдүүлэхдээ 1404 мянгаар хязгаар тогтоож

нэмэгдүүлснээс хамаараад харьцангуй өндөр тэтгэвэр авдаг байсан хүмүүс хохирсон”) гэх мэт.

Албан байгууллагын хариуцлагагүй байдлаас хамаараад шилжилтийн үед ажил, хөдөлмөр эрхэлж байсан баримт нотолгоо олдоогүй тул эхнэр нь 20 жилээс илүү ажилласан ч илүү ажилласан жил тутамдаа 1.5 хувиар нэмэгдүүлэн тэтгэвэр авах боломжгүйд хүрсэн.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Хүснэгт 14. Өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцэх байдал, насаар

Насны бүлэг	Нийцэл				Нийт
	Бүрэн нийцтэй	Зарим талаар нийцтэй	Нийцтэй бус	Мэдэхгүй	
65 хүртэл	16.3	23.6	35.8	24.4	100.0
66–75	9.9	19.8	28.4	42.0	100.0
76–85	–	23.3	56.7	20.0	100.0
86+	–	33.3	16.7	50.0	100.0

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Бусад насны бүлэгтэй харьцуулахад 76–85 насныхан өндөр насны тэтгэврийн хэмжээ ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй нийцдэггүй гэсэн хариултыг (56.7 хувь) түлхүү өгсөн. Өөрөөр хэлбэл, 76–85 насныхны дунд тэтгэврийн тогтолцооны шударга, тэгш байдлын талаарх итгэл буурсан хандлага ажиглагдав.

Ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс үзэхэд ахмад настнуудын амьдралын баталгаа нь гэр бүлийн орлого, дэмжлэгээс ихээхэн хамааралтай байна. Цөөн хэсэг нь ганцаар амьдардаг, эрүүл мэнд сайн тохиолдолд тэтгэвэр боломжийн (n=2) гэсэн бол ихэнх нь тэтгэврийн хэмжээндээ сэтгэл ханамжгүй (n=10) байв.

Тэтгэврийн орлогоо аль болох зөв зарцуулж, орлогодоо захирагдах байдлаар зарлагаа төлөвлөж, зохицуулж амьдрахыг хичээдэг. Хэрэв ганцаараа 1.2 сая төгрөгийн тэтгэвэр авдаг байсан бол одоохондоо хэрэгцээгээ хангаад байх талтай.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Ахмад настнуудын амьдралын баталгаа нь гэр бүлийн орлого, дэмжлэгээс ихээхэн хамааралтай, ганцаараа амьдрах тохиолдолд тэтгэвэр хүрэлцдэггүй хүндрэл үүсдэг. Тэтгэвэр нь ахмад настнуудын өдөр тутмын хэрэгцээг хангах түвшинд байдаг ч баяр ёслол тэмдэглэх, эрүүл мэндээ анхаарах, нийгмийн


харилцаанд орох тохиолдолд хүрдэггүй. Инфляцын өсөлт, амьжиргааны доройтол, нэмэлт орлого олох боломж зэрэг нь тэтгэврийн хэмжээний зохист байдлыг хумих нөхцөл болдог.

Эхнэр, бид хоёр хоёулаа тэтгэврийн доод хэмжээ буюу сард 689 мянган төгрөг авдаг. Тэтгэврээр хэрэгцээ хангах боломж байхгүй. Ер нь хоол унд, түлээ, эм тарианд зарцуулаад дуусдаг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Өндөр насны тэтгэврийн талаар ойлголт: Ганцаарчилсан ярилцлагын агуулгын шинжилгээнд тулгуурлан тэтгэврийн талаарх ахмад настны үзэл бодлыг тоймлон зурагт үзүүлэв.

Зураг 20. Тэтгэврийн хэмжээний талаарх ахмад настнуудын ойлголт, үзэл бодол



Өндөр настнууд тэтгэврийг сар бүр тогтмол орж ирдэг, найдвартай санхүү, амьжиргааны гол эх үүсвэр гэж дийлэнх нь үзэж байна. Шаардлагатай тохиолдолд зээл авах баталгаат эх үүсвэр болгон ашигладаг гэжээ. Түүнчлэн хөдөлмөр эрхлэхгүйгээр орж ирдэг орлого гэдэг утгаар төрөөс өгч буй хүндэтгэлийн илэрхийлэл буюу “төрийн хишиг” хэмээн үнэлж байна.

Тэтгэврийн хэмжээ их, бага, гэдгээс илүүтэй төрөөс өгч буй хишиг гэж ойлгож, хүлээн авдаг. Сар бүрийн 1-ний өдөр бол ахмад настан бидний хувьд нэг талаар баярын өдөр гэж хэлж болно.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Түүнээс гадна ахмад настнууд тэтгэврийг үндсэн хэрэгцээг нь хангах төдий гэж үзэж байна. Ажил хийх, жижиг бизнес эрхлэн нэмэлт орлого олох тохиолдолд тэтгэвэр нь хүрэлцдэг. Хүүхдүүдийн дэмжлэгт ихээхэн түшиглэдэг ч “хүүхдүүддээ дараа болохгүй байх” гэсэн хандлага хүчтэй илэрч байна. Ахмад настнууд өдөр тутмын хэрэглээнд хэмнэлттэй хандаж, зардлаа байнга тооцож байдаг ч сарын эцэст мөнгө нь дуусах нь элбэг тохиолддог ажээ.

Эмнэлгийн үйлчилгээний чанар, байршлын ялгаа нь нэмэлт зардлыг үүсгэхээс гадна цагаан сар зэрэг уламжлалт баярын бэлтгэл ахмад настнуудад том сорилтыг бий болгодог. Энэ сорилтыг зээл авах, хадгаламжаа ашиглах зэргээр нөхөх нь түгээмэл.

Тэтгэврийн хэмжээний талаарх ганцаарчилсан ярилцлагыг дүгнэн үзвэл үнэлгээ тааруу, гэр бүлийн дэмжлэг, нэмэлт орлого, зээл ахмад настнуудын амьжиргааг дэмжих гол арга болж байна. Соёл зан заншил, уламжлалтай холбоотой баяр ёслол, эрүүл мэндийн зардал тэтгэврийн талаарх үнэлгээнд нөлөөлж байна.


Би 68 настай, нөхөр, зээ хүү болон охины хамт амьдардаг. Сард 1.5 сая төгрөгийн тэтгэвэртэй. Өөрийн тэтгэврийг харьцангуй бодитой, харин эхнэрийнх нь тэтгэвэр маш бага тогтоогдсон гэж үздэг. Эрүүл мэндийн онцгой зардал гарахгүй бол тэтгэврийн мөнгөөр үндсэн хэрэгцээгээ нь хангаж чадаж байсан бол одоо байдал эрс өөрчлөгджээ. Сүүлийн 2 жилийн байдлаар тэтгэвэр нь зөвхөн эрүүл мэндийн зардалд зарцуулагддаг болов. Учир нь Ж жилийн өмнө элгээ боолгосон. Одоо нэг уураг авахад 350 мянган төгрөг. Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ тааруу учраас Улаанбаатар хотыг зорьж эмчилгээ хийлгэдэг болсон. 3-4 удаа эмнэлэгт хэвтэхэд хувийн эмнэлгийн төлбөр сарын тэтгэврээс хэд дахин давдаг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Ахмад настнуудын ярилцлагын үр дүнг баталгаажуулах зорилгоор 20 мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагад агуулгын шинжилгээ хийж үзвэл, 90 хувь нь ахмад настнуудын тэтгэврийн талаарх сэтгэл ханамж дундаас доогуур түвшинд байдаг гэж үнэлжээ.

Монгол Улсад ахмад настнуудын 50 гаруй хувь нь тэтгэврийн доод хэмжээ болох 689,000 (бүрэн) болон 572,400 (хувь тэнцүүлсэн) тэтгэвэр авч байгаа нь өрхийн болон хувь хүний амьжиргаанд хүрэлцэхгүй, хэрэглээний зардлаа төлөх боломжгүй түвшинд байна. Цалин өндөр, ажилласан жил харьцангуй урт, хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн хэмжээ бусадтай харьцуулахад өндөр байгаа ч эзлэх хувь хэмжээ бага тул сэтгэл ханамжгүй гэсэн нийтлэг дүр зурагт нөлөөлөхгүй болно.

Зураг 21. Өндөр насны тэтгэврийн хэмжээний талаарх мэргэжилтнүүдийн үзэл бодол



Эх сурвалж: Мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнд суурилсан ангилал

Өндөр настнуудаас тэтгэвэртэй холбоотой ирсэн өргөдөл гомдлын агуулгад шинжилгээ хийж үзвэл дийлэнх нь “тэтгэврийн хэмжээндээ сэтгэл ханамжгүй” гэсэн утгатай байдгийг мэргэжилтнүүд онцлов. Тэтгэвэр бодох аргачлал оновчтой ч улс орны эдийн засгийн нөхцөл боломж хомс, инфляцын түвшин өндөр, хөдөлмөр эрхлэгчдийн дундаж цалин бага байгаа нь тэтгэврийн хүрэлцээг хумих угтвар нөхцөл болж байна. Өндөр насны тэтгэврийн хүрэлцээний асуудал нь зөвхөн мөнгөн дүн бус, тогтолцооны шударга байдал, бодлогын уялдаа, сангийн чадамж, даатгуулагчийн эрхийн хэрэгжилттэй салшгүй холбоотой.

Өндөр насны тэтгэвэр амьжиргаанд нь хангалттай сайн хүрэлцэхгүй байна. Үүнд нөлөөлөх үндсэн хүчин зүйл бол инфляц, үнийн өсөлт. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн тухайд авч байсан цалингийнх нь 45 хувиас эхлэн боддог. Тэтгэврийн хувь хэмжээг тооцдог аргачлалд огт асуудал байгаа бус. Тэтгэврийн хэмжээ амьжиргаанд нь хүрэлцэхгүй байгаа үндсэн шалтгаан цалин багатай холбоотой. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй иргэдийн дундаж цалингийн хэмжээ бага. Нөгөө талаасаа юмны үнэ жил болгон өсөөд байгаа нь асуудал.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өндөр насны тэтгэврийн хэмжээний талаарх үнэлгээнд хот, хөдөө гэсэн газарзүйн байршил хамгийн их нөлөө ($n=10$) үзүүлж байна. Хотод амьжиргааны өртөг өндөр байдгаас хамаарч тэтгэвэр хүрэлцэхгүй байх нь нийтлэг. Харин хөдөө орон нутагт хэрэглээ харьцангуй бага тул амьжиргаа нь боломжийн гэсэн хариулт мэргэжилтнүүдийн дунд давамгайлжээ. Хот, хөдөө гэсэн ангиллаас гадна хотод орон байрны төрөл, байршлаас хамаарсан ойлголтын ялгаа үүссэн. Жишээ нь: Хотын төвийн хорооллын өндөр настнуудын тэтгэврийн талаарх ойлголт эерэг түвшинд байгаа бол гэр хорооллын хувьд эсрэг төлөв ажиглагдав.

Хоёулаа тэтгэвэр авч, хоёулаа амьдарч байгаа, хүүхдүүдээ зардал гаргадаггүй, тэгээд хөдөө орон нутагт амьдарч байгаа тохиолдолд амьжиргаа болоод байх талтай. Харин өөрийн хүүхэд, ач зээ нарынхаа худалдан авалтад, машин худалдан авахад нь ч юм уу, сургалтын төлбөрт нь тэтгэврээ зориулаад ирэхээр асуудал үүснэ. Хот, хөдөөгийн тухайд мэдээж ялгаатай. Хотод амьдрах нь зардал ихтэй. Наад зах нь автобусанд явах боломжгүй бие султай хүн таксигаар явахаас өөр аргагүй. Өнөөдөр такси хэр үнэтэй билээ.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Хүүхдүүдийнх нь хөдөлмөр эрхэлдэг эсэх нь ($n=5$) тэтгэврийн талаарх ойлголтод нөлөөтэй гэж мэргэжилтнүүд үзжээ. Хот, хөдөөгийн ялгаа,

хүүхдийнх нь хөдөлмөр эрхлэлтийн байдал гэсэн голлох нөлөө бүхий хоёр хүчин зүйлээс гадна ахмад настны ажил эрхэлж байсан салбар болон байгууллага, боловсролын түвшин, ажилласан жил, хүүхдийн тоо, өрхийн бүтэц зэрэг хүн ам зүйн хүчин зүйлээс хамаарч тэтгэврийн талаарх ойлголт харилцан адилгүй байна.


Мэдээж ганцаараа өндөр насны тэтгэвэр авагч байх юм бол 100 хувь тэтгэврээс хамааралтай болчихно. Хоёулаа гурвуулаа, дөрвүүлээ, тавуулаа болохоор магадгүй 2 өндөр настан 3 хүүхэдтэй байх, ажил хийдэг өрхийн гишүүний тоо, ам бүлийн тооноос хамааран тэтгэврийн мөнгөний хүрэлцээ нь багасна. Үр хүүхдийн тоо нэмэгдэх тутам өөрсдийнх нь хэрэглээ буурдаг.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Цэргийн албан хаагчид (80 хувиар тэтгэврээ тогтоолгодог), төрийн албан хаагчид өндөр тэтгэвэр авдаг бол малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, олон хүүхэдтэй эмэгтэйчүүд харьцангуй бага тэтгэвэртэй гэж мэргэжилтнүүд онцолжээ. 2010 оноос өмнө тогтоолгосон бол тэтгэврийн хэмжээ харьцангуй бага, 2010 оноос хойш бол харьцангуй боломжийн зэрэг ялгаатай байдал үүссэнийг мэргэжилтнүүд цохон тэмдэглэв. Ялангуяа социализмын үеийг дамнан ажилласан иргэдийн хувьд нийгмийн тогтолцооны өөрчлөлт, шилжилтийн үр дагаварт илүү өртөж хоёр системийн золиос болсон гэх хандлага мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас ажиглагдав.

Өндөр насны тэтгэвэрт гарснаар амьжиргаанд гарсан өөрчлөлтийн талаарх үнэлгээ: Тэтгэвэрт гарснаар ахмад настны амьжиргаа, амьдралын чанар, сэтгэл ханамжид өөрчлөлт гардаг. Судалгаанд оролцогчдын 5 хувь нь тэтгэвэрт гарснаар амьжиргаа дээшилсэн гэж үзэж байгаа бол 40.4 хувь хэвэндээ гэжээ. Харин 25.4 хувь амьжиргаа доошилсон гэж хариулсан бол 29.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан.

Зураг 22. Өндөр насны тэтгэвэрт гарснаар өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлтийн үнэлгээ, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Цалингийн хэмжээ бага, үүний тал хүрэхгүй хувиар тооцуулж, тэтгэвэр тогтоолгож байгаа гэдэг логигоор үзэхэд, тэтгэврийн хэмжээ амьдралд дангаараа хүрэлцэх боломж тун бага юм. Ахмад настнууд тэтгэвэрт гармагцаа ядуусын эгнээнд шилжиж байгаа гэж үзэхэд хилсдэхгүй.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

10 хүн тутмын гурав нь мэдэхгүй гэж хариулсан нь үнэхээр мэдэхгүй байгаадаа бус харин амьжиргааны өөрчлөлтийг ямар хэмжүүрээр хэмжихээ илэрхийлж чадаагүй, мэдлэг мэдээллийн дутмаг байдалтай холбоотой байж болох талтай.

Хүснэгт 15. Өндөр насны тэтгэвэрт гарснаар өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт, насны бүлгээр


Насны бүлэг	Өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт				Нийт
	Дээшилсэн	Хэвэндээ	Доошилсон	Мэдэхгүй	
65 хүртэл	6.5	43.1	27.6	22.8	100.0
66–75	3.7	30.9	23.5	42.0	100.0
76–85	3.3	56.7	23.3	16.7	100.0
86+	–	33.3	16.7	50.0	100.0

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Нас ахихын хэрээр амьжиргаа дээшлэх нь маш бага болон хэвэндээ гэж үзсэн хариулт ихэнх хувийг эзэлж байна. Амьжиргаа доошилсон (27.6 хувь) гэсэн хариулт 65 хүртэлх насны бүлэгт хамгийн өндөр байгаа нь тэтгэвэрт гараад удаагүй, амьдралын шинэ хэв маягт бүрэн дасан зохицоогүйн илрэл юм.

Өндөр насны тэтгэврийн өрхийн амьжиргаанд үзүүлж буй нөлөөний талаарх үнэлгээ: Ахмад настны эрхийг хамгаалах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэхэд өндөр насны тэтгэвэр чухал үүрэгтэй.

Зураг 23. Өндөр насны тэтгэврийн өрхийн амьжиргаанд үзүүлж буй нөлөө, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

“Өндөр насны тэтгэвэр нь танай өрхийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байна вэ?” гэсэн асуултад ахмад настнуудын 41.3 хувь нь амьжиргаанд гол нөлөөтэй гэсэн бол тал хувь нь тодорхой хэмжээнд нөлөө (50.4 хувь) үзүүлдэг гэж хариулжээ. Үүнээс үзвэл, 10 ахмад настан тутмын 9 нь өндөр насны тэтгэвэр нь амьжиргаанд тодорхой хэмжээнд болон голлох байдлаар нөлөөлдөг гэж үзсэн бол үлдсэн нэг нь (8.3 хувь) төдийлөн нөлөөгүй гэжээ.

Ийнхүү судалгаанд оролцогчдын 2/5 нь өндөр насны тэтгэвэр ахмад настны амьжиргааг хангах нийгмийн хамгааллын арга хэрэгслийн үүргээ бүрэн гүйцэтгэж байгаа гэсэн агуулгатай хариулт өгчээ.

Хүснэгт 16. Өндөр насны тэтгэврийн өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөөний талаарх үнэлгээ (хувь) шинж байдлын зарим үзүүлэлтээр

Шинж байдал	Үзүүлэх нөлөө			Нийт
	Голлох нөлөөтэй	Тодорхой хэмжээнд нөлөөтэй	Төдийлөн нөлөөгүй	
Насны бүлэг				
65 хүртэл	35.0	57.7	7.3	100.0
66–75	46.9	45.7	7.4	100.0
76–85	56.7	33.3	10.0	100.0
86+	16.7	50.0	33.3	100.0
Байршил				
Нийслэл	24.3	49.0	26.7	100.0
Аймгийн төв	42.5	40.2	17.3	100.0
Сумын төв	56.7	33.3	10.0	100.0
Нийт	41.3	50.4	8.3	100.0

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Нас ахих тусам тэтгэвэр амьжиргаанд нь голлох нөлөөтэй гэж үзсэн хандлага ахмад настнуудын дунд ажиглагдаж байгаа бол 76–85 насны бүлэгт хамгийн их голлох нөлөөтэй (56.7%) байна. Харин 86-аас дээш насны бүлэгт “голлох нөлөөтэй” гэсэн хариултын хувь хэмжээ буурч, төдийлөн нөлөөгүй гэсэн хариулт нэмэгдэж байгааг энэ насны бүлэгт тэтгэврээ захиран зарцуулах эрх мэдэл буурдаг, хүүхдүүдээс дэмжлэг авах байдал нэмэгддэгтэй холбон тайлбарлаж болох юм.

Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг байршлаар харьцуулан үзэхэд, нийслэлтэй харьцуулахад аймаг, сумын төвийн иргэдийн үнэлгээ харьцангуй өндөр байна. Тухайлбал, сумын төвөөс судалгаанд хамрагдагчдын 56.7 хувь нь өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэвэр голлох нөлөөтэй гэж үзсэн бол аймгийн төвөөс судалгаанд хамрагдагчдын

42.5 хувь, нийслэлээс судалгаанд хамрагдагчдын 24.3 хувь нь тус тус тэтгэврийг өрхийн эдийн засагт гол нөлөөтэй гэж хариулжээ. Улмаар нөлөөгүй гэсэн хариултын хувь байршлаас хамааран 10.0–26.7 хувь байна.

4.3. Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөө

Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөөг өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь хэмжээ, орлогын гол эх үүсвэр болдог эсэх, өндөр насны тэтгэврээс хуримтлуулал боломж, тэтгэврийн зээлийг орлогын эх үүсвэр болгон ашиглах байдлын хүрээнд авч үзнэ.

Өрхийн сарын дундаж орлогын хэмжээ: Монгол Улсад 2025 оны I улирлын байдлаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2,648,665 төгрөг байна (ҮСХ, 2025). Санал асуулгын судалгаанд хамрагдсан өндөр насны тэтгэвэр авагчтай 240 өрхийн хувьд өрхийн сарын орлогын хэмжээ 572,400–6,000,000 төгрөг, дундаж орлогын хэмжээ 1,910,663 төгрөг гарсан нь ҮСХ-ны мэдээлсэн орлогын дундаж түвшнээс 36.8 хувиар доогуур дүн байна.

ҮСХ-оос гаргасан орлогын бүлгээр авч үзэхэд, судалгаанд хамрагдсан өрхийн орлогын түвшин дараах байдалтай байна.

Хүснэгт 17. Судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж орлогын хэмжээ, бүлэглэсэн байдлаар

Орлогын бүлэг	Тоо	Хувь
700.0 мянган төгрөгөөс доош	38	15.8
700.0–1600.0 мянган төгрөг	84	35
1.6–3.0 сая төгрөг	81	33.8
3.0 сая төгрөгөөс дээш	37	15.4
Нийт	240	100

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Харьцангуй өндөр буюу сарын 1.6–3.0 сая төгрөгийн болон 3.0 сая төгрөгөөс дээш дундаж орлоготой өрхүүд нийт өрхийн 50 орчим хувийг эзэлж байна. 2025 онд баталсан хүн амын амьжиргааны доод түвшин бүсээс хамааран 482,900–495,400 төгрөг байгаа бөгөөд нэг өрх дунджаар 4 ам бүлтэй гэсэн дундаж статистикийг баримжаалбал, өндөр насны тэтгэвэр авдаг өрхүүдийн 50 орчим хувь нь ядуу байж болзошгүй байна. Энэ нь “Өндөр насны тэтгэвэрт гарснаар өрхийн амьжиргаа хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэсэн асуултад 40.4 хувь нь хэвээрээ, 25.4 хувь нь доошилсон, 5.0 хувь нь дээшилсэн гэсэн хариулт өгсөнтэй уялдаж байна.

Өрхийн сарын дундаж орлогын хэмжээг өрхийн шинж байдлын үзүүлэлт болох ам бүлийн тоо, хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоогоор харьцуулан авч үзэхэд, ам бүлийн тоо, цаашлаад хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоо нэмэгдэхийн хэрээр сарын дундаж орлогын хэмжээ өссөн байна. Тухайлбал, 1 ам бүлтэй өрхүүд сард дунджаар 1.3 сая төгрөгийн орлоготой бол 6, түүнээс олон ам бүлтэй өрхүүдийн сарын дундаж орлого түүнээс 2.2 дахин өндөр байна.


Хүснэгт 18. Өрхийн сарын дундаж орлогын хэмжээ, өрхийн шинж байдлаар

Өрхийн ам бүлийн тоо	Сарын дундаж орлогын хэмжээ (төгрөг)	Хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоо	Сарын дундаж орлогын хэмжээ (төгрөг)
1	1,342,183	0	1,470,686
2	1,598,886	1	1,877,393
3-5	1,967,279	2	2,448,481
6+	2,922,150	3+	2,756,690
Нийт	1,910,664	Нийт	1,910,664

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Мөн судалгаагаар Улаанбаатар хотын өрхийн сарын дундаж орлого 2.1 сая төгрөг байгаа нь аймгийн болон сумын төвийн өрхийн орлогоос дунджаар 400 мянган төгрөгөөр илүү байна.

Зураг 24. Өрхийн сарын дундаж орлогын түвшин, байршлаар




Энэ нь нийслэлийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн боломж илүү, орлогын эх үүсвэрийн төрөл олон, эдийн засгийн идэвх илүү өндөр байгааг харуулж байна.

Өрхийн орлогын эх үүсвэр: Судалгаанд хамрагдсан өрхүүд нийтдээ 1-5 орлогын эх үүсвэртэй бөгөөд дунджаар 1.7 эх үүсвэрээс орлого олж байгаа нь нэг өрх хоёр хүрэхгүй орлогын эх үүсвэртэй байгааг илтгэнэ. Өөрөөр

хэлбэл, өрхийн орлого харьцангуй төвлөрсөн, цөөн эх үүсвэр, тодруулбал, өндөр насны тэтгэвэр болон цалингийн орлогоос хамааралтай байна.

“Танай өрхийн орлогын гол эх үүсвэр юу вэ?” гэсэн нээлттэй асуултад судалгаанд хамрагдагчдын 55.8 хувь нь өндөр насны тэтгэвэр, 41.3 хувь нь цалин хөлс гэж хариулсан бол үлдсэн багахан хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, мал аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагааны орлого зэрэг бусад эх үүсвэрийг дурдсан байна.

Зураг 25. Судалгаанд хамрагдсан өрхийн орлогын гол эх үүсвэр, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Энэ нь судалгаанд хамрагдсан өрхүүдийн дийлэнх нь хөдөлмөрийн орлогоос илүүтэйгээр тэтгэврийн орлогод түшиглэж байгааг илэрхийлнэ.

Ярилцлагын үр дүнгээс үзвэл, ахмад настнууд дараах 3 үндсэн шалтгаанаар тэтгэврийг өрхийн гол орлогын эх үүсвэр гэж үзэж байна. Үүнд, нэгдүгээрт, өрхийн өдөр тутмын хэрэгцээг хангах боломжтой байдал буюу хүнсний бүтээгдэхүүн, нийтийн үйлчилгээ, эмийн зардлыг тэтгэврийн орлогоор бүрэн эсвэл хэсэгчлэн хангадаг, хоёрдугаарт, орлогын тогтмол шинж буюу тэтгэвэр сар бүр тогтмол хугацаанд (ихэвчлэн сарын 1-нд) дансанд ордог тул өрхийн төсөвт тогтвортой байдал бий болгодог, гуравдугаарт, гэр бүлийн гишүүдээ дэмжих чадамж буюу тэтгэврийн орлогоор хүүхэд, ач зээ нартаа санхүүгийн туслалцаа үзүүлэх боломж бүрддэг зэрэг болно.

Дээрх зургаас үзэхэд цалинг өрхийн орлогын хоёр дахь гол эх үүсвэр гэж үзэж байгаа нь судалгаанд хамрагдагчдын 53.8 хувь нь хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, ач зээ нартайгаа хамт амьдарч байгаатай холбоотой байна. Түүнчлэн судалгаа хийх явцад ахмад настнууд орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох зорилгоор харуул, үйлчлэгч, таксины жолооч, жижиглэн худалдаачин зэрэг ажил эрхэлж, хөдөлмөрийн зах зээлд оролцсоор байсан нь ажиглагдсан.


Миний хувьд 1,3 сая, эхнэр 689 мянган төгрөгийн тэтгэвэртэй. Өрхийн орлогодоо нэмэр болгох үүднээс эхнэр үйлчлэгчийн ажил эрхэлж, сард 1,2 сая төгрөгийн цалин авдаг. Сар бүр 1,3 сая төгрөгөөр амьдрах л байх, гэхдээ цагаан сар, наадам гэх мэт өндөр зардалтай үед орлого дутагдах асуудал гарах тул ажил эрхэлдэг. Ер нь таксинд явах, харуул хамгаалалт хийх зэргээр эрүүл мэндийн асуудалгүй л бол ажил хөдөлмөр хийдэг тэтгэврийн насныхан олон байдаг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь хэмжээ: Монгол Улсын нэг өрхийн дундаж мөнгөн орлогын бүтцийг задлан харвал, цалин хөлс 57.4 хувийг, тэтгэвэр, тэтгэмжийн орлого нь нийт мөнгөн орлогын 22 хувийг эзэлж байна (ҮСХ, 2025). Өөрөөр хэлбэл, тэтгэвэр, тэтгэмжийн орлого нь өрхийн орлогын 2 дахь чухал эх үүсвэр болж байна.

Санал асуулгын судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээ 901,550 төгрөг байгаа ба тухайн өрхийн сарын дундаж орлогын 47.2 хувийг тэтгэврийн орлого бүрдүүлж байна. Үүнээс судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд тэтгэврийн орлого нь зөвхөн ахмад настны амьжиргааны баталгаанд бус, өрхийн нийт орлогын тогтвортой байдалд чухал хувь нэмэр оруулж байгаа нь харагдаж байна.

Зураг 26. Өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь, орлогын бүлгээр



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан судлаачдын тооцоо

Өндөр насны тэтгэврийн өрхийн орлогод эзлэх хувийг тухайн өрхийн орлогын бүлгээр авч үзэхэд, мэдэгдэхүйц ялгаатай байна. Тодруулбал, 700 мянган төгрөгөөс доош орлоготой өрхүүдийн хувьд өндөр насны тэтгэвэр нь нийт мөнгөн орлогын 90 гаруй хувийг эзэлж байсан бол харьцангуй өндөр буюу 2.5 саяас дээш төгрөгийн орлоготой өрхийн орлогын 32 хувийг бүрдүүлж

байна. Энэ нь өндөр насны тэтгэвэр нь бага орлоготой өрхүүдийн хувьд гол амьжиргааны эх үүсвэр болж байгаагийн зэрэгцээ эдгээр өрхийн эдийн засгийн тогтвортой байдал, амьжиргааны түвшин тэтгэврийн хэмжээнээс шууд хамаарч байгааг илэрхийлж байна.

Нөгөөтээгүүр, орлогын түвшин нэмэгдэхийн хэрээр тэтгэврийн орлогын эзлэх хувь буурч байгаа нь дунд болон дундаас дээш орлоготой өрхүүд нэмэлт орлогын эх үүсвэртэй байгааг харуулна.

Судалгааны үр дүнг илүү нарийвчлан шинжилбэл, өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь хэмжээ нь өрхийн ам бүлээс хамаарч мэдэгдэхүйц ялгаатай байна.

Хүснэгт 19. Өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь, өрхийн ам бүлийн бүтцээр

Өрхийн ам бүлийн тоо	Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь	Хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоо	Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн эзлэх хувь
1	63.3	0	61.4
2	57.9	1	44.2
3-5	45.9	2	38.4
6+	30.6	3+	34.5
Нийт	47.2	Нийт	47.2

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувийг өрхийн ам бүлийн тоогоор авч үзэхэд, ганцаар амьдардаг өрхийн нийт орлогын 2/3 арай хүрэхгүй хувийг бүрдүүлж байгаа бол өрхийн ам бүлийн тоо нэмэгдэхийн хэрээр энэ дүн буурсан байна. Энэ нь өрхийн ам бүрийн тоо нэмэгдэхийн хэрээр хөдөлмөрийн насны хүн амын оролцоо болон бусад орлогын эх үүсвэр нэмэгдэж байгаагаар холбоотой.


Өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувийг өрхийн хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоогоор авч үзэхэд, хөдөлмөр эрхэлдэг гишүүн байхгүй өрхийн орлогын 3/5 орчим хувийг тэтгэврийн орлого бүрдүүлдэг аж. Харин тухайн өрхөд ямар нэгэн хөдөлмөр эрхэлдэг гишүүн байгаа тохиолдолд өндөр насны тэтгэвэр нь өрхийн орлогын 30-40 хувийг эзэлж байна.

Эдгээрээс хөдөлмөр эрхэлдэг гишүүнгүй эсвэл ганцаараа амьдардаг өрхүүдийн хувьд өндөр насны тэтгэвэр нь амьжиргааны гол орлогын эх үүсвэр болж байгааг батлан харуулж байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн зах зээлээс хөндийрсөн, өдөр тутмын амьдралд нь дэмжлэг үзүүлэх хүнгүй

ахмад настнуудын хувьд өндөр насны тэтгэвэр нь амьжиргааны баталгааг хангах үндсэн хэрэгсэл, нийгмийн хамгааллын гол элемент болж байна.

Өндөр насны тэтгэврийн өрхийн нийт орлогод эзлэх хувь нь тухайн өрхийн байршлын онцлогоос хамааран ялгаатай байна. Тодруулбал, аймгийн төвд оршин суудаг өрхийн хувьд өндөр насны тэтгэвэр өрхийн орлогын 54.5 хувийг эзэлдэг бол сумын төв, Улаанбаатар хотын хувьд 4.1–9.0 пунктээр доогуур байгаа дүн гарсан.

Зураг 27. Өндөр насны тэтгэврийн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь, байршлаар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо


Байршлын ялгаанаас харахад өндөр настнуудын тэтгэврийн орлого нь Улаанбаатар хотод харьцангуй өндөр байгаа ч нийт өрхийн орлогын бүтцэд эзлэх жин нь бага, харин орон нутагт тэтгэврийн хэмжээ бага боловч өрхийн орлогын бүтцэд эзлэх байр суурь нь илүү чухал байна. Энэ нь орон нутаг, ялангуяа аймгийн төвийн ахмад настнуудын амьжиргаа тэтгэврийн орлогоос илүү байгааг илтгэж байна.

Сумын төвийн ахмадуудын хувьд тодорхой тооны малтай байх хандлага илүү. Улаанбаатар хотод бол такси үйлчилгээнд явах, байр түрээслэх зэргээр орлогын эх үүсвэрийн боломж нэмэгддэг гэж боддог.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өрхийн хуримтлал: Өрхийн орлого, зарлага, хуримтлал нь тухайн улсын эдийн засгийн тогтвортой байдал, иргэдийн санхүүгийн чадамжийг илтгэдэг гол үзүүлэлтүүдийн нэг юм (Дамба, 2020, хууд.23). Санал асуулгын судалгааны үр дүнгээс харахад нийт орлогоос өрхүүдийн 37.9 хувь нь хуримтлал үүсгэж чаддаг бол 62.1 хувь нь хуримтлал үүсгэж чадахгүй байна.

Зураг 28. Өрхийн орлогоос хуримтлуулдаг эсэх, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Энэ нь судалгаанд хамрагдсан нийт өрхийн 2/3-т нь орлогоо амьжиргааны үндсэн хэрэгцээнд бүрэн зарцуулж, ирээдүйн санхүүгийн эрсдэлийг бууруулах боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, өндөр насны тэтгэврийн орлого нь өрхийн орлогын 50 орчим хувийг бүрдүүлж байгаа ч хуримтлалын боломжийг нэмэгдүүлж чадахгүй байгаа нь тогтвортой шинжтэй боловч хэмжээний хувьд хангалтгүй байгаагийн илрэл юм.


Нөгөө талаас хуримтлал үүсгэж чаддаг өрхүүдийн хувьд өрхийн бусад гишүүдийн орлогоор дэмжигдэх боломжтой, өр төлбөр багатай, санхүүгийн мэдлэг илүү сайн зэрэг хүчин зүйл нөлөөлж байж болох юм.

Ач нарынхаа сургалтын төлбөр зэрэг зардалд хэрэгтэй гэж үзээд анх хуримтлуулж, багахан хэмжээний хадгаламж бий болгосон. Гэвч тэтгэвэрт гарснаас хойш хуримтлалд нэмэр болгож амжихгүй байна. Зардал бараг хэвээрээ, гэтэл цалингийн орлогын тал хэмжээтэй тэтгэвэр авч байгаа болохоор тэтгэврийн хэмжээ бага учир хуримтлуулах боломж бага гэх үү дээ.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өрхийн байршлаас хамааруулж үзэхэд, Улаанбаатар хотын өрхийн 23 орчим хувь, аймгийн төвийн өрхийн 52 орчим хувь, сумын төвийн өрхийн хувьд 55 орчим хувь нь тус тус хуримтлал хийж чаддаг байна.

Зураг 29. Тэтгэврийн орлогоос сар бүр хуримтлал хийдэг өрхийн хувь, байршил болон хариулагчийн боловсролын түвшнээр



Үүнээс орон нутгийн өрхүүдийн хуримтлал үүсгэх чадвар нийслэлийн өрхүүдээс өндөр байгааг харж болно. Энэ нь орон нутагт амьжиргааны өртөг харьцангуй бага, зарим тохиолдолд өрхийн дотоод нөөц, хүнсний хэрэглээ илүү байдагтай холбоотой байх магадлалтай. Харин Улаанбаатар хотод амьжиргааны зардал өндөр тул өндөр настнуудын хувьд тэтгэврийн орлого нь зөвхөн хэрэглээнд зарцуулагддаг, хуримтлал үүсгэх боломж хязгаарлагдмал байх магадлалтай юм.

Багахан хэмжээний хуримтлал бий болгосон хэдий ч бага багаар зарцуулсаар үндсэндээ дууссан. Хүүхдийн орон сууц, хурим гээд хадгаламжийн дийлэнх нь зарцуулагдсан.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшин нь өрхийн хуримтлуулах чадварт шууд нөлөөлж байна. Ерөнхийдөө хариулагчийн боловсролын түвшин нэмэгдэх хэрээр хуримтлалтай өрхийн тоо хэмжээ нэмэгдэж байна. Тухайлбал, бага боловсролтой иргэдийн 28 хувь, дунд боловсролтой иргэдийн 39 хувь, дээд боловсролтой иргэдийн 41 хувь нь тус тус хуримтлал үүсгэж чаддаг байна. Энэ нь боловсролын түвшин өндөр байх тусам иргэдийн санхүүгийн мэдлэг, орлогоо төлөвлөх болон хуримтлал үүсгэх чадвар дээшилж байгааг харуулж байна. Нөгөө талаас, боловсролын түвшин өндөртэй иргэдийн хувьд албан тушаалын шатлал, цалин хөлс нэмэгдэх хандлага бий.

Судалгаанд хамрагдсан тодорхой хэмжээний хуримтлал үүсгэж чаддаг өрхүүдийн сарын дундаж хуримтлалын хэмжээ 414,500 төгрөг байгаа бөгөөд сард хуримтлуулдаг дүнг бүлэглэн авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 20. Судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж хуримтлалын бүлэглэсэн хэмжээ, тоо болон хувиар

Бүлэглэсэн дүн	Тоо	Хувь
100.0 мянган төгрөгөөс доош	34	36.1
100.0–500.0 мянган төгрөг	38	41.7
500.0–1.0 сая төгрөг	15	16.7
1.0 сая төгрөгөөс дээш	5	5.6
Нийт	91	100

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Хуримтлал үүсгэж буй өрхийн дийлэнх буюу 77.8 хувь нь сарын 500 мянган төгрөгөөс бага хэмжээний хуримтлалтай байна. Энэ нь өрхийн орлогын түвшин хязгаарлагдмал, орлогоосоо илүүтэйгээр өдөр тутмын хэрэглээнд зарцуулдаг байдал түгээмэл байгааг илтгэнэ.

10 жилийн өмнө хуримтлал үүсгэсэн. Сар бүр 5 мянган төгрөг татах байдлаар хуримтлалаа нэмэгдүүлдэг. Уг нь сарын таталтыг нэмэгдүүлээд хадгаламжийн хэмжээгээ өсгөх бодолтой байдаг ч одоогоор мөрөөдөл төдий байна.


Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өрхийн хуримтлалд орлогын хэмжээнээс гадна санхүүгийн боловсрол, урт хугацааны санхүүгийн төлөвлөлт, хадгаламжийн дадал зэрэг хүчин зүйл нөлөөлж байна.

Өндөр насны тэтгэврийг зээлийн эх үүсвэр болгон ашиглах байдал:

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 76.3 хувь нь сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан бол 23.7 хувь нь аваагүй байна байна. Энэ нь судалгаанд хамрагдсан 4 өрх тутмын 3 нь өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлд хамрагдсан байгааг илтгэх үзүүлэлт бөгөөд өндөр насны тэтгэвэр нь ахмад настнуудын амьжиргааны гол эх үүсвэр төдийгүй тэтгэвэр барьцаалсан зээлийн хэлбэрээр дутагдаж буй зардал, нэмэлт санхүүгийн хэрэгцээг нөхөх боломжийг олгодог болохыг харуулж байна.

Зураг 30. Сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Судалгаагаар харьцангуй залуу буюу 65–75 насны тэтгэвэр авагчдын дунд сүүлийн 3 жилд тэтгэвэр барьцаалсан зээл авсан байдал хамгийн өндөр буюу 80 орчим хувьтай байна.

Хүснэгт 21. Сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх, хариулагчийн нас, хүйсээр, хувиар

Өрхийн шинж байдал	Зээл авсан эсэх		Нийт
	Тийм	Үгүй	
Насны бүлэг			
65 хүртэл	83.7	16.3	100
66–75	77.8	22.2	100
76–85	46.7	53.3	100
86+	50.0	50.0	100
Хүйс			
Эрэгтэй	69.0	31.0	100
Эмэгтэй	79.3	20.7	100
Нийт	76.3	23.8	100

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Мөн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс тэтгэвэр барьцаалсан зээл авсан байдал 10 пунктээр өндөр байгаа нь хэрэглээ, сэтгэл зүйн онцлогтой холбоотой байж болох талтай.

Миний хувьд зээлээс айдаг. Эхнэр бол төдийлөн тоодоггүй, зээлээ дуусахаар дараагийн зээлийг авах байдлаар тогтмол зээл авдаг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх нь өрхийн байршлаас хэрхэн хамаарч байгааг шинжлэн үзвэл, Улаанбаатар хотын өрхийн 68 орчим хувь нь, харин аймгийн болон сумын төвийн өрхийн 85 хувь нь тус тус зээл авсныг харж болно. Энэ нь орон нутгийн өрхүүдэд тэтгэвэр барьцаалсан зээлийн эрэлт илүү өндөр, Улаанбаатар хотод харьцангуй бага болохыг харуулж байна.

Хүснэгт 22. Сүүлийн 3 жилд Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх, байршлаар

Байршил	Зээл авсан эсэх		Нийт
	Тийм	Үгүй	
Улаанбаатар хот	67.5	32.5	100
Аймгийн төв	85.0	15.0	100
Сумын төв	85.0	15.0	100
Нийт	76.3	23.8	100

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Судалгаанд хамрагдсан иргэдийг тэтгэвэрт гарах үеийн нийгмийн даатгалын төрлөөр нь харьцуулсан үр дүнгээс үзэхэд, сайн дурын даатгалд хамрагдсан иргэд албан журмын даатгалд хамрагдсан иргэдээс 12 пунктээр илүү өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авчээ. Энэ нь нэг талаас, сайн дурын даатгалд хамрагдан тэтгэвэрт гарсан өндөр настнуудын хувьд өндөр насны тэтгэвэрт гарахаасаа өмнө орлогоо нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага өндөр болохыг харуулж байж болох юм.

Хүснэгт 23. Сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан эсэх, тэтгэвэрт гарах үеийн нийгмийн даатгалын төрлөөр, хувиар

Тэтгэвэрт гарах үеийн нийгмийн даатгалын төрөл	Зээл авсан эсэх		Нийт
	Тийм	Үгүй	
Албан журмын	73.8	26.2	100
Сайн дурын	85.7	14.3	100
Нийт	76.3	23.8	100

Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Нөгөө талаас, хувиараа бизнес эрхэлдэг иргэд гол төлөв сайн дураар даатгалд хамрагддаг тул бизнес эрхлэхэд шаардлагатай орлогоо нэмэгдүүлэх зорилгоор зээл авч байгаатай холбоотой.

Тэтгэвэр барьцаалсан, POS машины нийт 10 сая төгрөгийн зээлтэй, бизнест нэмэр болгох, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх гэдэг үүднээс зээл авсан. Мэдээж өдөр бүр зээл төлнө гэдэг өглөө босоод л барааны гүйлгээ ямар байх бол гэсэн бодол бий болгодог. Азаар өдөр бүр орлоготой, POS машины зээлээ төлөөд яваад байна. Тэтгэврийн зээл бол банкнаас автоматаар татагдана.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Судалгааны хүрээнд зээлийн төлбөрийг юунд зарцуулсныг нарийвчлан авч үзэхэд:

- Эрүүл мэнд – 31.1 хувь
- Тавилга, эд хогшил – 22.9 хувь
- Тээврийн хэрэгсэл – 15.8 хувь
- Сургалт, сургалтын төлбөр – 9.3 хувь
- Орон сууц худалдан авах/засварлах үйл ажиллагаа – 28.2 хувь
- Зээлийн төлбөр – 20.2 хувь
- Цагаан сар – 21.3 хувь
- Бизнесийн үйл ажиллагаа – 4.9 хувь
- Бусад – 10.9 хувь гэсэн хариултууд дурдагджээ.


Үүнээс хамгийн өндөр буюу 31.1 хувь нь эрүүл мэндийн зорилгоор зээл авсан байна. Сүүлийн 3 жил тэтгэврийн зээл авсан иргэдийн 28.2 хувь нь орон сууц худалдан авах, түрээслэх зорилгоор зээл авсан бөгөөд энэ нь зээл нь үл хөдлөх хөрөнгө худалдан авах нэг эх үүсвэр болж байгааг харуулав. Мөн 1/5 орчим нь цагаан сар тэмдэглэхтэй холбоотойгоор тэтгэвэр барьцаалсан зээл авсан байна. Судалгааны явцад ахмад настнуудын жилийн амьдралын тойрогт хаврын улиралд цагаан сар, зуны улиралд улсын баяр болон нутагтаа очих, хамаатан садандаа зочлох гэсэн чухал үйл ажиллагаа байдаг бөгөөд эдгээр нь санхүүгийн хувьд ачаалал болдог нь харагдсан.

Цагаан сар, зуны амралтаар нутаг руугаа явж, ах дүүтэйгээ уулзах гэх мэт үед тэтгэврийн орлого хүрэлцээгүй болдог. Жишээ нь: Өнгөрсөн жил ах дүүсийн уулзалтдаа явсан. Бэлэг сэлт, дээл хувцас, бензин шатахуун гээд өндөр зардал гарсныг тэтгэвэр барьцаалсан зээл авах байдлаар шийдсэн.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Сүүлийн 3 жилд авсан өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл нь өрхийн хэрэглээнд тодорхой хэмжээнд нөлөөлсөн нь судалгааны үр дүнгээр харагдаж байна.

Зураг 31. Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл өрхийн хэрэглээнд нөлөөлсөн байдал, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо


Тодруулбал, судалгаанд хамрагдсан өрхийн 24.0–28.8 хувьд нь өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл ямар нэгэн нөлөө үзүүлээгүй бол 38.8 хувьд нь зарим худалдан авалтыг багасгасан, 32.8–37.2 хувьд нь зарим зүйлийг худалдан авах боломжгүйд хүргэжээ. Энэ нь тэтгэвэр барьцаалсан зээл нь өндөр настнуудын өдөр тутмын хэрэглээ, амьдралын хэв маягт шууд нөлөөлж байгааг харуулж байна.

Тэтгэвэр барьцаалсан зээлтэй, нэмээд POS машины зээл авсан. Нийлээд 10 саяын зээлтэй, бизнест нэмэр болгох, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх гэдэг үүднээс зээл авсан. Бас хүүгийнхээ сургалтын төлбөр төлсөн. Мэдээж өдөр бүр зээл төлнө гэдэг өглөө босоод л барааны гүйлгээ ямар байх бол гэсэн айдас бий болгодог. Азаар өдөр бүр орлоготой, POS машины зээлээ төлөөд яваад байна. Тэтгэврийн зээл бол банкнаас автоматаар татагдана.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл нь ахмад настнуудын сэтгэл санаанд хэрхэн нөлөөлж байгааг судалбал, зээл авсан иргэдийн 45.4 хувь нь зээлтэй холбоотойгоор ямар нэг байдлаар сэтгэл санааны дарамт мэдрэсэн бол үлдсэн 54.8 хувь нь ийм дарамт мэдрээгүй гэж хариулжээ.

Зураг 32. Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл сэтгэл санаанд нөлөөлсөн байдал, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Үүнээс өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлээс хамааран сэтгэл санааны дарамт мэдэрсэн байдал 9.2 пунктээр өндөр байна.


Зээл авч байхдаа сайхан ч гэсэн дараа эргүүлэн төлнө, төлж байгаатай уялдаад бусад хэрэгцээгээ зохицуулах шаардлага гарна гэх мэт асуудал ихтэй учир аль болох зээл авахгүй байхыг эрмэлздэг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Сүүлийн 3 жилд авсан өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл нь өрхийн хэрэглээнд тодорхой хэмжээнд нөлөөлсөн нь судалгааны үр дүнгээр харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдээс өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлийг үр дүнтэй зарцуулсан эсэхийг тодруулахад, 73.8 хувь нь тийм гэсэн хариулт өгсөн нь зээлийн зарцуулалт, үр дүнд сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.

Зураг 33. Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлийг үр дүнтэй зарцуулсан эсэх



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тэтгэвэр барьцаалсан зээл аваад эмнэлгийн зардалд нэмэрлэсэн. Мэдээж зээлийн төлбөрт тал нь зарцуулагддаг учраас хүрэлцээгүй болох, зөрчил үүсэх асуудал мэр сэр гарч байна. Гэхдээ тухайн үед эрүүл мэндийн нэн шаардлагатай үед хэрэг болсон гэж бодохоор өөдрөг байдаг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өмнө нь нэг удаа тэтгэврийн зээл авч, хүүхдийн бизнест нэмэрлэж байсан. Гэхдээ сар болгоны тэтгэврээс хасагдахаар бас төвөгтэй юм билээ. Мэдээж үр хүүхдэдээ тусалсан гэж бодохоор сэтгэл өег байдаг ч бодит байдал дээр залуучууд орон гэртэй болох хэцүү байгаа тул туслахаас аргагүй байдал үүссэн.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөтэй холбоотой кейс: Судалгааны хүрээнд өндөр насны тэтгэвэр нь өрхийн орлогод хэрхэн нөлөөлж буйг тодруулах зорилгоор дараах 3 төрлийн кейс боловсруулан танилцуулж байна.

Кейс 1: Би эхнэр, дөрвөн хүүхэд, ач зээ нартай өнөр гэр бүлтэй байсан ч эхнэр минь өөд болсон. Одоо хүүхдүүд маань бүгд ажил хөдөлмөр эрхэлж, тус тусын амьдралаа авч явдаг. Би сард 1,200,000 төгрөгийн өндөр насны тэтгэвэр авдаг, энэ орлогоороо бие даан амьдарч байна.

Заримдаа мэргэжлээрээ зөвлөх ажил хийж нэмэлт орлого олдог. Тэтгэврээсээ илүү гарсан мөнгөө хуримтлуулах боломж байдаг ч хуримтлуулдаггүй, амьдралд хэрэгцээ бага, хүүхдүүдэд туслах шаардлага гарвал тэдэнд зээлдүүлдэг, тэд ч буцааж өгдөг.

Өндөр насны тэтгэврийн зээл авч үзээгүй, харин эхнэр маань нэг удаа охины төгсөлтөд зориулж авсан байдаг.

Тэтгэврийн ихэнхийг орон сууцны ашиглалтын зардал болон хоол хүнсэндээ зарцуулдаг. Хувцсыг хүүхдүүд өгдөг тул бусад зардал бага. Эрүүл мэндийн хувьд сайн, эм тариа тогтмол хэрэглэх шаардлагагүй, эмчилгээ сувилгаанд ч явж байгаагүй. Иймээс одоогийн тэтгэвэр нь өдөр тутмын хэрэгцээнд хүрэлцээтэй. Гэхдээ өвдөж, эмчилгээ шаардлагатай бол хангалтгүй байх нь тодорхой.

Өөрийн тэтгэврийн хэмжээг тогтоосон нь шударга эсэхэд эргэлздэг. Учир нь ажилласан жил, төлсөн татварыг бүрэн харгалзаагүй гэж боддог. Тэр үеийнхэн “улсаас өгч байгаа мөнгө” гэж ойлгодог байснаас тэтгэврийн тогтолцооны утгыг сайн мэддэггүй байжээ. Тэтгэврийн хэмжээг төлсөн татвар, хөдөлмөрийн онцлог, бүтээн байгуулалтын хувь нэмрийг харгалзан ялгамжтай тогтоох ёстой гэж үздэг.

Инженерийн мэргэжлээр улс орны эрчим хүчний бүтээн байгуулалтад олон жил ажилласан учраас илүү үнэлэмжтэй байх ёстой гэж боддог. ХБНГУ, АНУ, ОХУ-д ийм ялгамжийн систем байдаг гэж сонссон бол манай улсад ийм үнэлгээ дутмаг санагддаг.

Тэтгэврийн хэмжээ хангалттай биш гэж үздэг. Хангалттай орлоготой байсан бол АНУ-д байгаа хүүгийн дээ илүү ойр очиж, хөдөлмөр эрхлэх, туршлагаа ашиглах сонирхолтой байх байжээ. Энэ жишээгээр ахмад настануудаа илүү дэмждэг, хөдөлмөрийг нь үнэлдэг нийгэмд хүрэх хүсэлтэй гэдгээ илэрхийлдэг.

Кейс 2: Би хүргэнийдээ, ам бүл тавуулаа, өвгөн, охин, хүргэн, зээ хүүтэй хамт амьдардаг. Өвгөн бид хоёр хоёулаа тэтгэвэр авдаг, би сардаа 680 мянган төгрөг, өвгөн бас 689 мянган төгрөг авдаг. Хүүхдүүд маань хувийн бизнес эрхэлдэг, нэг зээ маань сургуульд сурдаг.

Хуримтлал бий болгож чадаагүй. Зургаан хүүхэдтэй, 260 мянган төгрөгийн цалинтай цэвэрлэгч байсан. Социалист үед цалин бага, хэрэглээ их байсан тул хуримтлал хийх боломж байгаагүй. Тэр үеийн хадгаламжтай хүмүүсийн мөнгө 20 дугаар тогтоолоор үнэгүйдсэн жишээ ч мэднэ.

Сувилалд явах дуртай ч тэтгэвэр хүрэлцдэггүй тул хүүхдүүдээс тусламж авдаг. Хамгийн их зардалтай үе нь Цагаан сараар ууц, хэвийн боов, бууз, гарын бэлэг гээд зардал их. Зургаан хүүхэдтэйгээ нийлж байж л уг баярыг өнгөрөөдөг. Ерөнхийлөгч Баттулга тэтгэврийн зээл тэглэсэн үед “зээл авдаг байсан бол гэж” бодсон, өөрөө зээл авч үзээгүй, хүнээс мөнгө зээлэх дургүй.

Тэтгэвэр маань байрны мөнгө, СӨХ, хоол хүнс, эм тарианд хүрэлцдэггүй. Өөртөө хувцас авдаггүй, охин авчирч өгснийг өмсдөг. Хааяа үсчин ордог (25,000 төгрөг). Хүнсний үнэ өссөн тул авсан мөнгө хурдан дуусна. Тэтгэврийн гуравны нэгийг хоол хүнсэнд зарцуулдаг ч 400 мянгаар бараг юм авч чадахгүй. Нуруу, хөлний өвчин, даралт, бамбайн эмийг сар бүр авдаг. Мөнгө сард 20-доор дуусаж, охин хүргэнээсээ зээлдэг. Хүүхдүүдээ зүдэрч байгааг хараад аль болох мөнгө зулгаахгүйг боддог ч тэд “ээж мөнгөө ав” гэж хэлдэг.

27 жил ажиллаж тэтгэврийн бүх болзол хангасан, гэхдээ тэтгэвэр анхнаасаа бага тогтоогдсон. Хэдийгээр жил бүр нэмдэг ч амьдралын өртөг нэмэгдэж буйтай харьцуулахад нэмэгдэл нь “амсуулах төдий”. Тэтгэврийг цалин, ажилласан жил, амьжиргааны бодит түвшинтэй уялдуулж бодох ёстой гэж үздэг.

Хөгшчүүдийн сэтгэл санаа гундуухан байдаг. Тэтгэвэр бага тул дуртай зүйлээ хийх, сувилалд явах боломж хомс. Өвөл гадаа гарах хэцүү, нийгмийн

идэвх сул. Хавар, зун нар гарахад хөгшчүүл гадаа сууж ярилцан сэтгэлээ сэргээдэг нь ганцхан баяр баясгалан. Хүйтний улиралд уулзах, хамт байх дулаан байр байхгүй. Хүүхдүүд орой ажилтай ирээд ядарсан байдаг тул бидэнтэй их ярилцдаггүй. Зарим хөгшчүүл унаж бэртэж, ганцаарддаг.

Гэр хороололд бүжиглэдэг, тоглоом тоглодог хэдэн хөгшчүүл байдаг ч бидэнтэй нийлэхгүй, тэд залуу, идэвхтэй. Харин бидний нийгмийн амьдралын гол хэлбэр нь зуны өдөр гадаа нарлах, хууч хөөрөх явдал юм.

Кейс 3: Би охинтойгоо хамт амьдардаг. Охин маань нягтлан бодогчийн мэргэжилтэй, хувийн компанид ажилладаг. Би сард 898 мянган төгрөгийн тэтгэвэртэй, охин байр, тог цахилгааны төлбөрийг хариуцдаг. Тэтгэврийн мөнгөөрөө голдуу хоол хүнс, хувийн хэрэглээ (хувцас, гоо сайхан, бензин) зэрэг хэрэгцээгээ хангадаг. Эрүүл мэндийн онцгой асуудал гараагүй учраас одоохондоо хүрэлцээтэй байгаа ч эмчилгээ, эмнэлгийн зардал гарвал хүрэлцэхгүй.

Тэтгэврийн зээл одоогоор аваагүй. Охины цалин хязгаартай тул зээл авбал сар бүрийн амьжиргаанд хүндрэл учирна гэж үздэг. Хуримтлал байхгүй, учир нь ажиллаж байхдаа 1–1.2 сая төгрөгийн цалинтай байсан ч хувийн хэрэглээ өндөр тул хадгаламж үүсгэж чадаагүй.

Жилд 1–2 удаа халамжаар амралтад найз нөхөдтэйгөө явдаг, харин өөрийн мөнгөөр амрах, үйлчилгээ авах боломж хомс. Өрхийн хүнсний зардал хоёр хүнтэй тул бага гардаг ч ихэнх мөнгө хүнсэнд зарцуулагддаг. Сард нэг удаа үсчинд орж, даралтын эмээ авдаг.

Цагаан сарын үеэр мөнгө хүрэлцдэггүй, гэхдээ хүүхдүүд нь ууц, тавгийн идээ, бэлэг сэлтээ хувааж бэлтгэж өгдөг. Өвдөж эмнэлэгт хэвтэх үед тэтгэвэр тэр чигээрээ эм тарианд зарцуулагдаж байсан.

Төр, засгийн бодлогод шүүмжлэлтэй хандаж, цалин, тэтгэврийн хэмжээ амьдралд хүрэхгүй байгаа нь төрийн албаны зохион байгуулалт, бодлого муугаас шалтгаалж байна гэж үздэг.

Нийгмийн даатгалын шударга бус байдал хэцүү санагддаг. Нэг насаараа ажиллаж, шимтгэл төлсөн хүн бага тэтгэвэр авч байхад, өндөр шимтгэл богино хугацаанд төлсөн хүн илүү тэтгэвэр авах явдал шударга бус гэж үздэг. Энэ нь хүмүүсийн нийгмийн даатгалд хамрагдах сонирхлыг бууруулж байна гэж боддог.

Тэтгэврийн хэмжээг ажил хөдөлмөрийн бодит үнэ цэн, тухайн үеийн амьжиргааны түвшинтэй уялдуулж тогтоох хэрэгтэй гэж үздэг. 45 хувийн тогтоох хувь хангалтгүй гэж ойлгодог.

Мөн төрийн байгууллагууд татан буугдсанаас үүдэн ахмадууд харьяалалгүй болж, сэтгэл санааны хувьд хөндийрч байна. Би өөрөө 35 жил ажилласан байгууллага татан буугдаж, одоо хаана харьяалагдах нь тодорхойгүй болсон. Ахмадын баяраар нэг хүлээн авалт ч зохиогддоггүйд харамсаж байна.

4.4. Өрхийн зардалд өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөө

Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг өрхийн нийт зардалд өндөр насны тэтгэврийн эзлэх хувь хэмжээ, өндөр насны тэтгэврээс ахмад настан өөрийн хувийн хэрэглээгээ хангах боломж, хүрэлцээт байдал, өндөр насны тэтгэврээс бусдад дэмжлэг үзүүлэх байдлын хүрээнд тодорхойлно.

Өндөр насны тэтгэврийн зарцуулалт: Санал асуулгын судалгаагаар “Таны тэтгэвэр дараах хэрэгцээний алинд нь илүү зарцуулагддаг вэ?” гэсэн асуултад судалгаанд хамрагдагчдын 67.1 хувь нь өрхийн нийтийн хэрэгцээнд зарцуулагддаг гэсэнтэй уялдаж байгаа юм. Түүнчлэн, өрхийн нийтийн хэрэгцээнд болон хувийн хэрэглээнд зарцуулдаг ахмад настан 20.8 хувьтай байгаа нь өндөр насны тэтгэврийн зарцуулалтын дийлэнх буюу 90.0 орчим хувийг ахмад настан хувийн хэрэглээндээ зарцуулах боломж, бололцоо хязгаарлагдмал болохыг илэрхийлнэ.

Зураг 34. Өндөр насны тэтгэврийн өрхийн хэрэгцээнд зарцуулагдах байдал, хувиар




Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тэтгэврийн насны хүмүүсийн дийлэнх нь бага тэтгэвэртэй, улмаар амьжиргаанд нь хүрэлцээ багатай гэсэн дүгнэлт гарна. Үүнд цалингийн хэмжээ, ажиллаж байсан байгууллага, ажилласан жил, цалингийн итгэлцүүр гэсэн хүчин зүйлүүд нөлөөлж байна. Хүрэлцээгүй байдал сүүлийн үед улам нэмэгдэж байна. Бараа, үйлчилгээний үнэ өсөөд нөгөө талдаа тэтгэврийн хэмжээ нэмэгдэхгүй байгаа нь ахмад настнууд байтугай ажил хийж байгаа иргэдэд ч хүрэлцээ багатай нөхцөл байдлыг бий болгож байна. Мөнгөний бодлого, эдийн засгийн өсөлтийг хангах бодлого үр дүнгүй хэрэгжиж байгаагаас хамааран тэтгэврийн хүрэлцээ тааруу болж байна гэж ойлгож байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өндөр настнуудыг хүйсээр ангилан тэдний тэтгэврийн зарцуулалтын дүр зургийг харвал нийтийн зардалд зарцуулах байдал эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд төдийлөн ялгаагүй буюу 65–72 орчим хувьтай байна.

Зураг 35. Нийтийн ба хувийн зардалд зарцуулах тэтгэврийн зарцуулалтын хувь, хүйсээр



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Өндөр насны тэтгэврийн орлогыг ахмад настан зөвхөн өөрийн буюу хувийн хэрэглээнд зарцуулах байдлаар нь үзвэл эрэгтэй, эмэгтэй ахмад настнууд тоо хэмжээгээр нэн цөөн буюу ойролцоогоор 10 хүн тутмын нэг нь байна.

Хоол хүнс, бензин, байрны төлбөр, хоёр ачийн хувцас хунар гэх мэт зүйлд зарцуулдаг. Одоогоор амьдралдаа хүргээд л байна, хэрэв дутагдвал урд


хормойгоороо хойд хормойгоо гэдэг шиг зээл авах байдлаар шийдэх болов уу. Нийт зардлын бүтцээ харахаар өрхийн өргөн хэрэглээний, хүн бүрд хамааралтай зардал өндөр хувийг эзэлдэг. Өөртөө гэж бодож зарцуулдаг зардал бага.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Ийнхүү, нийтийн зардалд зарцуулж буй тэтгэврийн хувьд хүйсийн ялгаа харьцангуй байхгүй байдал нь өндөр настнууд хүйсээс хамааралгүйгээр өрхийн эдийн засагт оролцдог болохыг илэрхийлнэ.

Тэтгэврийн зардлын ихэнх буюу 58–73 орчим хувийг нийслэл, аймаг, сумын төвд амьдардаг ахмад настнууд өрхийн нийтийн хэрэглээнд зарцуулдаг. Харин аймаг, сумын төвд амьдардаг гурван өндөр настан тутмын ойролцоогоор нэг нь нийтийн болон хувийн хэрэгцээндээ зарцуулж байна.

Зураг 36. Нийтийн ба хувийн зардалд зарцуулах тэтгэврийн зарцуулалтын хувь, байршлаар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Нийслэл болон аймгийн төвийн өндөр настнуудын арав гаруйхан хувь нь, харин сумын төвийнхний хувь дөнгөж 7 орчим хувь нь өөрийн хэрэглээндээ зарцуулж байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

Хөдөөтэй харьцуулахад хотод тэтгэврийн хэмжээ арай өндөр, улмаар хүрэлцээтэй байдал өндөр байх магадлалтай. Учир нь хөдөө орон нутагт харьцангуй өндөр цалин олгох боломжтой аж ахуйн нэгж, байгууллагууд маш цөөхөн байдаг. Гэтэл хувийн хэвшлийн компаниуд захаас сард 3-аас дээш сая төгрөгийн цалин өгч байна. Мөн ажилтай, бизнес эрхэлдэг

хүүхдүүдтэйгээ амьдардаг бол тэтгэвэрт нэмэр болох талтай гэх мэт нөхцөл байдал нөлөөлж байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл


Өндөр настны хувийн хэрэглээний дундаж дүн судалгаанд хамрагдсан өрхүүдийн дундаж орлого болох 1,910,664 төгрөгтэй харьцуулахад тухайн орлогын талаас илүүг нь хувийн хэрэглээнд зарцуулдаг гэжээ. Үүнээс, өндөр настай эмэгтэй хүний хувийн хэрэглээний дундаж зардал эрэгтэйчүүдийнхээс тавь орчим мянган төгрөгөөр илүү байна.

Том зургаар харвал хүрэлцээ багатай байдал ажиглагддаг. Үүнд: Хувь хүний талаас тухайн хүний эрхэлж байсан ажил, албан тушаал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа, шимтгэлийн хувь хэмжээ, цалин, цаашлаад боловсролын түвшин зэрэг олон хүчин зүйл нөлөөлнө. Жишээ нь: Нийгмийн даатгалын шимтгэл 20 хүрэхгүй жил төлсөн бол бүрэн тэтгэвэр авах боломжгүй тул хувь тэнцүүлсэн буюу бага тэтгэвэр авна. Цалингийн түвшин бага буюу анхан, дунд шатны ажил эрхэлж байсан бол тэтгэвэр бага байхад нөлөөлнө, үүнийг гүнзгийрүүлээд судалбал боловсролын түвшинтэй уялдана. Мөн анхаарах нэг гол зүйл нь ямар байгууллага/салбарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан бэ гэдэг асуудал.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өрхийн нийтийн хэрэгцээнд зарцуулж буй тэтгэврийн зардал 2023 онд Засгийн газраас тэтгэврийн хэмжээнд оруулсан өөрчлөлт нь өрхийн нийтийн хэрэгцээ ба хувийн хэрэгцээний аль алинд болон өрхийн нийтийн хэрэгцээнд зарцуулах байдал 2.5–4 орчим пунктээр өссөн.

Зураг 37. Тэтгэврийн орлогын зарцуулалт, нийтийн ба хувийн зардлын төрөл, он, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Харин, ахмад настнуудын хувьд өөрийн хувийн хэрэгцээнд зарцуулах хувь хэмжээ эсрэгээрээ буурч 2023 оноос өмнө 17.5 хувьтай байсан бол 2023 оноос хойш энэхүү үзүүлэлт 7.5 пунктээр буурч 11 хувьд хүрсэн сөрөг дүнтэй болжээ. Түүнчлэн, нийтийн ба хувийн хэрэглээнд хослуулан зарцуулдаг байдал 20 гаруй хувьтай байгаа нь тэтгэврийн орлогыг бүрэн хувийн зардалд зарцуулах боломжгүй өндөр настан тодорхой түвшинд байгааг харуулж байна. Энэ нь тэтгэврийн орлого хэдийгээр өрхийн бусад орлогоос бага дүнтэй ч өрхийн эдийн засагт ихээхэн эерэг нөлөө үзүүлдэг болохыг илэрхийлнэ.

Өндөр насны тэтгэвэр нь хүнс, ахуйн хэрэглээ, хувцас, эм тариа, эмчилгээ зэрэг бүх зүйлд хүрэлцдэг, хүссэн газартаа аялахад нь хүрдэг, цаашлаад их, бага ямар нэгэн байдлаар хадгалах боломж бүрддэг бол эерэг нөлөөтэй гэж үзнэ. Тэгэхээр тэтгэврийг хүрэлцээт байдлаар тогтоохын хувьд 45 хувь гэдэг босго болон тэтгэвэр тогтоож буй аргачлалыг эргэн харах хэрэгтэй.


Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Эндээс, хэдийгээр өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх үр нөлөө өндөр байгаа ч, нөгөөтээгүүр өрхийн бусад орлогын хэмжээг нэмэгдүүлэх замаар өндөр настны хувийн хэрэглээнд зарцуулах тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага маш өндөр байгааг харуулна.

Өндөр насны тэтгэврээс ахмад настны хувийн хэрэгцээний зарцуулалт:

Өндөр настны хувийн хэрэглээний зардлын гуравны нэг орчим хувийг хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн эзэлж байгаа нь тэдний насны онцлогоос хамаарсан бүтээгдэхүүний хэрэглээ зайлшгүй шаардлагатайг илэрхийлнэ.

Зураг 38. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд зарцуулах үзүүлэлт, төгрөгөөр




Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Өндөр настнууд хэдийгээр нийтийн тээврийн үйлчилгээнд үнэ төлбөргүй зорчих эрхтэй хэдий ч тээврийн зардалд сард дунджаар 137,000 орчим төгрөг зарцуулж байна. Өндөр настнууд өдөр тутамдаа гадуур найз нөхөдтэйгөө уулзах, банк, дэлгүүр, хороогоор орох зэрэгт хувийн машинаар явах хэрэгцээ тулгарч байдаг нь тэдний хувийн зардлын нэг хэсэгт тээврийн зардал багтахад нөлөөлдөг. Энэ нь нэг талаасаа зардал нэмэгдүүлж байгаа ч нөгөөтээгүүр тэдний эрүүл мэндийн нөхцөл байдал амьдралын хэв маяг, сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлнэ. Өндөр настнуудын шинэ, хуучин хувцас, эд хэрэглэл нь гол төлөв үр хүүхдүүдээс нь шилжин ирсэн байдаг бөгөөд хувцас, эд хэрэглэлийн зардалд нийт хувийн зардлынхаа тавны нэг хувийг буюу дунджаар 189,000 орчим төгрөг зарцуулдаг болох нь дээрх зургаас харагдаж байна.

Эрэгтэй өндөр настнууд үс засуулах зэрэг хувийн үйлчилгээ, хувцас, эд хэрэглэл болон тээврийн зардалд эмэгтэйчүүдээс 23–47 орчим мянган төгрөгөөр өндөр хэрэглээтэй байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд хоол, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнд харьцангуй өндөр буюу 120,000 орчим төгрөгөөр илүү зарцуулдаг байна.

Зураг 39. Өндөр настны хувийн зардал, хүйс, төгрөгөөр



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Найз нөхөдтэйгөө уулзах зэрэг үйл ажиллагаанд улиралдаа нэг удаа явдаг. Тэр үедээ зардал яавал хамгийн бага байх вэ гэдгээ бодож тооцоолоод голдуу нэгнийхээ гэрт очих байдлаар шийддэг.


Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Эрэгтэй өндөр настнууд өөрийн нас, биеийн онцлогт хэрэгтэй хоол, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн төдийлөн хэрэглэж чадахгүй байгаа нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

Нийслэл хотод амьдардаг өндөр настнуудын хувийн хэрэглээний зардал нь аймаг, сумын төвд амьдардаг өндөр настнуудын хувийн хэрэглээний зардлаас 85–103 орчим мянган төгрөгөөр өндөр дүнтэй байна. Нийт хувийн хэрэглээний дундаж дүнгээр нийслэлд амьдардаг өндөр настнуудын хувийн зардал бага байгаа хэдий ч хоол, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнд зарцуулах тал дээр аймаг, сумын төвийн өндөр настнуудаас даруй 189–250 орчим мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь орон нутагт хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний нийлүүлэлт бага байдгаас шалтгаалж байгаа талтай юм.

Аймаг, сумын төвийн өндөр настнууд тээвэр болон хувцас, эд хэрэглэлд нийслэлийн өндөр настнуудаас 125–256 орчим мянган төгрөгөөр илүү зарцуулж байна. Чөлөөт цагт зориулсан зардлын хувьд нийслэл болон сумын төвийн өндөр настнууд дунджаар 22 мянган төгрөг, аймгийн төвийн өндөр настнууд 3 дахин их буюу 60 гаруй мянган төгрөг дунджаар зарцуулдаг.

Зураг 40. Өндөр настны хувийн зардал, байршил, төгрөгөөр



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Хүн ам төвлөрсөн гэдэг утгаараа нийслэлд амьдардаг өндөр настнуудын хувьд чөлөөт цагаа харьцангуй олон төрлийн үйл ажиллагаанд зарцуулах


боломжтой хэдий ч бага хэмжээгээр зардал үүсгэдэг болох нь харагдаж байна. Энэ нь тэдний эдийн засгийн нөөц, боломж бага байдагтай холбоотой юм.

Өндөр настнуудын нас ахих тусам тэдний хувийн зардал багасаж байгаа нь дараах зургаас харагдана. Насны хувьд хамгийн залуу ангилал буюу 65 хүртэлх насны хүмүүсийн дундаж хувийн зардал 85-аас дээш насныхнаас 300,000 орчим төгрөгөөр илүү байна. Энэ нь нэг талдаа, нас ахих тусам тэдний тэтгэвэр тогтоолгосон үеийнхээс өнөөгийн тэтгэврийн хэмжээ нь төдийлөн нэмэгдээгүйг илэрхийлнэ. Нөгөөтээгүүр, нас ахих тусам тэтгэврийн орлогоо өрхийн нийтийн зардалд зарцуулах нь нэмэгдэж байгаа талтай юм.

Миний хувьд бөөрний дутагдалтай, цус багадалттай шалтгаанаар уураг хэрэглэх, сар бүр аппаратад орох хэрэгцээ гардаг. Эрүүл мэндийн зардалд сард дунджаар 300 гаруй мянган төгрөг зарцуулдаг. Нэмээд Сэлэнгээс Улаанбаатар хотод очиж эмчилгээ, шинжилгээ хийлгэх бензин шатахуун, улсын эмнэлэг очер ихтэй бол хувийн эмнэлгээр үзүүлэх зэргээр зардал, чирэгдэл маш өндөр гарч байна.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Зураг 41. Өндөр настны хувийн зардал, насны ангилал, төгрөгөөр



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо


Хэдийгээр 86-аас дээш насны хүмүүсийн нийт хувийн зардлын дундаж нь бусад насны ангиллынхнаас харьцангуй бага байгаа ч тэдний эрүүл мэнд, тээвэр, хувцас, эд хэрэглэл, хувийн үйлчилгээний зардал ойролцоо дүнтэй байна. Ийнхүү, эрүүл мэндийн зардалд насны ангиллаас үл хамааран ойролцоо дүнтэй байгаа нь тэтгэврийн насны иргэдийн эрүүл мэндийн голлох зардлуудын нэг эм, тарианы үнийн хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагатай байгааг илэрхийлнэ.

Өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөөг өрхийн ам бүлийн тооноос хамааран харилцан адилгүй байгааг дараах зураг илэрхийлнэ.

Өрхийн амьжиргаа гэхээр өрхийн бүх гишүүдэд хуваагдаад тэтгэвэр хүрэлцээгүй гэсэн дүн гарна. Харин зөвхөн ахмад настанд хүрэлцээтэй байна уу гэвэл, өөрөөр хэлбэл нэг хүн дээр тулгуурласан тооцоо хийж үзвэл тодорхой хэмжээгээр хүрэлцээтэй гэсэн дүн гарах боломжтой. Дүүргийн хэмжээнд ахмадуудын 70 орчим хувь нь сая хүрэхгүй төгрөгийн тэтгэвэртэй, тэтгэвэр барьцаалсан зээлтэй байгаа гэдгээс хүрэлцээтэй байдал төдийлөн сайнгүй гэсэн нөхцөл байдал харагдаж байна гэж ойлгож байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Зураг 42. Өндөр настны хувийн зардал, өрхийн ам бүлийн тооны ангилал, төгрөгөөр



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тухайлбал, ам бүлийн тоо хамгийн олон буюу зургаа ба түүнээс дээш болон бага буюу нэг байх үед өндөр насны тэтгэврийг тухайн өндөр настны хувийн хэрэгцээнд зарцуулах байдал хамгийн их хэмжээтэй байна.

Бидний тэтгэврийн болон цалингийн мөнгө амьдралд тэр бүр хүрэлцээ багатай байдаг. Тэтгэврээ өөрөө тусгайлан өөрийн хэрэгцээнд зарцуулна гэдэг ойлголт байхгүй. Сардаа даралтын эм, үсний будаг, улирал солигдоход хэрэгтэй 1–2 хувцас гэх мэт зүйлд тэтгэврээсээ зарцуулж байна. Ер нь ганцаараа амьдардаг, 1.1 саяын тэтгэврээр авдаг байсан бол тэтгэврээр хүрэлцэх байсан байж магадгүй, тэр талаар бодож байгаагүй.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Ам бүлийн тоо нэмэгдэх тусам тухайн өрхийн орлогын төрөл, хэмжээ нэмэгдэж тэр хэрээр өндөр настан тэтгэврээ хувийн хэрэгцээнд зарцуулах боломж нэмэгдэж байна. Зургаан ам бүлтэй өрхийн өндөр настан хувийн хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнд нийт хувийн хэрэглээний зардлын 70 орчим хувийг зарцуулж байгаа нь тухайн өрхийн ахмад настны хүнсний чанар нэмэгдэж байгааг илэрхийлнэ.


Хүн ам зүйн талаас олон хүүхэдтэй байдлыг хөндөх хэрэгтэй санагддаг. Олон хүүхэдтэй учир эрт тэтгэвэрт гардаг, эрт тэтгэвэрт гарахаар жил бүрийн 1.5 хувийн нэмэгдлээ тооцуулах боломжгүй тул тэтгэврээр бага тогтоогдоход нөлөөлдөг. Залуучууд нь ажил хөдөлмөр эрхлэх хандлага бага, ухамсар дорой буюу аав, ээжийнхээ тэтгэврийг дураараа зарцуулж болно гэж үзэж буй манай улсын хувьд зайлшгүй анхаарах асуудал юм. Нөгөө талаас эрт тэтгэвэрт гараад өөр ажил хийж, санхүүгийн нөхцөл байдлаа дордуулахгүй авч явах боломж бий.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Ам бүлийн тоо олон байх нь тухайн өрхөд хөдөлмөр эрхлэгч гишүүний тоо нэмэгдэж орлогын түвшин өндөр байх боломж бүрдэн өндөр настан гишүүн нь тэтгэврийн орлогоо хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн худалдан авах боломжийг нэмэгдүүлж байна.

Өндөр насны тэтгэврээс бусдад дэмжлэг үзүүлдэг байдал: Өндөр насны тэтгэврийн орлого нь зөвхөн өрхийн дотоод хэрэглээнд ашиглагдахаас гадна бусад өрх, гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх чухал эх үүсвэр болдог.

Зураг 43. Тэтгэврийн орлогоос бусад дэмжлэг үзүүлдэг эсэх, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Судалгааны үр дүнгээс үзэхэд, судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 62.5 хувь нь хэн нэгэнд өндөр насны тэтгэврийн орлогоосоо дэмжлэг үзүүлдэг бол, 37.5 хувь нь үзүүлдэггүй байна. Энэ нь судалгаанд хамрагдсан ахмад настнуудын 2/3 орчим нь өндөр насны тэтгэврийг зөвхөн өөртөө буюу хувийн хэрэгцээнд бус, бусад өрхийн гишүүдэд зарцуулж буйг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдээс өндөр насны тэтгэврийн орлогоосоо хэнд дэмжлэг үзүүлж байгааг тодруулахад, талаас илүү хувь нь өөрийн хүүхдүүддээ, 43.3 хувь нь ач, зээдээ дэмжлэг үзүүлж, хамаатан болон бусад хүмүүст дэмжлэг үзүүлдэг байдал түгээмэл биш байгаа нь харагдлаа.

Тэтгэврийн орлогоо аль болох зөв зарцуулж, орлогодоо захирагдах байдлаар зарлагаа төлөвлөж, зохицуулж амьдрахыг хичээдэг. Гэвч үндсэн хэрэгцээгээ хангах, үр хүүхдэдээ туслах гээд төлөвлөөгүй зардал их гарна.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл


Зураг 44. Өндөр насны тэтгэврээс дэмжлэг үзүүлдэг субъект, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Өндөр насны тэтгэврийн орлогоос бусдад үзүүлж буй дэмжлэгийн давтамжийг судлахад, дийлэнх нь буюу 61.9 хувь нь сар бүр бусдад дэмжлэг үзүүлж байна. Харин үлдсэн хэсэг нь дэмжлэгийг хагас жил тутам буюу жилд нэг удаа үзүүлдэг байна.

Зураг 45. Өндөр насны тэтгэврийн орлогоос бусдад үзүүлж буй дэмжлэгийн давтамж, хувиар




Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Ийнхүү харьцангуй тогтмол шинжтэй буюу сар бүр тэтгэврийн орлогоос бусдад дэмжлэг үзүүлэх хандлага өндөр байгаа нь өндөр насны тэтгэврийн бусад гэр бүл, улмаар нийгэмд үзүүлэх нөлөөг харуулах чухал мэдээлэл болно.

Судалгааны үр дүнгээс харахад өндөр насны тэтгэврийн орлогоор бусдад дэмжлэг үзүүлдэг байдал нь өрхийн ам бүлийн тоо болон байршлаас хамааралтай байна.

Зураг 46. Тэтгэврийн орлогоос бусдад дэмжлэг үзүүлдэг өрхийн хувь, ам бүлийн тоо болон байршлаар



Ганцаараа эсвэл олон гишүүнтэй (6 ба түүнээс дээш) өрхүүдийн хувьд бусдад дэмжлэг үзүүлэх байдал харьцангуй бага байна. Үүнээс ганцаараа амьдагддаг өрхийн хувьд орлогын хэмжээ бага, өндөр насны тэтгэврийн орлого нь зөвхөн өөрийн хэрэглээнд зориулагддаг бол олон гишүүнтэй

өрхүүдийн хувьд өрхийн хэрэгцээ ихэсдэг тул дэмжлэг үзүүлэх боломж хязгаарлагддаг гэж үзэж болохоор байна.


Өндөр насны тэтгэврийн орлогоосоо бусдад дэмжлэг үзүүлдэг байдлыг өрхийн байршлаар авч үзвэл, Улаанбаатар хотын өрхийн 55 орчим хувь, аймгийн төвийн өрхийн 65 хувь, сумын төвийн өрхийн 77 орчим хувь бусдад дэмжлэг үзүүлдэг гэсэн байна. Үүнээс үзвэл орон нутагт, ялангуяа сумын төвийн өндөр настнуудын хувьд өндөр насны тэтгэврийн орлогоосоо бусдад дэмжлэг үзүүлэх байдал хамгийн өндөр байна. Энэ нь сумын төвд хөдөлмөр эрхлэлтийн түвшин бага, тэтгэвэр нь өрхийн орлогын чухал эх үүсвэр болж байгааг харуулж байна.

Сумын төвд ажлын байр бага, хөдөлмөр эрхлэх боломж хомс байдаг нь өндөр насны тэтгэврийн орлого өрхийн санхүүгийн гол эх үүсвэр болоход хүргэдэг. Хаяандаа байгаа ажилгүй хүүхдүүдийнхээ хэрэглээний зардлыг бүрэн хариуцаад явдаг аав, ээжүүд цөөнгүй.

Иргэдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Ахмад настнуудын амьдралын нэн чухал үйл явдлуудын нэг нь тэдний ач, зээгээ гэх сэтгэл юм. Ахмад настнуудын гурван хүн тутмын хоёр нь ач, зээдээ тодорхой хэмжээгээр тэтгэврийн орлогоосоо зарцуулдаг гэсэн хариултыг сонгожээ. Тэдгээрийн жар гаруй хувь нь сар тутамдаа ач, зээдээ зориулан зайрмаг, чихэр, жимс зэрэг амттан авч өгөн баярлуулах дуртай байдаг нь харагдаж байна.

Зураг 47. Өндөр насны тэтгэврээс ач, зээдээ зарцуулдаг байдал, хувиар



Ийнхүү эмээ, өвөө нар ач, зээгийнхээ дуртай амттанг авч өгөх явдал нь өрхийн нийтийн болон ахмад настны хувийн хэрэглээний зардлын аль, алинд нь хамаарахгүй хэдий ч эдийн засаг талаасаа уг тэтгэврийн зардлын тодорхой хувийг эзэлж байна. Нөгөөтээгүүр Нобелийн шагналт эдийн засагч Гарри Бэйкерийн тодорхойлсон “Шинэ өрхийн эдийн засаг”-ийн онолын

нэг хэсэг болох сэтгэл зүйд үзүүлэх өрхийн орлого, зардлын үр нөлөө ямар болохыг харах боломжтой юм. Эмээ өвөө ба ач, зээгийн эдийн засаг дээр суурилсан энэхүү харилцаа нь нэг талаасаа ахмад настнуудын хувьд ач, зээгийнхээ дуртай зүйлийг авч өгөн баярлуулах хүсэл, нөгөө талдаа ач, зээ нь эмээ, өвөөгөөсөө өөрийн дуртай амттанг авах хүсэл хоёрын нийцлийг бүрдүүлж гэр бүлийн баяр баясгаланг бий болгож байна. Энэ нь ахмад настнуудын урт удаан, эрүүл энх аж төрөх, ач, зээгийн хувьд нэг нэгийгээ гэсэн сайхан сэтгэлийг уламжлан үлдэх зэрэг маш олон талын чухал ач холбогдол бүхий харилцаа юм.


Өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт нөлөөлөх байдлыг тэтгэврийн зарцуулалт талаас судлахад өндөр настнуудын хувьд өрхийн нийтийн буюу гишүүн бүрийн хэрэглээний зардалд зарцуулагдсаны дараа үлдэх хэсгийг өөрийн хувийн хэрэглээнд зарцуулдаг болох нь судалгаанд хамрагдагчдын 67 хувь нь өрхийн нийтийн хэрэгцээнд зарцуулдаг, 21 хувь нь өрхийн нийтийн болон өндөр настны хувийн хэрэглээнд зарцуулдаг гэсэн үр дүнгээс харагдаж байгаа юм.

Өндөр насны тэтгэврийн зорилго болох тухайн өндөр настны хувийн хэрэгцээнд хүрэлцэх байдал нь ерөнхийдөө хангалтгүй, хувцас, эд хэрэглэл зэрэг зарим төрлийн зардал, цагаан сар зэрэг томоохон баяр ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах зардал зэргийг үр хүүхдүүдээс санхүүгийн болон эд хөрөнгийн туслалцаа авах замаар хангаж байна. Нас, хүйсийн ангиллаар авч үзвэл төдийлөн өндөр ялгаа харагдахгүй хэдий ч 65 хүртэлх насны өндөр настан болон эмэгтэй өндөр настнуудын хувьд хувийн хэрэглээ бага зэргийн өндөр дүнтэй байгаа нь тэдний нас, хүйсийн онцлогтой хамааралтай.

Өндөр настнууд тэтгэврийн орлого зарцуулалтаа маш сайн тооцоолон өдөр тутмын амьжиргаагаа залгуулж байгаа нь нийтлэг харагдаж байгаа бөгөөд хэрэв тухайн өрхийн хэн нэгэн гишүүн хүндээр өвдөх зэрэг эрүүл мэндийн болон бусад шалтгаанаас үүдэлтэй эрсдэл даван туулах чадвар сул байгааг анхаарах шаардлагатай байна.

Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцэх байдал: Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцэх байдлыг тодруулахад, ойролцоогоор 3/5 нь өндөр насны тэтгэврээр хувийн хэрэгцээгээ хангах боломжгүй гэж үзэж байгааг харж болно.

Зураг 48. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Харин, судалгаанд хамрагдсан ахмад настнуудын 30 хувь нь тодорхой хэмжээнд хүрэлцдэг, 27 хувь нь хангалттай хүрэлцдэг гэсэн хариултыг өгсөн нь өндөр насны тэтгэврийн хэмжээ харьцангуй бага байгааг харуулж байна.

Тэтгэврээ өөрөө тусгайлан өөрийн хэрэгцээнд зарцуулна гэдэг ойлголт байхгүй. Сардаа даралтын эм, үсний будаг, улирал солигдоход хэрэгтэй 1–2 хувцас гэх мэт зүйлд тэтгэврээсээ зарцуулж байна. Өөрийн тэтгэвэр 1.1 сая, нөхрийн цалин 2 сая. Нийлээд 3.1 сая төгрөгөөр бүх хэрэглээгээ зохицуулдаг. Бидний тэтгэврийн болон цалингийн мөнгө амьдралд тэр бүр хүрэлцээ багатай байдаг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл


Өндөр насны тэтгэвэр нь хоол хүнс, орон сууц, ахуйн хэрэглээ, ойр зуурын эм тариа зэрэг зөвхөн суурь хэрэгцээнд хүрэлцэж байгаа нь өндөр насны тэтгэвэрт гарсны дараа тэдний хэрэглээний төлөв байдалд өөрчлөлт гарч, хувцас, тээврийн зардал, болон зарим ахуйн хэрэглээний зардал буурдагтай холбоотой юм. Гэвч эрүүл мэндийн хувьд онцгой эмчилгээ, үйлчилгээ шаардлага бүхий гишүүнтэй өрхийн хувьд тэтгэврийн орлогоор хэрэгцээгээ хангахад боломжгүй нөхцөл үүсэхийн зэрэгцээ тэтгэврийн орлогоор олон улсад болон дотооддоо аялах зэргээр амралт, чөлөөт цагаа идэвхтэй өнгөрүүлэх боломж хязгаарлагдмал байна. Мөн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлт хурдтай байгаа нь өндөр насны тэтгэврийн худалдан авах чадварыг бууруулж, тэтгэврийн хүрэлцээтэй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Ахмад настнуудын 56 хувь нь бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээний тэтгэвэр авч байгаагаас үзвэл тэтгэвэр төдийлөн хүрэлцээтэй биш байна гэж дүгнэж болно. Үүнд бараа, үйлчилгээний үнийн өсөлт буюу инфляц, төсвийн хүрэлцээт байдал нөлөөлж байна. Төсөв хангалттай хүрэлцээтэй, эсвэл нийгмийн даатгалын сангийн хөрөнгө боломжийн бол тэтгэврийн хэмжээг өндөр тогтоох бүрэн боломжтой.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага

Өндөр насны тэтгэврийн хүрэлцээт байдлын үнэлгээг сарын дундаж тэтгэврийн хэмжээтэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

Зураг 49. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, сарын дундаж тэтгэврийн хэмжээ, төгрөгөөр



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тэтгэврийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр тэтгэврийн хүрэлцээт байдлын үнэлгээ дээшилсэн боловч өндөр тэтгэвэр авч байгаа хэдий ч хүрэлцээгүй гэж үзэх хандлага мэр сэр ажиглагдав. Тухайлбал, өндөр насны тэтгэвэр хангалттай хүрэлцдэг гэж хариулсан иргэдийн сарын дундаж тэтгэврийн хэмжээ тодорхой хэмжээнд хүрэлцдэг гэж хариулж буй өндөр настнуудаас 90 гаруй мянган төгрөгөөр доогуур байв.


Мэдээж тэтгэврийн хэмжээ хамгийн чухал учир бага тэтгэвэр авч байгаа хүмүүсийн хувьд амьжиргаанд хүрэлцээгүй байдал үүснэ. Түүнээс гадна ахмад настнуудын өөрсдийнх нь хандлага, амьдралдаа хүргэх гэсэн оролдлого, хүргэхийн төлөө ажиллаж, хөдөлмөрлөх байдал, сэтгэл ханамж бас чухал юм. Хэчнээн өндөр тэтгэвэр авч байгаа ч хүрэлцээгүй гэж үзэх хүмүүс байдаг.

Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Ахмад настны хувийн хэрэглээнд тэтгэврийн орлого хүрэлцээтэй эсэхийг тэтгэвэр тогтоолгосон хугацаагаар ангилан тодруулахад өндөр настнуудын

сэтгэл ханамж харилцан адилгүй байна. Хамгийн сүүлд тэтгэврийн хэмжээг 2023 онд шинэчлэн тогтоосноос хойш тэтгэвэрт гарсан гурван ахмад настан тутмын нэг нь сэтгэл ханамж өндөр буюу хангалттай хүрэлцдэг хэмээн судалгааны асуулгад хариулжээ. Харин, 2023 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон хоёр хүн тутмын нэг сэтгэл ханамж муу буюу огт хүрэлцдэггүй гэсэн хариултыг өгсөн.

Зураг 50. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, тэтгэвэр тогтоолгосон оноор, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Өндөр насны тэтгэврийн хэмжээнд өөрчлөлт оруулснаар тодорхой хэмжээнд хүрэлцдэг, хүрэлцдэггүй гэж хариулсан ахмад настануудын тоо 5–9 хувиар буурсан бол хангалттай хүрэлцдэг гэсэн хариултыг сонгосон ахмад настануудын хувь хэмжээ нэг дахин буюу 15 орчим хувиар өссөн нь нийт судалгаанд хамрагдсан иргэдийн ойролцоогоор гурван хүн тутмын нэг болсон эерэг үзүүлэлттэй байна.

Хугацааны ангилалгүйгээр авч үзвэл гурван хүн тутмын нэг нь тодорхой хэмжээнд хүрэлцдэг гэсэн хэдий ч тэтгэврийн орлого нь тэдний амьжиргаанд огт хүрэлцдэггүй хэмээн хариулсан иргэдийн тоо 10–13 хувиар илүү байлаа.

2010 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд авч байгаа тэтгэврийн хэмжээ бага, харин 2010 оноос хойш бол харьцангуй өндөр тогтсон гэж ойлгож болно. Итгэлцүүрийг зөв, бодитой тогтоож чадаагүй тул хугацааны хувьд хэдий чинээ өмнө тэтгэвэрт гарна, тэр хэмжээгээр бага тэтгэвэр авах байдал харагддаг. Үнэн хэрэгтээ ахмадууд 20–40 жил ажиллаад тэтгэвэртээ гарахад бараг хамгийн доод тэтгэвэр тогтоогддог. Хамгийн сүүлд тэтгэврийн

доод хэмжээг 689 мянган төгрөг болгож, 7 хувиар нэмэгдүүлсэн ч өргөн хэрэглээний барааны үнэ хэдийнээ 15–20 хувиар нэмэгдсэн байна. Эдийн засгийн чадавх хангалтгүй нөхцөлд хэрэгжих нь боломжгүй.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Хүйсийн ялгаатай байдлаар харьцуулан үзвэл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд тодорхой хэмжээнд хүрэлцдэг хэмээн хариулсан иргэдийн ихэнх нь эрэгтэй хүмүүс 36 хувь байсан бол огт хүрэлцдэггүй гэж хариулсан иргэдийн ихэнх нь эмэгтэйчүүд буюу 27 орчим хувьтай байв.

Зураг 51. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, хүйсээр, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Хангалттай хүрэлцдэг гэсэн хариултыг судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй хүмүүс ойролцоо дүнтэй буюу 2.4 хувийн ялгаатай байдлаар дүгнэсэн нь ахмад настнуудын хувьд хэрэглээний зөрүүтэй байдал харьцангуй бага юм гэж ойлгож болохоор байна.

Тэтгэврийн орлогоо хоол хүнс, түлээ нүүрс, саван, вок зэрэг гэр ахуйн хэрэглээний зүйлд зарцуулдаг. Тэтгэвэрт гарснаас хойш шинэ хувцас авах асуудал бараг байхгүй болсон, хүүхдүүдийн хуучин, өмсөхгүй хувцас өмсдөг болдог юм байна. Найз нөхөдтэйгөө уулзах зэрэг үйл ажиллагаанд улиралдаа нэг удаа явдаг. Тэр үедээ зардал яавал хамгийн бага байх вэ гэдгээ бодож тооцоолоод голдуу нэгнийхээ гэрт очих байдлаар шийддэг.


Иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй эсэхийг насны ангиллаар харвал 76–85 насны иргэдийн 60 хувь нь огт хүрэлцдэггүй гэсэн бол тус насны ангилалд хангалттай хүрэлцдэг гэж хариулсан нь нийт хариултын

хамгийн бага буюу 13.3 хувьтай байна. Энэ нь 76–85 насны иргэдийн тэтгэврийн орлого бусад насны ангиллын харьцангуй тааруу үзүүлэлттэй байгааг илэрхийлнэ.

Насны ангиллаар харьцангуй дундаж болох 66–75 настай иргэдийн сэтгэл ханамжийн түвшин ойролцоо буюу санал асуулгын хариулт тус бүрийг ойролцоогоор гурван хүн тутмын нэг нь сонгосон байдалтай байна. Гэсэн хэдий ч, 65 хүртэлх–85 насны ангиллыг нэгтгэн харвал огт хүрэлцдэггүй гэсэн хариулт 42.9 хувьтайгаар давамгайлж байгаа нь өндөр настнуудын хувийн хэрэглээгээ хангах боломж, хүрэлцээ нэлэнхүй байдлаар хангалтгүй байгааг илэрхийлнэ. Түүнчлэн, хангалттай болон тодорхой хэмжээнд хүрэлцдэг тэтгэврийн орлоготой иргэд жар орчим хувьтай байгаа нь өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө төдий чинээ өндөр болохыг харуулна.

Зураг 52. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, насны ангиллаар, хувиар




Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Түүнчлэн, 86 ба түүнээс дээш насны ахмад настнууд хангалттай хүрэлцдэг болон тодорхой хэмжээнд хүрэлцдэг гэсэн хариултуудыг тэнцүү байдлаар сонгож, харин огт хүрэлцдэггүй гэж нэг ч хүн хариулаагүй байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь тухайн 86 ба түүнээс дээш настай ахмад настнууд гол төлөв хөдөлмөрийн насны үр хүүхдүүдтэйгээ амьдардаг буюу цалингийн орлоготой өрхөд амьдардаг байх талтай юм.

Орон сууц, гэрт амьдардаг өндөр настнуудын тэтгэвэр тэдний хувийн хэрэглээнд хүрэлцдэг, тодорхой түвшинд хүрэлцдэг болон хүрэлцдэггүй гэж хариулсан иргэдийн тоо ойролцоо буюу хариулт тус бүрийг ойролцоогоор

гурван хүн тутмын нэг нь сонгосон байдлаас харагдаж байна. Харин хашаа байшинд амьдардаг хоёр ахмад настан тутмын нэгнийх нь өндөр насны тэтгэвэр тэдний хувийн хэрэглээнд хүрэлцдэггүй болохыг илэрхийлжээ. Энэ нь тус төрлийн сууцанд амьдарч буй иргэдийн өрхийн өдөр тутмын зардал өндөр, үүнийг дагаад хувийн зардалд зарцуулах боломж бага байх талтай юм.

Зураг 53. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, орон сууцны төрлөөр, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Тохилог байшин/хаусд амьдардаг өндөр настнууд хангалттай хүрэлцдэг гэсэн хариултыг огт сонгоогүй бөгөөд хоёр хүн тутмын нэг тодорхой хэмжээнд хүрэлцдэг, харин үлдсэн 30 гаруй хувь нь огт хүрэлцдэггүй гэжээ. Эдгээр ахмад настнуудын хувьд тодорхой хэмжээнд хүрэлцдэг хэмээн хариулсан нь цалин, ХАА-н зэрэг бусад өрхийн орлого харьцангуй өндөр учир тодорхой цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол худалдан авах тухай ойлголт юм.


Дэд бүтцийн үйлчилгээнд ойр, өмчтэй, МАА, газар тариалан эсвэл ямар нэгэн орлого олох эх үүсвэртэй, өрхийн хувьд тэтгэвэр хүрэлцээтэй байх талтай.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өрхийн байршлаар ахмад настны хувийн хэрэглээнд хүрэлцдэг эсэхийн ялгаатай байдлыг тодорхойлох асуултад нийслэл хот болон аймгийн төвд амьдардаг иргэдийн өндөр насны тэтгэвэр тэдний хувийн хэрэглээнд хүрэлцдэггүй гэсэн хариулт 43–47 орчим хувьтай, сумын төвд дээрхээс 10–14 орчим хувиар бага байгаа нь томоохон суурин газрын хүн амын төвлөрөл,

бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нь сумын төвөөс эрс илүү сонголт ихтэй буюу эдийн засгийн хөгжлийн ялгаатай байдлаас хамааралтай.

Зураг 54. Өндөр насны тэтгэврийн хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй байдлын үнэлгээ, байршлаар, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо


Сумын төвд амьдардаг иргэдийн өндөр насны тэтгэврийн хувийн хэрэглээнд хүрэлцэх байдал нь эсрэгээрээ нийслэл болон аймгийн төвд амьдардаг иргэдийнхээс 30 хүртэл хувиар өндөр байна. Энэ нь сумын төвд амьдардаг ахмад настнуудад өдөр тутмын худалдан авалт хийх хэрэгцээ шаардлага харьцангуй бага байдаг болохыг илэрхийлнэ. Нийслэл амьдардаг ахмад наснуудын хувьд хангалттай хүрэлцдэг гэсэн хариулт хамгийн бага буюу ойролцоогоор арван хүн тутмын нэг нь, харин огт хүрэлцдэггүй гэсэн хариултыг хоёр хүн тутмыг нэг нь хариулсныг харвал төв суурин газар болох нийслэлд амьжиргааны түвшин орон нутагтай харьцуулахад муу байгаа нь тодорхой юм.

Улаанбаатар хотын хувьд тэтгэвэр өндөр тогтоогдох зарим нэг нөхцөл байгаа боловч эргээд халаалт, сар бүрийн тогтмол зардал зэрэг хэрэглээний зардал ихтэй тул хүрэлцээт байдал адил болох талтай. Түүнчлэн, хот суурин газарт амьдралын өртөг өндөр, эмнэлэгт үзүүлье гэхэд заавал таксинд суух хэрэгтэй болдог гээд үзвэл хот суурин газарт тэтгэврийн хүрэлцээгүй байдал илүү нийтлэг яригдах болов уу. Хөдөө орон нутагт амьдардаг, ялангуяа малтай айл өрхүүдийн хувьд хэрэглээний зардал төдийлөн өндөр биш учир бага тэтгэвэртэй байсан ч сар бүрийн хэрэглээндээ хүргээд байдаг байх талтай.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өрхийн нийтлэг хэрэгцээнд зарцуулж буй тэтгэврийн зардал 2023 онд Засгийн газраас тэтгэврийн хэмжээнд оруулсан өөрчлөлтөөс үл хамааран 67 орчим хувьтай байна.

Зураг 55. Тэтгэврийн орлогын зарцуулалт, нийтийн ба хувийн зардлын төрөл, он, хувиар



Эх сурвалж: Санал асуулгын судалгааны өгөгдөлд суурилсан тооцоо

Түүнчлэн, нийтийн ба хувийн хэрэглээнд хослуулан зарцуулдаг байдал 20 орчим хувьтай байгаа нь тэтгэврийн орлогыг зуун хувь зардалд зарцуулах боломжгүй өндөр настан тодорхой түвшинд байгааг харуулж байна. Энэ нь тэтгэврийн орлого хэдийгээр өрхийн бусад орлогоос бага дүнтэй ч өрхийн эдийн засагт ихээхэн эерэг нөлөө үзүүлдэг болохыг илэрхийлнэ. Хувийн хэрэглээнд зарцуулдаг өндөр настнууд 2023 оноос өмнө 17.5 хувьтай байсан бол 2023 оноос хойш энэхүү үзүүлэлт 7.5 пунктээр буурч 11 хувьд хүрсэн сөрөг дүнтэй болжээ.

Өндөр насны тэтгэвэр нь хүнс, ахуйн хэрэглээ, хувцас, эм тариа, эмчилгээ зэрэг бүх зүйлд хүрэлцдэг, хүссэн газартаа аялахад нь хүрдэг, цаашлаад их, бага ямар нэгэн байдлаар хадгалах боломж бүрддэг бол эерэг нөлөөтэй гэж үзнэ. Тэгэхээр тэтгэврийг хүрэлцээт байдлаар тогтоохын хувьд 45 хувь гэдэг босго болон тэтгэвэр тогтоож буй аргачлалыг эргэн харах хэрэгтэй.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Эндээс, хэдийгээр өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх үр нөлөө өндөр байгаа ч, нөгөөтээгүүр өрхийн бусад орлогын хэмжээг нэмэгдүүлэх замаар өндөр настны хувийн хэрэглээнд зарцуулах тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага маш өндөр байгааг харуулна.

Өрхийн зардалд өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөтэй холбоотой кейс: Судалгааны хүрээнд өндөр насны тэтгэвэр нь өрхийн зардалд хэрхэн нөлөөлж буйг тодруулах зорилгоор дараах 4 төрлийн кейс боловсруулан танилцуулж байна.

Кейс 1: Өрхийн ам бүлийн тоо 2, нөхөртэйгөө хамт амьдардаг. Хоёулаа насаараа төмөр замд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ суусан.

Нөхөр төмөр замын машинист, миний хувьд инженерээр ажиллаж байсан. Намайг 2013 онд тэтгэвэрт гарахад 700 мянган төгрөгөөр тогтоосон. Одоо нэмэгдээд 1.6 сая төгрөг болсон. Нөхөр 2011 онд суусан, одоогоор 1.5 сая төгрөгийн тэтгэвэртэй. Бидний тэтгэврийн орлого амьдрал ахуйд хүрэлцээ багатай. Мэдээж зөвхөн суурь шинжтэй буюу хоол хүнс гэх мэт хэрэгцээгээ хангахад их тансаг биш ч болоод л байдаг. Харин цагаан сар гэх мэт томоохон баяр, эсвэл гэр бүлд өндөр зардал гарахаар үйл явдал тохиолдвол тэтгэвэр хүрэлцэхгүй нөхцөл байдал үүсдэг.

Хүнс, орон сууц гэсэн зардалд голлон зарцуулагддаг. Одоогоор нөхөр бид хоёр тус тусын буюу хувийн гэхээр хэрэглээнд тэр бүр зарцуулах боломж хомс л байна. Уг нь эрүүл мэндээ дэмжих, хамгаалах үүднээс ядаж амин дэм, витамин хэрэглэмээр байвч орлогодоо баригдаад төдийлөн авч хэрэглэдэггүй.

Нэмэлт буюу тооцоологдоогүй гэнэтийн зардал үүссэн тохиолдолд үр хүүхдийнхээ гар хардаг. Бас насны хишиг гэх мэт мөнгө бага гэлтгүй нэмэр үзүүлдэг.

Зээл тавихаас айдаг. Авч байхдаа сайхан ч гэсэн дараа эргүүлэн төлнө, төлж байгаатай уялдаад бусад хэрэгцээгээ зохицуулах шаардлага гарна гэх мэт асуудал ихтэй учир аль болох зээл авахгүй байхыг эрмэлздэг.

Ямар нэгэн хуримтлал үүсгэсэн зүйл үгүй, угаасаа тийм боломж ч байхгүй. Сар бүрийн тэтгэврээрээ тухайн сарынхаа бүх хэрэглээгээ болгоод явдаг. Үндсэндээ сарын 25-наас хойш мөнгөгүй болдог.

Тэтгэвэр анх 700 мянган төгрөгөөр тогтсон. Тухайн үед боломжийн хүрэлцээтэй байсан. Гэтэл 2023 онд тэтгэврийг итгэлцүүрээр нэмэгдүүлэхдээ 1,404 мянгаар хязгаар тогтоож нэмэгдүүлснээс шалтгаалаад харьцангуй өндөр тэтгэвэр авдаг байсан хүмүүс хохирсон. Энэхүү хохирсон хүмүүсийн тоонд миний нөхөр орсон. Тухайн үед миний нөхөр 1,404 мянгаас дээш тэтгэвэртэй байсан тул нэмэгдээгүй, харин түүнээс доогуур тэтгэвэр авдаг байсан хүмүүсийнх нэмэгдээд нөхрийнхөөс илүү болж таарсан. Энэ бол гэр бүлийн хүний хувьд халуунд халж, хүйтэнд хөрж насаараа төмөр замд

ажилласан боловч тэр хөдөлмөрийн үнэ цэн тэтгэврийн итгэлцүүрийн алдаанаас болж алдагдах нөхцөл бүрдсэн гэж ойлгож болно.

Тэтгэврийг инфляцын түвшин, мөнгөний ханштай уялдуулан бодитоор нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Бага тэтгэвэртэй хүмүүсийг илүү хувиар нэмэгдүүлэх зарчим нь шударга байдлын талаасаа үр дүнгүй нөхцөл гэж ойлгож болно. Нөгөө талаас, татвар төлөөгүй боловч нийгмийн даатгалын шимтгэлээ өндөр дүнгээр төлөөд илүү хэмжээний тэтгэвэр авдаг явдлыг өөрчлөх хэрэгтэй. Тухайн хүн зээл тавиад ч хамаагүй өндөр дүнгээр шимтгэл төлөөд өндөр дүнтэй тэтгэвэр авах нөхцөл бүрдэж байна.

Кейс 2: Би 63 настай, охинтойгоо хоёулаа амьдардаг. Охин нягтлан бодогч мэргэжилтэй. Голдуу хувийн компанид ажилладаг.

Сард 898 мянган төгрөгийн тэтгэвэртэй. Охины цалин хэдэн төгрөг байдгийг мэдэхгүй. Өөртөө хувцас хунар, гоо сайхны бүтээгдэхүүн, машины бензин шатахуун гээд зарцуулаад дуусдаг. Байр, тогны мөнгийг охин хариуцан төлдөг. Одоогоор эрүүл мэндийн онцгой хэрэгцээ гараагүй тул тэтгэврийн мөнгөөр гол хэрэгцээгээ болгоод байна. Хэрэв эмнэлгээр явах гэх мэт хэрэгцээ гарвал хүрэлцэхгүй талдаа орох байх. Жилд 1–2 удаа халамжаар амралтад найз нөхөдтэйгөө явдаг. Өөрөө мөнгөө төлөөд амрах, үйлчилгээ авах боломж бага.

Хоол хүнсэндээ голдуу зарцуулдаг. Ам бүл хоёулаа тул өрхийн хүнсний хэрэглээ нэг их өндөр гардаггүй тулдаа болж байна. Сард нэг удаа үсчинд ордог. Даралтын эмээ авдаг. Хүнсний өөрийн хэрэглээ гэж үзэх үү гэдгээс хамаараад хувийн, нийтлэг хэрэгцээ өөр гарах байх.

Цагаан сараар бол дутагдана. Тэр үед хүүхдүүд ууц, тавгийн идээ, бэлэг сэлт гээд хуваагаад бэлдээд өгдөг. Эмчилгээний үеэр бас дутагдах шинжтэй юм билээ. Хэдэн жилийн өмнө өвдөөд хэвтэхэд тэтгэвэр тэр чигээрээ эм тарианд зарцуулагдсан.

Тэтгэврийн зээл одоогоор аваагүй. Учир нь охины цалин бараг харагддаггүй учраас хэрэв зээл авбал сар бүр хоолоо яахав гэдэг асуудал гарна гэж бодоод аваагүй байна.

Хуримтлал байхгүй. Тухайн үед цалин 1–1.2 сая төгрөг байсан, гэхдээ ажил хийдэг хүнд хувцас хунараас эхлээд хэрэгцээ өндөр тул хадгалах боломж бүрдээгүй. Ер нь миний бодлоор цалин, тэтгэврийг амьдралд хүргэхүйц хэмжээнд аваачих бодлого алдагдсан, ХНХЯ, Засгийн газар ажлаа маш муу хийж байна гэж боддог.

Хуулийн цоорхойг хаах хэрэгтэй гэж боддог. Нэг насаараа ажиллаж, шимтгэл төлөөд нэг сая хүрэхгүй төгрөгийн тэтгэвэр авч байхад гэртээ сууж байгаад өндөр шимтгэл төлж, өндөр тэтгэвэр авч байгаа нь зохимжгүй. Иймэрхүү шударга бус зүйлүүд нийгмийн даатгалд хамрагдах сонирхлыг бууруулахад нөлөөлж байна.

Тэтгэврийн хэмжээг тухайн үед ажил хөдөлмөр хийж байх үеийн үнэ цэнээ хадгалж үлдэх боломжтой хэмжээнд тогтоох тал дээр анхаарах хэрэгтэй. Тэгэхээр одоогийн тооцож буй 45 хувь хангалттай биш гэж ойлгогдоно. Төрийн алба тогтворгүй байдлаас хамааран ахмадуудын ажиллаж байсан байгууллага татан буугдах тохиолдол цөөнгүй гарч, ахмадууд харьяалалгүй болж байна. Энэ нь тэдний сэтгэл санаанд нөлөөлдөг учир энэ асуудлыг шийдэж өгөх хэрэгтэй байна. Миний хувьд 35 жил ажилласан байгууллага татан буугдаад одоогоор хаана харьяалагдах нь тодорхой бус, ахмадын баяраар нэг хүлээн авалт ч болтугай хийдэг. Одоогоор тэр арга хэмжээ ч болсонгүй.

Кейс 3: Би одоо 68 настай, ам бүл 4. Нөхөр, зээ хүү болон охины хамт амьдардаг. Сард 1.5 сая төгрөгийн тэтгэвэр авдаг. Охины цалин 1.8 сая, нөхрийн тэтгэвэр 950 мянга. Хэрэгцээгээ хангах боломж эрүүл мэндийн онцгой зардал шаардлагагүй үед болж байсан, одоогоор хэцүү байна.

Өөрийн хэрэгцээгээ ч хангаж чадахгүйд хүрсэн. Учир нь жилийн өмнө элгээ боолгосон. Одоо нэг уураг авахад 350 мянган төгрөг байна. Аймагт ирэхээр дахиад үнэ нь нэмэгддэг. Бусад хэрэгцээг охины цалин, нөхрийн тэтгэврээр зохицуулж байна.

Сүүлийн 2 зөвхөн эрүүл мэндийн зардал гээд бусад хэрэглээнд хувь нэмэр үзүүлэхээ больсон. 3–4 удаа эмнэлэгт хэвтэхэд хувийн эмнэлгийн төлбөр сарын тэтгэврээс даваад явах тал руугаа орж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ тааруу учраас зориуд Улаанбаатар хотод очиж эмчилгээ авдаг, үүнтэй холбоотойгоор зардал мөнгө ч нэмэгддэг тал бий.

Тэтгэвэр барьцаалсан зээл аваад эмнэлгийн зардалд нэмэрлэсэн. Мэдээж зээлийн төлбөрт тал нь зарцуулагддаг учраас хүрэлцээгүй болох, зөрчил үүсэх асуудал мэр сэр гарч байна. Гэхдээ тухайн үед эрүүл мэндийн нэн шаардлагатай үед хэрэг болсон гэж бодохоор өөдрөг байдаг.

Багахан хэмжээний хадгаламж бий болгосон хэдий ч бага багаар зарцуулсаар үндсэндээ дууссан. Хүүхдийн орон сууц, хурим гээд хадгаламжийн дийлэнх нь зарцуулагдсан.

Миний тэтгэвэр харьцангуй бодитой. Харин эхнэрийн тэтгэвэр маш багаар тогтсон. Албан байгууллагын хариуцлагагүй байдлаас хамаараад шилжилтийн үед ажил, хөдөлмөр эрхэлж байсан талаарх баримт нотолгоо нь олдоогүй тул 20 жилээс илүү ажилласан боловч илүү ажилласан жил тутамдаа 1.5 хувиар тэтгэврээ нэмэгдүүлэн авах боломжгүйд хүрсэн.

Ахмад настнуудын нөхцөл байдлыг харгалзан үзэж, үзүүлэх тусламж, дэмжлэгийг ялгаатай болгоход анхаарах хэрэгцээ бий. Тухайлбал, эрүүл мэндийн онцгой хэрэгцээ, шаардлагатай ахмадуудын хувьд ямар нэгэн нэмэлт дэмжлэг, үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал байна. Очер дугааргүй эмнэлэгт хэвтэн үйлчлүүлэх боломжгүй.

Кейс 4: Би 72 настай, ам бүл 3. Эхнэр, зээ охины хамт амьдардаг. Эхнэр ахлах сувилагч, миний хувьд нийгмийн даатгалын салбарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан. Миний тэтгэвэр 1.5 сая, эхнэрийнх 900 мянга буюу нийт 2.4 сая төгрөгийн тэтгэвэр авдаг. Өөрийн тусдаа хэрэглээ гэхээр зүйл бараг байхгүй. Сард 1–2 ширхэг тамхи, машины бензин л авдаг. Тэдгээрт бол хангалттай хүрэлцэнэ.

Эхнэр бид хоёрын тэтгэвэр хоол хүнс, орон сууц, зээ охины хувцас хунар гэх мэт зүйлд зарцуулагддаг. Тэтгэвэр өрхийн хэрэглээнд голлон зарцуулагддаг гэж ойлгож болно. Хааяа нэг найз нөхөд, хамт ажиллаж байсан хүмүүстэйгээ уулздаг, гэхдээ зардал хамгийн бага байх нөхцөлийг бодолцож, аль болох хэрэглээ бага гаргах талаас анхаардаг.

Ерөнхийдөө суурь маягийн хэрэглээндээ хүрэлцэж байна. Гэхдээ хамгийн хямдыг сонгох, яавал арай бага дүнтэй тусах вэ гэдгийг байнга бодож явдаг болохоор сар бүр орлого хангалттай хүрдэг гэж хэлэх бас хэцүү. Гэхдээ төрийн хишиг гэдэгчлэн том зардал гарчихгүй бол болгоод явах боломжтой.

Зээл аваагүй. Социализмын үеийн бидний хувьд зээл гэдэг ойлголтоос хол байхыг хичээдэг. Өмнө нь нэг удаа тэтгэврийн зээл авч, хүүхдийн бизнест нэмэрлэж байсан. Гэхдээ сар болгоны тэтгэврээс хасагдахаар бас төвөгтэй юм билээ. Мэдээж үр хүүхэддээ тусалсан гэж бодохоор сэтгэл өег байдаг ч бодит байдал дээр залуучууд орон гэртэй болох хэцүү байгаа тул туслахаас аргагүй байдал үүссэн.

Хадгаламжаа хүүхдийн байр сууцанд нэмэрлээд дууссан. Ерөнхийдөө цалин хангалттай хэмжээнд бус, нэмээд хуримтлуулах зуршил тааруу учраас хадгаламж хийх боломж хязгаарлагдмал байна уу гэж ойлгодог.


Тусдаа хууль, тогтоомжоороо зохицуулагддаг учир бодитой тогтоогддог гэж ойлгож байна. Гол нь тухайн хүн ажил хөдөлмөр эрхлээд хэр хугацаанд, ямар дүнгээр нийгмийн даатгалын санд хувь нэмэр оруулснаас хамааран тэтгэврийн хэмжээг тогтоох нь зөв. Өөрөөр хэлбэл, тухайн хүний хариуцлагын асуудал тэтгэврийн хэмжээтэй уялдах нь зөв зүй тогтол юм.

Тэтгэврийн худалдан авах чадварт дүйцүүлэн нэмэх асуудал чухал байна. Мөн индексжүүлэх байдлаар нэмэхдээ дээд хязгаарыг үндэслэлтэй тогтоож, тэтгэвэр авагчдыг хохироохгүй байх тал дээр анхаарах нь зөв болов уу. Сүүлийн буюу 2023 оны нэмэгдэл нь 1,404 мянгаар таслахаар хохирсон ахмадууд багагүй бий. Ахмад настнуудын хувьд эрүүл мэндийн онцгой хэрэгцээтэй, гэтэл эрүүл мэндийн сан мөнгөгүй болсон гэдэг сонин логик яваад байна. Шимтгэл татахдаа нийгмийн даатгалын нэг хэсэг гэж төвлөрүүлсэн атлаа бодит байдал дээр хянах боломжгүй тусдаа сан бий болгож, зарцуулж байгаа нь буруу гэж үздэг. Ер нь тэтгэврийн зөрүү бол арилахгүй. Яагаад гэвэл хүн бүрийн боловсрол, эрхэлж буй ажил, хүлээж буй хариуцлага бүгд өөр тул зөрүү гарна. Харин нэг төрлийн ажил хийж байгаа атлаа тэтгэвэрт гарсан оноос хамаараад ялгаатай тэтгэвэр авдаг явдлыг халах тал дээр төрийн бодлого чиглэх нь зүйтэй гэж бодож байна.

4.5. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг дээшлүүлэхэд анхаарах асуудал

Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх эерэг нөлөөг нэмэгдүүлэх, ахмад настнуудын амьжиргааны баталгааг сайжруулах зорилгоор бодлогын ямар чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай талаар салбарын мэргэжилтнүүдийн байр суурийг тодруулан нэгтгэл хийлээ.

Зураг 56. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг дээшлүүлэхэд анхаарах асуудлын талаарх саналын нэгтгэл, хувиар



Эх сурвалж: Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын үр дүнд суурилсан ангилал

Мэргэжилтнүүдийн саналыг бодлого, эрх зүйн баримт бичиг, судалгааны үр дүн, статистик өгөгдөлтэй уялдуулан тодруулж, холбогдох саналыг дараах байдлаар тодорхойллоо.

Тэтгэврийн хэмжээг жил бүр итгэлцүүрээр нэмэгдүүлэх: “Ахмад настны тухай” Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлд **“8.3. Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцын өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ”** гэж заасан. 1994 оноос хойш Засгийн газраас нийт 41 удаа тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоохдоо гол төлөв тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх байдлаар өөрчилсөн байна.

Хүснэгт 24. Амьжиргааны доод түвшин болон тэтгэвэр, цалингийн хэмжээ

Үзүүлэлт	Дүн (төгрөг)	Харьцуулсан үзүүлэлт	Дүн
Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ	572,400	ХХДХ-д хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээний эзлэх хувь	79.5
Бүрэн тэтгэврийн доод хэмжээ	689,000	ХХДХ-д бүрэн тэтгэврийн доод хэмжээний эзлэх хувь	95.7
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	720,000	Дундаж цалинд дундаж тэтгэврийн эзлэх хувь	33.0
Амьжиргааны доод түвшин ⁴	488,950	Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээнд амьжиргааны доод түвшний эзлэх хувь	117.1
Тэтгэврийн дундаж түвшин	865,123	Бүрэн тэтгэврийн доод хэмжээнд амьжиргааны доод түвшний эзлэх хувь	140.9
Цалингийн дундаж түвшин	2,621,900	Дундаж тэтгэвэрт амьжиргааны доод түвшний эзлэх хувь	176.9

Эх сурвалж: НДЕГ-ын нэгдсэн сан; ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn.

2025 оны байдлаар ХХДХ-д хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 79.5 хувь, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 95.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс доод тэтгэврийн хэмжээ ур чадвар бага шаардах энгийн ажил эрхлэгчдийн цалингаас 4.3–20.5 пунктээр хоцорсон нь харагдаж байна.

Тэтгэврийн доод хэмжээг тухайн жилийн ХХДХ-ний 75 хувиас бууруулахгүй байхаар тооцоолсон, одоогийн байдлаар бүрэн болон хувь тэнцүүлсэн доод тэтгэврийн дундаж ХХДХ-ний 87 орчим хувьтай байна гэсэн тооцоолол гарч байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуулийн дагуу цалин, түүнтэй адилтгах орлогын 45 хувиар өндөр насны тэтгэврийн хэмжээг тогтоож байна. Улмаар нийгмийн даатгалыг 240 сараас илүү төлсөн жил тутамд 1.5 хувийн нэмэгдэл тооцон олгож байна. 2025 оны байдлаар дундаж тэтгэвэр нь дундаж цалингийн 33.0 хувийг нөхөж байгаа нь ОУХБ-ын зөвлөмж⁵, хуульд заасан хэмжээнээс даруй 7.0–12.0 пунктээр доогуур байна. Энэ нь тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын түвшинг харгалзан итгэлцүүр, индексээр нэмэгдүүлж чадахгүй байгаагийн илрэл юм.

⁴ 2025 онд амьжиргааны доод түвшин бүсээс хамааран 482,900–495,000 төгрөг байна.

⁵ “Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай” 102 дугаар конвенцод тэтгэврийн хэмжээг цалингийн 40 хувиас багагүй дүнгээр тогтоохыг зөвлөмж болгосон.

Хамгийн сүүлд бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689 мянган төгрөг болгож, 7 хувиар нэмэгдүүлсэн ч өргөн хэрэглээний барааны үнэ хэдийнээ 15–20 хувиар нэмэгдсэн байна. Сүүлийн 8–9 жилд хийгдээгүй ажил буюу тэтгэврийг итгэлцүүрээр нэмэгдүүлэх ажлыг 2023 оны 7 сард хийж, 2024 оноос эхлэн жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлж байхаар тусгасан.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өндөр насны тэтгэвэр нь амьжиргааны доод түвшнээс өндөр тогтоогдож, ахмад настныг ядуурлаас ангид аж төрөх нөхцөл боллоцоог хангах учиртай. Одоогоор хувь тэнцүүлсэн болон бүрэн тэтгэврийн цаашлаад дундаж тэтгэврийн хэмжээ амьжиргааны доод түвшнээс 1.2–1.8 дахин өндөр боловч 2 хүрэхгүй байгаа нь тэтгэвэр зөвхөн тухайн ахмад настны наад захын хэрэгцээнд хүрэлцэж, өрхийн бусад гишүүдийн хэрэгцээг хангахад хувь нэмэр багатай байгааг илэрхийлэв. 2023 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон иргэдийн дундаж тэтгэвэр 976,894 төгрөг буюу улсын дунджаас 12.9 хувиар өндөр байгаа нь тэтгэврийн хэмжээг жил бүр итгэлцүүрээр нэмэгдүүлэхгүй байгаагийн илрэл юм.

Тэтгэврийн хэмжээг инфляцын түвшин, амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтмол шинэчилж, ахмад настнуудын орлогын тогтвортой байдлыг хангахын тулд даатгуулагчдын мэдээллийг нэгдсэн санд бүрэн оруулж, цахим системийг ашиглах явдал чухал юм. Өнөөдөр Монгол Улсад өндөр насны тэтгэвэр авч байгаа 369,301 иргэний мэдээлэл НДЕГ-ын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа нь цахим хөгжлийг дэмжиж буй улсын хувьд хангалтгүй үзүүлэлт юм.

Тэтгэвэр тогтоох аргачлалыг оновчлох: “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуулийн 7 дугаар зүйлд өндөр насны тэтгэврийн хэмжээг цалинд үндэслэсэн ба нэрийн дансны арга гэсэн хоёр төрлийн арга ашиглана гэж заасан. Цалинд үндэслэсэн аргаар өндөр насны бүрэн тэтгэвэр болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн сарын хэмжээг тооцоход ашиглагдах аргачлалыг энэхүү судалгаанд жишээ болгон авч үзэв.

Бүрэн тэтгэврийн сарын хэмжээг дараах томьёо ашиглан тооцдог. Үүнд:

$$T_{ц6} = Ц * (45\% + (Ш_{241} + *0.125\%))$$

Энд:

- $T_{ц6}$ – цалинд үндэслэсэн аргаар тооцсон бүрэн тэтгэврийн сарын хэмжээ;
- $Ц$ – Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;
- $Ш_{241} +$ –241 ба түүнээс дээш шимтгэл төлсөн сарын тоо (Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, 2023).

Мөн хуулийн 20.1 дүгээр зүйлд *“Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилд шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 60-д хувааж бодно”* гэсэн байна. Энэхүү заалтаас харвал өнгөрсөн цагт шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 60 сард хуваан тооцох нь өндөр насны тэтгэврийг алдаатай тооцох талтай юм. Учир нь энэхүү аргачлалд шимтгэл төлөх үеийн мөнгөний өнөөгийн болон ирээдүйн үнэ цэнийг харгалзан үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нэрлэсэн цалингийн дүнгээр биш инфляцын нөлөөг харгалзсан байдлаар бодит цалингийн дундаж хэмжээг тооцож, үүнд үндэслэн тэтгэврийн хэмжээг тогтоох нь зүйтэй.

Мөн “20 жилийн доторх дараалсан 5 жилд шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэр”-ээс тооцохоор заасан нь хувь хүнийг санхүүгийн боломжтой үедээ харьцангуй богино хугацаанд, нийгмийн даатгалын шимтгэлийг өндөр дүнгээр нэмж төлөх байдлаар тэтгэврийн хэмжээгээ өндөр тогтоолгох боломж олгож байгаа нь тэтгэврийн орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтооход дараах томъёог ашиглаж байна. Үүнд:

$$T_{\text{цх}} = Ц * 0.1875\% * Ш_{\text{сар}}$$

Энд:

- $T_{\text{цх}}$ – цалинд үндэслэсэн аргаар тооцсон хувь тэнцүүлэн тогтоох тэтгэврийн сарын хэмжээ;
- Ц – энэ хуулийн 20.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого;
- $Ш_{\text{сар}}$ – шимтгэл төлсөн сарын тоо.

Нийгмийн даатгалын шимтгэлийг 10–20 хүртэл жил төлсөн, 65 нас хүрсэн даатгуулагчид өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох эрх үүснэ. Үүнээс шимтгэл төлөх хугацааг урт хугацааны зөрүүтэй тогтоож өгсөн нь нэг талаасаа иргэдийн дунд цөөн жил шимтгэл төлөөд үлдсэн насандаа тогтмол орлоготой болох сөрөг сэтгэлгээг дэмжих, нөгөөтээгүүр, бага тэтгэврийн орлоготой ахмад настнуудыг бий болгох суурь шалтгаануудын нэг болж байгааг бодлогын түвшинд анхаарах шаардлагатай.

Тэгш, шударга байдлыг хангах: Бүтээмжийн шударга ёс буюу хийснийхээ хэрээр авах зарчим, ижил хөдөлмөрт ижил хөлс олгох шаардлагатай холбоотой. Иймд улсад ажилласан жил, нийгмийн даатгалын санд оруулсан хувь нэмрээс хамааран өндөр насны тэтгэврийн хэмжээ шударга тогтоогдох учиртай. Гэвч өндөр насны тэтгэврийг энгийн нөхцөлөөс гадна ажлын онцлог, нөхцөлөөс хамааран 14 ялгаатай төрлөөр тогтоож байгаа нь цаашид анхаарах асуудал юм.

Одоогийн бодлого хэт халамжилсан агуулгатай, олон хөнгөлөлт, дэмжих нөхцөл оруулж ирсэн байдалтай. Тиймээс залуу насандаа улсад хувь нэмэр оруулсан ахмадуудад нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах боломжийг бүрдүүлж, бусад ахмадыг халамжийн тэтгэвэр авах байдлаар зохицуулах нь зөв.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Цэргийн алба хаагчдын тэтгэврийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуулиар бус, салбарын хүрээнд үйлчлэх хуулиар зохицуулж, тэтгэврийн хэмжээ салбараас хамааран 45–80 хүртэл хувиар ялгаатай тогтоогдож байна. Энэ ялгааг улс орны батлан хамгаалах, аюулгүй байдлыг хамгаалах үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг онцгой нөхцөл гэдэг утгаараа хүлээн зөвшөөрч болох ч энэ салбарт ажиллагчдыг гүйцэтгэж буй ажил, ажиллаж буй нөхцөлөөс нь хамааруулан тэтгэвэр тогтоох хувь хэмжээнд ялгамжтай хандаж, шатлалтай болгох нь шударга байдалд нийцнэ.

Тэтгэврийн хэмжээг тогтооход олон улсад өндөр насны хувийн даатгалын системд өргөнөөр ашиглагдаж буй аргачлалд “улсад төлсөн нийт шимтгэлийн хувь хэмжээ ба түүнийг хуримтлал хэлбэрээр өсгөх боломжит дүнгийн нийлбэр”-ийг харгалзан тооцох нь өндөр насны тэтгэврийн хэмжээг бодитоор тооцох, тэгш бус байдлыг арилгахад ихээхэн ач холбогдолтой юм.

Ахмадуудын хийж бүтээсэн, улсад оруулсан хувь нэмэр, төлсөн шимтгэлээс хамааран тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх нь зөв. Одоогийн тогтолцоо бол бага шимтгэл төлсөн ч зарим тохиолдолд өндөр шимтгэл төлсөн хүнтэй адил хэмжээний тэтгэвэр авах нөхцөл анзаарагддаг. Ялангуяа 2010 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн хувьд ижил төрлийн ажилд тэтгэвэр тогтоолгосон цаг хугацаанаас үл хамааран тэнцүү хэмжээний тэтгэвэр гэдэг нөхцөл алдагдаж байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Шилжилтийн үед өөрөөс үл хамаарах шалтгаанаар ажил эрхлээгүй улмаар тэтгэврийн даатгалын шимтгэл төлөөгүй иргэдийг нөхөн даатгалд хамруулах зорилгоор 2012 онд “Ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийг гаргаж, уг хуулийн үр нөлөөг нийт 607,781 иргэн хүртсэн байна (НДЕГ, 2017).

Нөхөн даатгалын хууль гарснаар улсад нэг ч төгрөгийн шимтгэл төлөөгүй хүн бүхэл бүтэн 11 жилийн хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлд ердөө 78,120 мянган төгрөг төлөөд сар бүр 570 мянган төгрөгийн хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Шимтгэл нөхөн төлөлтийн үр шимийг олон хүн хүртсэн ч үр дагавар нь бусадтай харьцуулахад маш бага мөнгө төлөөд тэтгэвэр авах эрхтэй болсноор олон жил хөдөлмөр эрхэлсэн хүмүүстэй харьцуулахад шударга бус байдлыг бий болгож, бүтээмжийн шударга ёсны зарчим алдагдсан байна. Түүнчлэн даатгал нь агуулгын хувьд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэдэг тул улс орнуудын даатгалын бодлого, зарчимд нөхөн даатгуулах тухай ойлголт байдаггүйг харгалзан үзэх нь тэгш, шударга байдлыг хангах, цаашлаад сангийн тогтвортой байдлыг хангахад чухал болно.

Мөн “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”-ийг нэг жилийн хугацаатай хэрэгжүүлж, 1995–2019 оны хугацаанд тасарсан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувиар тооцон нэг удаа нөхөн төлөх боломжийг малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд олгожээ.

Малчны нөхөн даатгал үндэслэл, тооцоо муутай шийдвэр гарсан. Зарим малчин нэг үхрээ зарж, нөхөн даатгалд хамрагдаад, сар бүр 600–700 мянган төгрөгийн тэтгэвэр авч байна. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ буюу 689 мянган төгрөгөөр тэтгэвэр тогтоолгох гэж 20-оос дээш жил ажиллаж байгаатай харьцуулахад шүүмжлэхээс өөр аргагүй зохицуулалт

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Тэтгэвэр, нийгмийн даатгалын талаарх иргэдийн ойлголтыг сайжруулах: Нийгмийн даатгал нь тухайн хүний амьдралд тохиолдож болох эрсдэлээс хамгаалах үүрэгтэй тул татвараас зарчмын хувьд эрс ялгаатай. Өндөр насны тэтгэвэр нь ажил хөдөлмөр эрхлэх боломж, чадавх буурах эрсдэл тохиолдоход амьжиргааны хэвийн түвшинг хангах арга

хэрэгсэл болдог. Гэвч иргэдийн хувьд нийгмийн даатгалын агуулга, ач холбогдлын талаар ойлголт багатай тул цалинтай хөдөлмөр эрхэлдэг хэдий ч албан журмаар даатгуулахгүй байх, бага дүнгээр шимтгэл төлөх, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд сайн дурын даатгалд хамрагдахгүй байх хандлага түгээмэл байна.

Төрд ажиллаж байгаа иргэдийн хувьд нийгмийн даатгалын шимтгэлийг шударгаар төлдөг. Хувийн хэвшилд хамрагдагчдын дийлэнх нь албан журмын даатгалд хамрагддаггүй, хамрагдсан ч үндсэн цалинг бага дүнгээр бичилт хийлгэж, шимтгэл төлдөг. Энэ нь ирээдүйд авах тэтгэврийн хэмжээнд сөргөөр нөлөөлж байгаа төдийлөн ойлгодоггүй.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Өндөр насны тэтгэвэртэй холбоотой бүрэн тэтгэвэр, хувь тэнцүүлсэн тэтгэвэр, нэрийн дансны арга, албан журмын даатгал, сайн дурын даатгал, цалин хөлстэй адилтгах орлого, мөнгөжүүлсэн орлого зэрэг жирийн иргэн бүр шууд ойлгон хүлээж авах, хувийн тооцоолол хийхэд ашиглахад хүндрэлтэй ойлголтууд олон байдаг. Иргэд өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос өмнө буюу хөдөлмөр эрхлэх хугацаандаа эдгээр нэр томъёоны утга, агуулгыг сайтар ойлгосноор өөрт тохирсон өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх арга хэлбэрийг сонгоход дэмжлэг болохын зэрэгцээ шимтгэл төлөлтөд хандах хандлагад эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Тэтгэвэртэй холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн уялдаа, зохицуулалтыг сайжруулах: Монгол Улсад өндөр насны тэтгэврийг тогтоох, олгохтой холбогдсон харилцааг “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай”, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Ахмад настны тухай”, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай”, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” зэрэг 20 гаруй хуулиар зохицуулж байна. Ийнхүү тухайлсан асуудлыг олон хуулиар зохицуулж байгаа нь даатгуулагчдад өндөр насны тэтгэвэр тогтоолгох, авахтай холбогдох харилцаанд орох, нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг ойлгомжтой, тодорхой болгоход бэрхшээлтэй нөхцөл байдал үүсэж байна. Тухайлбал, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуулийн 8.1-д “НД_{сз} нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27.8-д заасны дагуу тооцсон нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэр дүнг хэлнэ” гэж заасан. Гэвч “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн нэр томъёоны тодорхойлолтод нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл гэж юу болохыг тусгаагүй байгаа нь даатгуулагчдад төөрөгдөл үүсгэж байна.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд **“5.1.3.төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-оос доошгүй жил төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй”** олон хүүхэдтэй гэсэн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ. Харин “Нийгмийн халамжийн тухай” хуульд нийцүүлэн гаргасан “Эхийн алдар одон олгох журам”-д **“дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь 1 нас хүрсэн”** гэснээс хууль хоорондын зөрчил харагдаж байна.

Манай аймагт цэцэрлэгийн багшаар ажиллаж байсан алдарт эхийн одонтой эмэгтэй олон хүүхэдтэй нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгох хүсэлт гаргасан. Гэвч хүүхэд нь 1.5 насандаа эндсэнээс хамаараад хүүхдийн тооноос хамааран эрт тэтгэвэрт гарах нөхцөлийг хангахгүй кейс гарч, гомдол саналаа тавьж байсан. Хуулиудад олон хүүхэд гэдгийг ялгаатай тогтоох нь эрх зүйн талаас зөрчил юм.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл

Эндээс өндөр насны тэтгэвэр тогтоолгох, авахтай холбогдох зохицуулалтад ашиглагдаж буй эрх зүйн баримт бичгийг нэгтгэн цогц болгох замаар иргэдэд хэрэглэхэд хялбар, ойлгомжтой, хэрэглэгчдэд ээлтэй болгох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

5.1. Дүгнэлт

Шинэ өрхийн эдийн засгийн онолд суурилан өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг хүн ам зүй болон бодлого, эрх зүйн хүчин зүйлтэй уялдуулан судалж, дараах дүгнэлтийг хийж байна.

Монгол Улсад өндөр насны тэтгэврийг тогтоох, олгохтой холбогдсон харилцааг “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай”, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” зэрэг 20 гаруй хуулиар зохицуулж байна. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуульд өндөр насны тэтгэвэр тогтоох нөхцөл, тэтгэвэр тооцох аргачлал зэрэг суурь шинжтэй зохицуулалтыг тусгасан.

Монгол Улсын нийгмийн даатгалын нэгдсэн санд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 369,301 өндөр насны тэтгэвэр авагч бүртгэгдсэний 90.9 хувь нь бүрэн, 9.1 хувь нь хувь тэнцүүлсэн төрлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байна. Үүнээс үзвэл, 10 тэтгэвэр авагч тутмын 9 нь өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах насанд хүрсэн бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг 241 сараас дээш хугацаанд төлж бүрэн тэтгэвэр авч байгаа, үлдсэн нэг нь нийгмийн даатгалын шимтгэлийг 10–20 жил төлж, хувь тэнцүүлсэн байдлаар тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчид байна.

Өндөр насны тэтгэвэр авагчдын 67.3 хувь нь эмэгтэй, 32.7 хувь нь эрэгтэй даатгуулагчид эзэлж байгаа нь нэг талаас хэвийн нөхцөлөөр эмэгтэйчүүд 5 жилийн өмнө өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаатай холбоотой. Нөгөө талаас, Монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалт зөрүүтэй байгаагийн илрэл юм.

Ахмад настнууд сард дунджаар 865,123 төгрөгийн тэтгэвэр авч байгаа бөгөөд ийнхүү тэтгэврийн дундаж хэмжээ бага байгаа нь бүрэн тэтгэвэр авч буй 10 даатгуулагч тутмын 5 нь (54.8 хувь), хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч буй 10 даатгуулагч тутмын 9 нь (92.0 хувь) тус тус тухайн тэтгэврийн төрлийн доод хэмжээгээр тэтгэвэр тогтоолгосонтой холбоотой юм. Түүнчлэн тэтгэврийн хэмжээ нь тэтгэврийн төрөл, тэтгэвэр тогтоолгосон он, нөхцөл, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа, нас, хүйс зэргээс хамааран харилцан адилгүй байна. Тухайлбал, 2023 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд дундаж тэтгэврийн хэмжээ 850 орчим мянган төгрөг байгаа бол 2023

оноос хойш тэтгэвэр тогтоолгосон иргэдийн дундаж тэтгэврийн хэмжээ 120 орчим мянган төгрөгөөр илүү байв.

Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлж байгаа нөлөөг орлого талаас нь авч үзвэл, санал асуулгын судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж орлогын 47.2 хувийг өндөр насны тэтгэвэр бүрдүүлж байна. Энэ нь өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэвэр орлогын чухал нөлөөтэй эх үүсвэр болохыг илэрхийлнэ. Өрхийн орлогод өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөнд байршлаас хамааран ялгаатай нөхцөл байдал ажиглагдсан бөгөөд нийслэлийн өрхүүдтэй харьцуулахад аймаг, сумын төвийн өрхүүдийн орлогод эзлэх хэмжээ өндөр буюу талаас дээш хувийг өндөр насны тэтгэвэр эзэлж байна. Үүнийг орон нутагт ажлын байр хомс, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байгаатай холбон тайлбарлаж болно.

Судалгаанд хамрагдсан 3 өрх тутмын 1 нь хуримтлалтай хэдий ч хуримтлалын дундаж хэмжээ 414.5 мянган төгрөг байгаа нь ахмад настантай өрхүүдийн хувьд эрүүл мэндийн болон бусад гэнэтийн шинжтэй санхүүгийн эрсдэлийг даван туулах, амьжиргааны тогтвортой байдлыг хангах чадвар сул байгааг илэрхийлнэ. Өрхийн нийт орлогын хэмжээ бага, бараа, үйлчилгээний үнэ өндөр тул хуримтлуулсан орлогоо нэмэгдүүлэхээсээ илүүтэй эргэн зарцуулах хандлага түгээмэл байгаа нь иргэдтэй хийсэн ярилцлагаас харагдлаа. Хуримтлал үүсгэх боломж нь байршлаас хамааралтай эсэхийг тодруулахад Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан өрхүүдийн $\frac{3}{4}$ -аас илүү (77.5 хувь) нь хуримтлалгүй байхад аймаг, сумын төвийн өрхүүдийн хувьд 45.0–48.3 хувь нь хуримтлалгүй гэсэн дүн гарчээ.

Тэтгэврийн орлого нь өрхийн бусад орлоготой харьцуулахад найдвартай, тогтмол орлогын төрөлд багтдаг утгаараа банк, банк бус байгууллагад барьцаалан зээл авах эх үүсвэр болдог. Ахмад настнуудын 76.3 хувь нь сүүлийн 3 жилийн хугацаанд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан бөгөөд үүнийг эрүүл мэнд, орон сууц худалдан авах/ засварлах, цагаан сар зэрэгт дутагдсан орлогыг нөхөх эх үүсвэр болгон ашигласан байна. Эдгээр ахмадуудын 73.8 хувь нь өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлийг үр дүнтэй зарцуулж, өрхийн эдийн засагт хувь нэмэр оруулсан гэж дүгнэж байна. Тэтгэврийн зээл нь авахад хялбар, шаардлагатай үед санхүүгийн томоохон эх үүсвэр болдог талаасаа эерэг хэдий ч эргэн төлөгдөх нөхцөл бүхий үүрэг хариуцлага гэж үзвэл тухайн зээлийн эргэн төлөлт хийгдэж дуустал ахмад настнуудын хувийн хэрэглээгээ танах нөхцөл үүсдэг болохыг ахмад настнууд дурдаж байв.

Өрхийн зардлын тухайд, өндөр насны тэтгэврийн орлогынхоо 67.1 хувийг өрхийн нийтийн, 20.8 хувийг өөрийн хувийн хэрэгцээнд, үлдсэн

хувийг аль алинд нь зарцуулдаг гэж хариулсан байна. Энэ нь өрхийн нийтийн хэрэглээний зардлыг хангахад өндөр насны тэтгэвэр нь ихээхэн хувь нэмэр оруулж байгаагийн илрэл юм. Хүйсээр харьцуулан үзэхэд, өндөр насны тэтгэврээс өрхийн нийтийн хэрэгцээнд зарцуулах байдалд төдийлөн ялгаагүй буюу 65.1–71.8 хувь байгаа нь өндөр настнууд хүйсээс үл хамааран өрхийн эдийн засагт оролцдог болохыг илэрхийлнэ.

Өндөр насны тэтгэврээс зөвхөн хувийн зардалд зарцуулж буй иргэдийн хувьд тэтгэврийнхээ 29.3 хувийг хүнс, нэмэлт бүтээгдэхүүнд, 20.6 хувийг хувцас, хэрэглэлд, 18.7 хувийг эрүүл мэндийн зардалд голлон зарцуулж байна. Харин 3.4 хувь буюу ердөө 30 гаруй мянган төгрөгийг амралт, чөлөөт цагт зориулан зарцуулж байгаа нь ахмад настнууд тэтгэврээ суурь хэрэгцээндээ зарцуулж байгааг харуулж байна. Тэтгэвэр авагчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд, найз нөхөдтэйгөө уулзах зэргээр нийгмийн харилцаанд орохдоо байнга хамгийн бага зардал гаргахыг хичээж, хэмнэдэг, тэтгэврийн хэдэн төгрөгөө өөрөөсөө ч 'харамлах' нөхцөл үүсдэг ажээ.

Гэсэн хэдий ч ахмад настнуудын 62.5 хувь нь тэтгэврээсээ хүүхдүүд, ач зээ, хамаатан садандаа боломжийнхоо хэрээр дэмжлэг үзүүлдэг бөгөөд тэдний хувьд хүүхдүүд (53.3 хувь) болон ач зээдээ (43.3 хувь) туслах хандлага хамгийн өндөр байна. Давтамжийн хувьд сар тутам гэсэн хариулт жин дарж байгаа нь ахмад настнууд өндөр насны тэтгэврээр өрхийн хэрэгцээг хангахад оролцоод зогсохгүй үр хүүхэддээ ч тусалж дэмжих байдал нийтлэг байгааг илэрхийлнэ. Сумын төвд амьдарч буй ахмад настнуудын 76.7 хувь нь тэтгэврээсээ бусдад дэмжлэг үзүүлдэг гэсэн нь аймгийн төвөөс 11.7, нийслэлээс 22.5 пунктээр тус тус өндөр дүнтэй байгаа нь сумын төвд хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур, тэтгэврийн орлогоос үр хүүхэддээ зарцуулах хандлага түгээмэл, улмаар өрхийн эдийн засаг нь тэтгэврийн орлогод илүү түшиглэж байгааг харуулж байна.

Ахмад настнууд өндөр насны тэтгэврийг тогтмол орлого, өрхийн санхүүгийн болон амьжиргааны эх үүсвэр, зээл авах баталгаа, төрийн хишиг гэж үзэж, 'амны билгээс ашдын билэг' гэсэн утгаар үнэлж байгаа хэдий ч бодит байдал дээр өндөр насны тэтгэвэр амьжиргаанд хүрэлцдэггүй гэсэн хариулт давамгайлж байна. Тодруулбал, өндөр насны тэтгэвэр нь тухайн ахмад настны хувийн хэрэгцээнд хүрэлцээтэй эсэх асуултад 5 хүн тутмын 3 нь хүрэлцдэг, 2 нь хүрэлцдэггүй гэсэн хариулт өгчээ. Өндөр насны тэтгэвэр хувийн хэрэгцээнд хангалттай хүрэлцдэг гэсэн хариултыг нийслэлээс судалгаанд хамрагдагчдын 14.2 хувь нь өгсөн ба аймаг, сумын төвийн иргэдийн хувьд энэ хариултын хувь 2–3 дахин өндөр байгаа нь нийслэлд бараа, үйлчилгээний нэр төрөл олон, амьжиргааны өртөг өндөр зэрэг хүчин зүйлээс хамааралтай юм. Судалгаанд хамрагдсан ахмад настнуудын 8.3

хувь нь өндөр насны тэтгэвэр өрхийн амьжиргаанд нөлөөгүй гэснээс 12 өрх тутмын нэг нь тэтгэврийн бус орлогыг амьжиргааны гол эх үүсвэр болгон ашигладаг болох нь харагдаж байна.

Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөөг нас, хүйс, байршил, ам бүлийн тоо, хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоо зэрэг хүн ам зүйн хүчин зүйлээр харьцуулан авч үзвэл, нас, хүйсээс хамаарсан ялгаа харьцангуй бага байна. Харин байршил, ам бүлийн тоо, хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоо гэсэн хүн ам зүйн хүчин зүйл нь нийгэм, эдийн засгийн ялгаатай нөхцөл байдлыг бий болгож, улмаар өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх үр нөлөө харилцан адилгүй байхад томоохон нөлөө үзүүлж байна.

Дээрх бүгдээс дүгнэвэл, өндөр насны тэтгэвэр нь ахмад настан төдийгүй өрхийн бүхий л гишүүдийн нийгмийн хамгааллын үүргийг гүйцэтгэж байна. Үүнийг шинэ өрхийн эдийн засгийн онолын хүрээнд авч үзвэл, өндөр насны тэтгэвэр нь тухайн өрхийн орлогын эх хэмжээ, үүсвэрийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ахмад настны хувийн болон нийтийн зардлын аль алинд зарцуулагдаж байна. Түүнчлэн өндөр насны тэтгэврийн орлого нь үр хүүхэд, ач зээдээ дэмжлэг үзүүлэх боломжийг олгож байгаа нь тухайн өндөр настны сэтгэл зүйн хувьд эерэг байдлыг бий болгож байна. Манай улсын хувьд тэтгэврийн хэмжээ мөнгөн дүнгээр тооцвол бага, худалдан авах чадвар хангалтгүй, амьжиргаанд төдийлөн хүрэлцээтэй бус байгаа хэдий ч ахмад настантай өрхийн эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж байна.

Таамаглал батлагдсан эсэх: Судалгаанд дараах таамаглал дэвшүүлсэн бөгөөд тоон болон чанарын шинжилгээний үр дүнгээр эдгээр таамаглал батлагдсан гэж дүгнэж байна.

“Таамаглал 1. Өндөр насны тэтгэвэр нь өрхийн орлого, эх үүсвэр, хуримтлалд эерэг нөлөө үзүүлж байна”. Өндөр насны тэтгэвэр нь өрхийн орлогын дунджаар 47.2 хувийг бүрдүүлэхийн зэрэгцээ орлого дутагдсан үед зээлийн эх үүсвэр болон ашиглагдах, үр хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэрэгсэл болох гэх мэт эерэг нөлөөг үзүүлж байна. Ялангуяа сумын төвийн, ам бүлийн тоо болон хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоо цөөн, орлого багатай өрхүүд гол төлөв өндөр насны тэтгэврийг орлогын үндсэн эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Таамаглал 2. Өндөр насны тэтгэвэр нь тухайн ахмад настны хувийн хэрэгцээнд хүрэлцэхгүй байна”. Ахмад настнуудын 27.1 хувь нь өндөр насны тэтгэврээрээ хувийн хэрэгцээгээ хангах боломжтой байдаг бол 42.9 хувь нь хувийн хэрэгцээгээ хангахад хүрэлцдэггүй гэж үзэж байна. Энэ нь өрхийн орлогын хэмжээ харьцангуй бага тул өндөр насны тэтгэврээс өрхийн нийтийн зардалд зарцуулах байдал өндөр байгаатай холбоотой.

“Таамаглал 3. Улаанбаатар хотын өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөө бага байна”. Судалгаанаас харахад, өндөр насны тэтгэвэр нь ахмад настнуудын 41.3 хувийнх нь амьжиргаанд голлох нөлөөтэй гэж үзэж болохоор байна. Гэвч Улаанбаатар хотын хувьд өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэвэр голлох нөлөө үзүүлдэг байдал нь бага буюу 24.3 хувь байгаа нь аймаг болон сумын төвөөс 18.2–32.4 пунктээр доогуур үзүүлэлт юм.

5.2. Санал

Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг дээшлүүлэх чиглэлээр судалгаанд суурилан дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Тэтгэврийн хэмжээг жил бүр итгэлцүүрээр нэмэгдүүлэх;
- Тэтгэвэр тогтоох аргачлалыг оновчлох;
- Тэгш, шударга байдлыг хангах;
- Нийгмийн даатгалын талаарх иргэдийн ойлголтыг сайжруулах;
- Тэтгэвэрт холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн уялдаа, зохицуулалтыг сайжруулах зэрэг болно.

Тэтгэврийн хэмжээг жил бүр итгэлцүүрээр нэмэгдүүлэх: Манай улсын хувьд өндөр насны тэтгэврийг цалин, түүнтэй адилтгах орлогын 45 хувиар тогтоож, 241 сараас илүү нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар нэмэгдүүлэн олгохоор зохицуулсан. Гэвч 2025 оны эхний хагас жилийн байдлаар дундаж тэтгэврийн хэмжээ дундаж цалингийн 33 хувийг эзэлж байгаа нь тэтгэврийн хэмжээг жил бүр итгэлцүүрээр нэмэгдүүлэхгүй байгаагийн бодит илрэл юм. Иймд ОУХБ-ын зөвлөмжийн дагуу ахмад настнуудын нийгмийн баталгааг хангахын тулд өндөр насны тэтгэврийг жил бүр итгэлцүүрээр нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх шаардлагатай байна.

Тэтгэвэр тогтоох аргачлалыг оновчлох: “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль”-ийн дагуу өндөр насны тэтгэврийг цалинд суурилсан болон нэрийн дансны аргаар тооцож байна. Гэвч эдгээр аргачлалаар тэтгэврийн хэмжээг тооцохдоо шимтгэл төлсөн хугацаан дахь мөнгөний үнэ цэнийг инфляцтай уялдуулан тооцохгүй нөхцөл байдал байгаа тул аргачлалд харгалзах нь зүйтэй.

Тэгш, шударга байдлыг хангах: Тэтгэвэр тогтоох аргачлалтай холбоотойгоор адил ажил эрхэлж байсан иргэдийн хувьд сүүлд тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр өндөр тогтох эрсдэлийг хааж, “адил хөдөлмөрт адил шан харамж” гэсэн ОУХБ-ын зарчмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болно. Түүнчлэн ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг тухай бүр төлүүлэх оновчтой механизм байхгүйгээс нөхөн төлж, зарим бүлэгт давуу байдал бий болгож байгааг анхаарах ч, тэтгэвэр тогтоож буй хөнгөлөлт, нөхцөлүүдийг нарийвчлан судалж, тодорхойлох шаардлагатай.

Нийгмийн даатгалын талаарх иргэдийн ойлголтыг сайжруулах: Иргэдийн хувьд тэтгэврийн даатгалд хамрагдсанаар ирээдүйд ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон хугацаандаа сар бүр өндөр насны тэтгэвэр авч, амьжиргааны баталгааг хангах боломж бүрддэг гэдгийг төдийлөн ойлгодоггүй, улмаар нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх, бага дүнгээр төлөх хандлагатай байдаг нь бага тэтгэвэр тогтоход нөлөөлж байна. Иймд нийгмийн даатгалын шимтгэлийн агуулга, ач холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх хэрэгтэй юм.

Тэтгэвэрт холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн уялдаа, зохицуулалтыг сайжруулах: Өндөр насны тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг 20 гаруй хуулиар зохицуулж байгаа нь нэг талаас, хуулийг хэрэглэхэд төвөгтэй нөхцөл байдал үүсэх, нөгөө талаас, даатгуулагч, тэтгэвэр авагчдад төөрөгдөл, ойлгомжгүй нөхцөл байдал бий болж, эрх ашиг нь хохирох асуудал гарч байна. Иймд өндөр насны тэтгэвэртэй холбоотой эрх зүйн баримт бичгийг нэгтгэн цогц болгох, бусад хуультай уялдаа, нийцлийг хангах шаардлагатай байна.

5.3. Судалгааны хязгаарлалт

1. Судалгааны үзэл баримтлалын үндэс болох шинэ өрхийн эдийн засгийн онолын дагуу өрхийн эдийн засаг гэдэг ойлголтод орлого, зардлыг багтаасан нь агуулгын талаас хязгаарлалт болно.
2. Цаг хугацаа, төсөв санхүү, хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаас хамааран судалгаанд 2 дүүрэг, 2 аймгаас тус бүр 2 сумыг хамруулсан нь [орон зайн хувьд] хязгаарлалт болж байна.
3. Нийгмийн даатгалын нэгдсэн санд бүртгэлтэй 369,301 өндөр насны тэтгэвэр авагчийн нас, хүйс, авч буй тэтгэврийн хэмжээ, төрөл, тэтгэвэр тогтоолгосон он, нөхцөл зэрэг мэдээлэлд суурилан холбогдох шинжилгээ, тооцооллыг хийсэн хангалттай өндөр дүн боловч нэлэнхүй байдлаар оруулаагүй тул [хамрах хүрээний хязгаарлалт] болно.

Монгол хэл дээрх эх сурвалж:

- Александр Петринг. (2009). *Нийгмийн баримжаат төр ба нийгмийн ардчилал. Нийгмийн ардчиллын сурах бичиг 3-р дэвтэр*. Улаанбаатар.
- Д.Алтанцэцэг. (2021). *Өрхийн орлого, хэрэглээ ба хуримтлалын хамаарал: Монголын жишээн дээрх эмпирик судалгаа*. Монголын эдийн засгийн судалгааны төв.
- С.Ариунаа. (2019). *Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагчдын талаарх судалгаа*. Улаанбаатар.
- Геронтологийн төв. (2009). *Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн байдлын судалгаа*. Улаанбаатар.
- Ц.Давхарбаяр, Г.Жаргал. (2010). *Нийгмийн хамгааллын эрх зүй*. Улаанбаатар.
- Ч.Дагвадорж. (2004). *Нийгмийн хамгаалал: Онол, арга зүй, туршлага, харьцуулалт*. Улаанбаатар.
- Ц.Дашдондог. (2017). *Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцооны өнөөгийн байдал, хэтийн төлөв*. Улаанбаатар.
- С.Дамба-Д. *Монгол өрхийн санхүүгийн байдал ба хуримтлалын загвар*. Монголын эдийн засгийн судалгааны төв.
- Т.Майер. (1999). *Социал демократ үзэл санаа ба нийгмийн ардчилал*. Улаанбаатар.
- Л.Мөнхзул. (2014). Тэтгэврийн даатгалын өнөөгийн байдал, шинэчлэлийн зорилтууд. *Азийн улс орнуудын нийгмийн хамгааллын бодлого ба хөгжил форум*. Улаанбаатар.
- Л.Мөнхзул, Б.Батжаргал ба бусад. (2017). *Нийгмийн хамгааллын нэр томъёоны Монгол-Англи тайлбар толь*. ХНХЯ.
- Монгол банкны Мөнгөний бодлогын хороо. (2025 оны 3 дугаар сарын 6). *Бодлогын хүүг нэмэгдүүлэх, хэрэглээний болон тэтгэврийн зээлийн зохицуулалтад өөрчлөлт оруулах тухай*. Улаанбаатар.
- МУ-ын Засгийн газар. (2015). *Нийгмийн хамгааллын үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Монгол Улсын нийгмийн хамгааллын Суурь түвшний тодорхойлолт, зардал*. Улаанбаатар: НҮБХАС.
- Б.Нарантулга. (2016). *Монгол Улсын нийгмийн хамгааллын бодлогын өнөөгийн байдал. Төрийн захиргаа сэтгүүл. Дугаар 3 (41)*. Улаанбаатар.

- НДЕГ. (2024). *Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн эмхэтгэл*. Улаанбаатар
- НДЕГ. (2000–2010). *Монгол Улсын нийгмийн даатгалын системийн тухай судалгаа* Улаанбаатар.
- НДЕГ. (2010–2015). *Монголын нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн асуудал*. Улаанбаатар.
- НДЕГ. (2014–2015). *Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдал*. Улаанбаатар.
- НДЕГ. (2015–2020). *Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмж*, Улаанбаатар.
- НДЕГ. (2017). *Нийгмийн даатгалын статистикийн эмхэтгэл*. Улаанбаатар.
- НДЕГ. (2020). *Монгол дахь нийгмийн даатгалын сангийн санхүүжилт ба түүний эрсдэл*. Улаанбаатар.
- НДЕГ. (2020). *Монголын нийгмийн даатгалын реформ ба хүн амын амьдралын чанар* . Улаанбаатар.
- НДЕГ. (2020–2023). *Нийгмийн даатгалын цахим шилжилт: системийн шинэчлэл*. Улаанбаатар.
- НДЕГ. (2024 оны 4 дүгээр сар). *Нийгмийн даатгалын сарын мэдээний тойм*. Улаанбаатар.
- Нийгмийн даатгалын ерөнхий газар, Олон улсын хөдөлмөрийн байгууллага. (2021). *Нийгмийн даатгал гарын авлага*. Улаанбаатар.
- ОУ-ын хөдөлмөрийн байгууллага.(2023). *Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд хийсэн дүн шинжилгээ: Нийгмийн хамгааллын хөтөлбөрт суурилсан хандлагад шилжих нь* . Улаанбаатар.
- ОУ-ын хөдөлмөрийн байгууллага.(2016). *Ахмад настны нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэл болон малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан тэтгэврийн шинэ хөтөлбөрийн санхүүгийн үнэлгээ*. Улаанбаатар.
- ОУХБ. (2016). *Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмж*. Улаанбаатар.
- Р.Ньюперт. (2012). *Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого дахь хүн ам зүйн өөрчлөлтийн нөлөөлөл*. Улаанбаатар.
- С.Эрдэнэ. (2013). *Нийгмийн даатгалын тогтолцоо: Шинэчлэл, чиг хандлага, Доктор (PhD)-ын зэрэг горилсон бүтээл*. Улаанбаатар: Удирдлагын академи.
- Н.Смелзер. (2017). *Социологи* .ШУА-ийн Философийн хүрээлэн.

- Г.Түмэннаст (2017). *Нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоонд хийсэн социологийн шинжилгээ*. МУИС.
- Г.Түмэннаст. (2009). *Нийгмийн ажлын түүх: Жам ёсны тусламжаас нийгмийн хамгаалалт ертөнц өөд (үзэл санаа ба туршлага)*. Улаанбаатар.
- Удирдлагын академи . (2019). *Өндөр насны тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал. Судалгааны тайлан 014*. Улаанбаатар.
- Үндэсний аудитын газар. (2024). *Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө аудитын тайлан*. Улаанбаатар.
- ҮСХ. (2015). *Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого: Үндсэн үр дүн*. Улаанбаатар.
- ҮСХ. (2018). *Ахмад настнуудын эдийн засаг, нийгмийн байдал судалгааны тайлан*. Улаанбаатар.
- ҮСХ. (2023). *Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа*. Улаанбаатар.
- Б.Үүрцайх. (2018). *Нийгмийн даатгалын тогтолцоо: асуудал-туршлага-шинэчлэл*. Улаанбаатар.
- ХЭҮК. (2015). *Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал*. Улаанбаатар
- ХЭҮК. (2020). *Хүний эрх ба нийгмийн даатгалын тогтолцоо*. Улаанбаатар.
- ЭМНДЕГ. (2017). Retrieved from ndaatgal: www.ndaatgal.mn
- Л.Энх-Амгалан. (2015). Хийсвэр хуримтлалын систем, түүний эерэг, сөрөг тал өгүүлэл. *Төрийн захиргаа сэтгүүл. Дугаар 01 (30)*.

Англи хэл дээрх сурвалж:

- Bank, W. (2014). *The Role of Social Safety Nets in Poverty Reduction and Shared Prosperity*. Washington, DC.
- Beauvoir, S. d. (1972). *The Coming of Age*. New York: W.W. Norton & Company.
- Becker, G. S. (1992). The economic way of looking at life. *Nobel Lecture* (p. 46). University of Chicago.
- Becker., G. S. (1986). *An Economic Analysis of the family*. Aigus press Ltd.
- Benington, R. (1996). *The Economics of Social Security*. Macmillan.
- Commission, E. (2020, February 07). *Gender pension gap in the EU: 30% less for women*. Retrieved from <https://ec.europa.eu/>: <https://ec.europa.eu/eurostat/web/products-eurostat-news/-/DDN-20200207-1>
- Durkheim, É. (1893). *The Division of Labor in Society*.

- Durkheim, É. (1997). *The Division of Labor in Society*. New York: Free press.
- Elliott Fan. (2010). Who Benefits from Public Old Age Pensions? Evidence from a Targeted Program . *Economic Development and Cultural Change Volume 58*
- Esther Duflo. (2003). Grandmothers and Granddaughters: Old–Age Pensions and Intrahousehold Allocation in South Africa . *The World Bank Economic Review, 2003, Vol. 17, No. (1), 1–25 .*
- European Commission. (1997). *Ageing and Pension Reform*.
- Eurostat. (2023). *Income and living conditions of older persons in the EU*. European Commission.
- Gillion, C.; Bailey, C.; Latulippe, D. (eds). (2000). *Social security pensions: Development and reform*. International Labour Office.
- GIZ. (2016). *Planning policy impact assessment and choosing right methods: Manual for development practitioners .*
- Halpern, D. (2005). *Social Capital*.
- Help age International. (2021). *Global age watch index*.
- Higo, M., & Klassen, T. R. (2017). Reforming the retirement system in Japan and Korea: Toward a new model of aging work society. *Routledge*.
- Huoyun Zhu, Alan Walker. (2018, 6 13). Pensions and social inclusion in an ageing China. *Ageing & Society, 7*. Retrieved from <https://www.cambridge.org/core>.
- ILO . (1952). *Convention No. 102 concerning Minimum Standards of Social Security, Part V – Old–age benefit*.
- ILO. (2022). *World Social Protection Report 2022: Social protection at the crossroads – in pursuit of a better future*. International Labour Organization.
- ILO. (2024, 9 20). Title <https://www.ilo.org/>. Retrieved from <https://www.ilo.org/publications/flagship-reports/world-social-protection-report-2024-26-universal-social-protection-climate>
- IMF. (2015). *The Impact of Social Insurance on Poverty and Employment*. Washington D.C.
- Ironmonger.D. (2001). Household Production. *International Encyclopedia of the Social & Behavioral Sciences*.
- J.Heckman, R.Lalonde and J.Smith. (1999). *The economics and econometrics of active labor market programs*. Amsterdam.

- J.Weeks. (2002). *Population. An Introduction to Concepts and Issues*.
- James Anderson. (2000). *Public policy making*. Houghton Mifflin company.
- Jin Feng, Lixin He, Hiroshi Sato. (2011). Public pension and household saving: Evidence from urban China. *Journal of Comperative Economics*, 470–485.
- Kohler, G. (2014). *Rights-based developmental welfare states and the asian experience*. Asian Countries Forum: Ulaanbaatar.
- Kwadwo Adusei-Asante. (2016). *Measuring Policies with the Social Impact Assessment Framework: Opportunities and Challenges*. Retrieved from <https://conferences.iaia.org>.
- Linton, R. (1936). *The Study of Man: An Introduction*. New York.
- Marta Lachowska and Michał Myck. (2018). The Effect of Public Pension Wealth on Saving and Expenditure . *American Economic Journal: Economic Policy*, 10, (3) (August 2018), 284–308.
- Martin Browning, Pierre-Andre Chiappori. (2011). *Family Economics*.
- Marx, K. (1867). *Capital, Volume 1*.
- Maslow, A. (1987). *Motivation and Personality*. New York.
- Mattila-Wirolahti, P. (1999). *Economic theories of the household: A critical review*.
- Michael Moran, Martin Rein and Robert E.Goodin. (2006). *The Oxford handbook for public policy*. New York: Oxford university press.
- Modigliani, F. &. (1954). *Utility Analysis and the Consumption Function: An Interpretation of Cross-section Data*. In K. Kurihara. Post-Keynesian Economics.
- National Institute on National Security . (2010). *Why do pension matters*.
- North, D. C. (1990). *Institutions, Institutional Change, and Economic Performance*. Cambridge : Cambridge University Press.
- OECD. (2002). *Aging impacts on socio economic planning*.
- OECD. (2021). *Pensions at a Glance 2021: OECD and G20 Indicators*.
- OECD. (2023). *Pensions at a Glance 2023: OECD and G20 Indicators*. OECD Publishing.
- Orazio P. Attanasio, Susann Rohwedder. (December 2003). Pension Wealth and Household Saving: Evidence from Pension Reforms in the United Kingdom. *American Economic Review* vol. 93, no. 5, 1499–1521.

- Parsons, T. (1937). *The Structure Of Social Action*.
https://ia801002.us.archive.org/31/items/dli.ernet.4397/4397-The%20Structure%20of%20Social%20Action_text.pdf.
- Parsons, T. (1951). *The Social System*. New York: The Free Press.
- Paweł Merto, Jacek Michalak Katarzyna Andruszkiewicz. (2024). Model of Family and the Propensity to Build Sustainable Savings Attitudes in the Post-COVID World: A Case Study of Poland. *Sustainability*, 3.
- Peter Whiteford, Edward Whitehouse. (2006). Pension challenges and pension reforms in OECD countries. *Oxford Review of Economic Policy, Spring 2006*, 22, 1, 78–94 .
- Plato. (1992). *The Republic* . Hackett Publishing Company.
- Putnam, R. D. (2000). *Bowling Alone: The Collapse and Revival of American Community*. New York.
- Robert Holzman. Ian W. Mac Arthur. The World Bank. (2009). *Social protection, labor markets, pensions, soial assistance*.
- Rousseau, J.J. (1979). *Emile or On Education*.
- Save the Children. (2000). *The household economy approach: A resource manual for practitioners*.
- Scheme Wei Huang Chuanchuan Zhang. (2021). The Power of Social Pensions: Evidence from China’s New Rural Pension . *American Economic Journal: Applied Economics vol. 13, no. 2, April* .
- Sona Akter. (2018). How economy and business management affect by household behaviour and family economy. *International journal of Management applied science*, 4.
- Stephen Kidd and Anh Tran. (2025, January 10). *Social Pensions and their Contribution to Economic Growth*. Retrieved from Development pathways: <https://www.developmentpathways.co.uk/wp-content/uploads/2018/06/Social-pensions-and-their-contribution-to-economic-growth-1.pdf>
- United Nations . (1948). *Universal Declaration of Human Rights, Article 25*.
- Unnikrishnan, S. Imai. (2020). Does the old-age pension scheme improve household welfare? Evidence from India. *World Development Volume 134*.
- William G. Gale. (1998). The Effects of Pensions on Household Wealth: A Reevaluation of Theory and Evidence. *Journal of Political Economy* Vol. 106, .(4), 706–723.

- World Bank. (2008). *The World Bank pension conceptual framework (English). World Bank pension reform primer series*. Washington DC.
- World Bank. (1994). *Averting old age crisis: Policies to protect the old and promote growth* .
- www.pensionrights.org*. (2022). Retrieved from *www.pensionrights.org*: https://pensionrights.org/resource/income-from-pensions/?utm_source
- Yanjun Ren, Weigang Liu, Xuexi Huo, Thomas Glauben. (11 October, 2023). The impact of old-age pension on nutritional outcomes: Evidence from Kyrgyzstan.
- Yen-Pi Cheng, Kira S Birditt, Steven Zarit, Karen L Fingerman. (October 2013). Young Adults' Provision of Support to Middle-Aged Parents. *The Journals of Gerontology Series B Psychological Sciences and Social Sciences*.
- Qing Zhao, Zhen Li, Taichang Chen. (2025, January 16). The Impact of Public Pension on Household Consumption: Evidence from China's Survey Data. Retrieved from <https://doi.org/10.3390/su8090890>
- Zaidi, A., & Grech, A. G. (2021). Pension policy design and income inequality among older people. *Journal of Aging & Social Policy*.
- Chen Park. (2023). Rural pensions, intra-household bargaining, and elderly medical expenditure in the People's Republic China. *ADB Economic Working Paper Series*. 693.

Хавсралт 1. Санал асуулгын хуудас

ТЭТГЭВРИЙН НАСНЫ ИРГЭДЭЭС АВАХ АСУУЛГА

Энэхүү судалгаа нь өндөр насны тэтгэврийн өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөөг судлах зорилготой. Асуулгад асуултын өмнөх тоог дугуйлах болон шаардлагатай бол нөхөж бичих байдлаар хариулна. Таны өгсөн мэдээллийн нууцыг “Статистикийн тухай” болон “хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн дагуу чандлан хадгална.

Байршил:

1. Баянзүрх дүүрэг
2. Сүхбаатар дүүрэг
3. Хан-Уул дүүрэг
4. Сайншанд сум
5. Өргөн сум
6. Сүхбаатар сум
7. Мандал сум

Амьдарч буй сууцны төрөл:

1. Гэр
2. Орон сууц
3. Хашаа байшин
4. Тохилог байшин/Хаус
5. Нийтийн сууц
6. Сууцны бус
7. Бусад (бичих)

Нэг. Хариулагчийн мэдээлэл

1) Нас (бүтэн жилээр хариулах): _____

2) Хүйс:

1. Эрэгтэй
2. Эмэгтэй

3) Таны боловсролын түвшин:

1. Бага
2. Дунд
3. Тусгай мэргэжлийн
4. Дээд
5. Боловсролгүй

4) Тэтгэвэрт гарсан он: _____

5) Тэтгэвэрт гарах үеийн албан тушаал:

1. Хувийн хэвшлийн ажилтан
2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч
3. Төрийн үйлчилгээний албан хаагч
4. Төрийн захиргааны албан хаагч
5. Төрийн тусгай албан хаагч
6. Төрийн улс төрийн албан хаагч
7. ТӨҮГ/ОНӨҮГ-ын ажилтан

6) Тэтгэвэрт гарах үеийн нийгмийн даатгалд хамрагдалт:

1. Албан журмын
2. Сайн дурын

7) Тэтгэврийн төрөл:

1. Бүрэн
2. Хувь тэнцүүлсэн

8) Та сард хэдэн төгрөгийн тэтгэвэр авдаг вэ? (төгрөг) _____

Хоёр. Өрхийн гишүүдийн мэдээлэл

9) Өрхийн ам бүлийн тоог дараах ангиллаар бөглөж бичнэ үү. (Тус ангилалд хамаарах гишүүн байхгүй бол бөглөхгүй орших)

№	Ангилал	Тоо
1	Өрхийн ам бүлийн тоо	
2	Тэтгэврийн насны хүний тоо	
3	Тэтгэвэр авч байгаа хүний тоо	
4	Хөдөлмөрийн насны хүний тоо	
5	Тогтмол орлоготой хөдөлмөр эрхэлдэг хүний тоо	
6	Тогтмол бус орлоготой хөдөлмөр эрхэлдэг хүний тоо	
7	Оюутны тоо	
8	Сурагчийн тоо	
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	

Гурав. Өрхийн орлого

10) Өрхийн сарын дундаж орлого (бүх орлогыг нэмж гаргах): _____ төгрөг

11) Танай өрх орлогын ямар эх үүсвэртэй вэ? (Хэдэн ч хариулт дугуйлж болно)

1. Өндөр насны тэтгэвэр
2. Цалин
3. МАА, газар тариалангийн үйл ажиллагааны орлого
4. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого
5. Түрээс, хүүгийн орлого
6. Нийгмийн халамж
7. Бусдын дэмжлэг, тусламж
8. Бусад (бичих)

12) Танай өрхийн орлогын гол эх үүсвэр юу вэ? (Орлого бүрдүүлэлтэд хамгийн гол нөлөөтэй зөвхөн нэг эх үүсвэрийг сонгон дугуйлах)

1. Өндөр насны тэтгэвэр
2. Цалин
3. МАА, газар тариалангийн үйл ажиллагааны орлого
4. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого
5. Түрээс, хүүгийн орлого
6. Нийгмийн халамж
7. Бусдын дэмжлэг, тусламж
8. Бусад (бичих) _____

13) Танай өрх орлогоосоо сар бүр хуримтлал хийж чаддаг уу?

1. Тийм
2. Үгүй (Асуулт 14-д хариулахгүй)

14) Тийм бол сард дунджаар хэдэн төгрөг хуримтлуулдаг вэ? _____

Дөрөв. Өндөр насны тэтгэврийн зарцуулалт

15) Та өндөр насны тэтгэврээсээ сард дунджаар хэдэн төгрөгийг өөрийн хувийн хэрэгцээнд зарцуулдаг вэ? (Өрхийн гишүүдэд хамааралгүй зөвхөн танд хамааралтай зардлыг мөнгөн дүнгээр бичнэ)

№	Зардлын төрөл	Мөнгөн дүн
1.	Хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн	
2.	Хувцас, эд хэрэглэл	
3.	Эрүүл мэндийн зардал (Эм тариа, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн)	
4.	Тээврийн зардал (шатахуун, машины засвар үйлчилгээ)	
5.	Хувийн үйлчилгээ (үсчин, гоо сайхан гм)	
6.	Өөрийн чөлөөт цагт зориулсан зардал (бүжиг, тоглоом, спорт гм)	
7.	Бусад (бичих)	

16) Та өндөр насны тэтгэврийн орлогоосоо хэн нэгэнд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг үү?

1. Тийм
2. Үгүй (Асуулт 17-18-д хариулахгүй)

17) Тийм бол хэнд үзүүлэх?

1. Хүүхдүүд
2. Ач/зээ
3. Хамаатан садан
4. Бусад

18) Ямар давтамжтай тусламж дэмжлэг үзүүлдэг вэ?

1. Сар тутам
2. Хагас жил тутам
3. Жил тутам

19) Тэтгэврээс ач, зээдээ зарцуулдаг уу?

1. Тийм
2. Үгүй (Асуулт 20-д хариулахгүй)

20) Ямар давтамжтай вэ?

1. Сар тутам
2. Хагас жил тутам
3. Жил тутам

21) Таны тэтгэвэр дараах хэрэгцээний алинд нь илүү зарцуулагддаг вэ?

1. Өрхийн нийтлэг хэрэгцээнд
2. Хувийн/зөвхөн өөрийн хэрэгцээнд

22) Таны тэтгэвэр хувийн/өөрийн тань хэрэгцээнд хэр хүрэлцдэг вэ?

1. Хангалттай хүрэлцдэг
2. Тодорхой хэмжээнд хүрэлцдэг
3. Хүрэлцдэггүй

Тав. Өрхийн өр төлбөр

23) Танай өрх сүүлийн 3 жилд өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээл авсан уу?

1. Тийм
2. Үгүй *(Асуулт 24-29-д хариулахгүй)*

24) Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлийг хэнд зориулж авсан бэ?

1. Өөртөө
2. Хамт амьдардаг өрхийн гишүүдэд
3. Хамт амьдардаггүй хүүхэд, ач зээ
4. Бусад

25) Өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлийг юунд зарцуулсан бэ?

1. Эрүүл мэнд
2. Тавилга, эд хогшил
3. Тээврийн хэрэгсэл
4. Сургалт
5. Зээлийн төлбөр
6. Орон сууц худалдан авах/түрээслэх/засварлах үйл ажиллагаа
7. Бизнесийн үйл ажиллагаа
8. Цагаан сар
9. Бусад

26) Тэтгэвэр барьцаалсан зээл нь танай өрхийн нийтлэг хэрэглээнд нөлөөлсөн үү?

1. Нөлөөлөөгүй
2. Зарим худалдан авалтыг багасгасан
3. Зарим зүйлийг худалдан авах боломжгүйд хүргэсэн

27) Тэтгэвэр барьцаалсан зээл нь таны хувийн хэрэглээнд нөлөөлсөн үү?

1. Нөлөөлөөгүй
2. Зарим худалдан авалтыг багасгасан
3. Зарим зүйлийг худалдан авах боломжгүйд хүргэсэн

28) Тэтгэвэр барьцаалсан зээлээс хамааран сэтгэл санааны дарамтад орсон уу?

1. Тийм
2. Үгүй

29) Таны бодлоор өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлийг үр дүнтэй зарцуулж чадсан уу?

1. Тийм
2. Үгүй
3. Мэдэхгүй

Зургаа. Өндөр насны тэтгэврийн талаарх ойлголт, үнэлгээ

30) Та өндөр насны тэтгэврийн хэмжээндээ хэр сэтгэл хангалуун байдаг уу?

1. Маш их
2. Их
3. Дунд зэрэг
4. Бага
5. Огт сэтгэл ханамжгүй

31) Таны бодлоор өндөр насны тэтгэврийн хэмжээ нь ажилласан жил, төлсөн шимтгэлийн хэмжээтэй хэр нийцэж байна вэ?

1. Бүрэн нийцтэй
2. Зарим талаар нийцтэй
3. Нийцтэй бус

32) Өндөр насны тэтгэвэрт гарснаар танай өрхийн амьжиргаа хэрхэн өөрчлөгдсөн вэ?

1. Дээшилсэн
2. Хэвэндээ
3. Доошилсон

33) Өндөр насны тэтгэвэр нь танай өрхийн амьжиргаанд хэр нөлөөлж байгааг тодорхойлно уу? Яагаад? (хариултыг тодорхой бичих)

1. Голлох нөлөөтэй
2. Тодорхой хэмжээнд нөлөөтэй
3. Төдийлөн нөлөөгүй

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Судалгаанд идэвхтэй оролцож, үнэн зөв мэдээлэл өгсөнд баярлалаа. Эрүүл энхийг хүсье.

Хавсралт 2. Иргэнтэй хийх ярилцлагын удирдамж

Зорилго: Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг судалж, дүгнэлт, санал боловсруулах

Бэлтгэл ажил, анхаарах зүйл: Ярилцлагын удирдамж, дуу хураагуур, тэмдэглэлийн дэвтэр, үзэг зэрэг хэрэглэгдэхүүний бэлэн байдлыг ханган, ярилцлага зохион байгуулахад саад учруулахгүй орчныг бүрдүүлэхэд анхаарна.

Ярилцлагад оролцогчдод өгөх зааварчилга: Сайн дурын үндсэн дээр ярилцлагад оролцож байгааг сануулж, оролцогчдоос мэдээлэл өгөх, шаардлагатай бол бичлэгийг дуу хураагуурт бичих талаар зөвшөөрлийг нь авна. Судалгааны зорилго, үргэлжлэх хугацааг (30–45 минут) танилцуулан, гар утасны дууг хаах, ярилцлагыг тасалдуулахгүйн үүднээс ажлаа зохицуулахыг сануулна.

Мэдээллийн нууцлал, сайн дурын оролцооны баталгаажуулалт: Ярилцлагын мэдээллийг “Статистикийн тухай”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн дагуу судалгааны зорилгоор ашиглах, мэдээллийн нууцлалыг хамгаалах тухай танилцуулна. Судалгааны мэдээллийг нэгтгэж боловсруулсны дараа нэр дурдахгүй, тайланд тусгаж оруулах талаар тайлбар хийнэ.

Үндсэн мэдээлэл

1	Ярилцлага хийсэн он, сар, өдөр	
2	Ярилцлага хийсэн аймаг (нийслэл, сум) дүүрэг	
3	Ярилцлагад оролцогчийн нэр	
4	Ярилцлага хийсэн судлаачийн нэр	

Ярилцлагын чиглүүлэх асуулт

1. Танай өрхийн ам бүлийн тоо хэд вэ? Тэтгэврийн насны болон хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүй гишүүд хэд байна вэ?
2. Та хэдэн төгрөгийн тэтгэвэр авдаг вэ? Таны хувьд өндөр насны тэтгэврээр өөрийн хэрэгцээгээ хангах боломж бүрдсэн үү? (Хоол хүнс, хувцас, нийгмийн харилцаанд орох гэх мэт)
3. Та тэтгэврийн орлогоо юунд зарцуулдаг вэ? Таны тэтгэвэр таны өөрийн хувийн болон өрхийн нийтийн хэрэгцээний алинд нь түлхүү зарцуулагддаг вэ?

4. Өрхийн хэрэгцээнд шаардлагатай орлого дутагдах тохиолдол бий юу? (Эмчилгээ, сувилал, цагаан сар гэх мэт) Тийм бол хэрхэн нөхдөг вэ?
5. Та болон танай өрхийн тэтгэврийн насны хэн нэгэн тэтгэвэр барьцаалсан зээлтэй юу? Хэрэв тийм бол ямар шалтгаанаар авсан бэ? Зээлтэй байх хугацаанд ямар нэгэн хүндрэл гарсан уу? (хэрэглээ дутагдах, стресс нэмэгдэх, өрхийн гишүүдийн дунд зөрчил үүсэх гэх мэт)
6. Та хөдөлмөр эрхлэх хугацаандаа тэтгэвэрт гарсны дараа өөрийн болон өрхийн хэрэглээнд зарцуулах зорилгоор хуримтлал бий болгосон уу? Үүнд ямар хүчин зүйл голлон нөлөөлж байна вэ?
7. Таны тэтгэврийг хэр бодитой тогтоосон бэ? Өндөр насны тэтгэвэр тогтооход ямар хүчин зүйлийг анхаарах ёстой гэж боддог вэ?
8. Танд судалгаатай холбоотой (өндөр насны тэтгэвэр, өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөө: сэтгэл зүй, нийгмийн идэвх, оролцоо мэт) нэмж хэлэх зүйл байна уу?

Судалгаанд оролцож, мэдээлэл өгсөнд баярлалаа. Танд эрүүл энхийг хүсье.

Хавсралт 3. Мэргэжилтэнтэй хийх ярилцлагын удирдамж

Зорилго: Өрхийн эдийн өндөр насны тэтгэврийн засагт үзүүлэх нөлөөг судалж, дүгнэлт, санал боловсруулах

Бэлтгэл ажил, анхаарах зүйл: Ярилцлагын удирдамж, дуу хураагуур, тэмдэглэлийн дэвтэр, үзэг зэрэг хэрэглэгдэхүүний бэлэн байдлыг ханган, ярилцлага зохион байгуулахад саад учруулахгүй орчныг бүрдүүлэхэд анхаарна.

Ярилцлагад оролцогчдод өгөх зааварчилга: Сайн дурын үндсэн дээр ярилцлагад оролцож байгааг сануулж, оролцогчдоос мэдээлэл өгөх, шаардлагатай бол бичлэгийг дуу хураагуурт бичих талаар зөвшөөрлийг нь авна. Судалгааны зорилго, үргэлжлэх хугацааг (30–45 минут) танилцуулан, гар утасны дууг хаах, ярилцлагыг тасалдуулахгүйн үүднээс ажлаа зохицуулахыг сануулна.

Мэдээллийн нууцлал, сайн дурын оролцооны баталгаажуулалт: Ярилцлагын мэдээллийг “Статистикийн тухай”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн дагуу судалгааны зорилгоор ашиглах, мэдээллийн нууцлалыг хамгаалах тухай танилцуулна. Судалгааны мэдээллийг нэгтгэж боловсруулсны дараа нэр дурдахгүй, тайланд тусгаж оруулах талаар тайлбар хийнэ.

Үндсэн мэдээлэл

1	Ярилцлага хийсэн он, сар, өдөр	
2	Ярилцлага хийсэн газар	
3	Ярилцлагад оролцогчийн нэр	
4	Байгууллагын нэр, газар хэлтэс, нэгж, албан тушаал	
5	Тухайн салбарт ажилласан жил	
6	Ярилцлага хийсэн судлаачийн нэр	

Ярилцлагын чиглүүлэх асуулт

1. Өндөр насны тэтгэвэр нь ахмад настнуудын амьжиргаанд хэр хүрэлцээтэй байна вэ? Үүнд юу нөлөөлж байна вэ?
2. Өндөр насны тэтгэврийн хүрэлцээтэй байдалд хот, хөдөө, байршил, өрхийн ам бүлийн бүтэц, хүн ам зүйн шинжээс хамааран ямар нэгэн ялгаа ажиглагдаж байна уу? Тухайлбал ямар ялгаа ажиглагдаж байна вэ?

3. Өндөр насны тэтгэврийн талаар Монгол Улсын төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийн үр дүнг Та хэрхэн тодорхойлох вэ? Яагаад?
4. “Ахмад настны тухай хууль”-д “Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцын өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ” гэсэн заалт хэр үр дүнтэй хэрэгжиж байна вэ? Хэрэгжилтэд ямар хүчин зүйл нөлөөлж байна вэ?
5. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх эерэг нөлөөг дээшлүүлэхийн тулд бодлогын түвшинд юуг анхааран ажиллах хэрэгтэй вэ? (Тэтгэвэр тогтоох болон бодох аргачлал, тэтгэврийн төрөл, нэмэгдэл, хувийн тэтгэврийн даатгал, шимтгэлийн хэмжээ гэх мэт)
6. Өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлэх нөлөөг дээшлүүлэх чиглэлээр амжилт олсон сайн туршлагын талаарх мэдээлэл байвал хуваалцана уу?
7. Танд судалгаатай холбоотой (өндөр насны тэтгэвэр, өрхийн эдийн засаг дахь нөлөө, бодлого, эрх зүйн шинэчлэл гэх мэт) нэмж хэлэх зүйл байна уу?

Судалгаанд оролцож, мэдээлэл өгсөнд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье.

Хавсралт 4. Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо, хувь, аймаг, дүүргээр (2023 он)

Аймаг, дүүрэг	Хүн амын тоо	Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо	Эзлэх хувь
Нийт	3,396,788	382,755	11.3
Архангай	93,616	13,328	14.2
Баян-Өлгий	109,467	10,543	9.6
Баянхонгор	88,499	10,757	12.2
Булган	60,437	9,888	16.4
Говь- Алтай	57,328	7,530	13.1
Дорноговь	71,414	7,621	10.7
Дорнод	84,485	10,147	12.0
Дундговь	46,131	7,165	15.5
Завхан	71,796	10,214	14.2
Өвөрхангай	115,575	15,637	13.5
Өмнөговь	76,153	7,649	10.0
Сүхбаатар	65,995	7,768	11.8
Сэлэнгэ	105,830	14,144	13.4
Төв	91,786	14,116	15.4
Увс	84,976	10,405	12.2
Ховд	90,137	10,764	11.9
Хөвсгөл	136,885	17,640	12.9
Хэнтий	78,877	10,231	13.0
Дархан- Уул	103,239	13,224	12.8
Орхон	105,269	13,705	13.0
Говьсүмбэр	18,112	1,975	10.9
Улаанбаатар	1,640,781	158,304	9.6
Чингэлтэй	136,280	18,517	13.6
Сонгинохайрхан	341,390	32,217	9.4
Баянгол	252,979	25,229	10.0
Хан-Уул	258,187	19,937	7.7
Баянзүрх	436,822	35,924	8.2
Сүхбаатар	141,537	17,975	12.7
Багануур	28,926	3,979	13.8
Налайх	40,238	3,990	9.9
Багахангай	4,422	536	12.1

Эх сурвалж: НДЕГ-ын статистик мэдээ, 2024 он



Удирдлагын академи,
Удирдлагын академийн гудамж - 100
Стадион Оргил -3, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17012

Судалгаа, эрдэм шинжилгээний алба
Утас: 70132135
Цахим шуудан: researchcenter@naog.gov.mn
Цахим хаяг: www.naog.gov.mn